

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20.. оны ... дугаар сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ****1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, хяналт тавих, хэрэглээг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж

2.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Кадастрын зураглал ба кадастрын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Хаягжуулалтын тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Статистикийн тухай хууль, Авто замын тухай хууль, Харилцаа, холбооны тухай хууль, Иргэний хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд, энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа, түүнийг удирдах, зохион байгуулахад оролцогч төрийн ба төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэнд хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“орон зайн өгөгдлийн дэд бүтэц” гэж орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, ашиглах зорилгоор олон талын хамтын ажиллагааг удирдан зохион байгуулах бодлого, хууль тогтоомж, стандарт, техник, технологи, хүний нөөцийн цогцыг;

4.1.2.“орон зайн өгөгдөл” гэж газрын гадаргын дээр, доор, ус, агаарт, тодорхой орон зайд орших байгалийн ба хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байрлал, хил, түүний шинж чанарыг тодорхойлсон мэдээллийн цогцыг;

4.1.3.“мета-өгөгдөл” гэж орон зайн өгөгдлийг ангилах, хайх, бүртгэх, цэгцлэх, ашиглахад зориулагдсан, орон зайн өгөгдлийн шинж чанарын тухай мэдээллийг агуулсан өгөгдлийн багцыг;

4.1.4.“геопортал” гэж орон зайн өгөгдөлд хандах, хайх, засварлах, дүн шинжилгээ хийх боломж бүхий цахим үйлчилгээ үзүүлэх Интернэтэд суурилсан цахим системийг;

4.1.5.“геоплатформ” гэж геопорталаар дамжуулан орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх өгөгдлийн нэгдсэн сан, программ хангамж, техник хангамж, технологийн шийдлийн цогцыг;

4.1.6.“хандах эрх” гэж геоплатформд байгаа орон зайн өгөгдөлд хандахад эрх бүхий байгууллагаас төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд олгож буй нэвтрэх эрхийн зөвшөөрлийг;

4.1.7.“орон зайн өгөгдөл бүрдүүлэгч” гэж хуульд заасан чиг үүргийнхээ хүрээнд орон зайн өгөгдлийг бүрдүүлж, түгээж буй этгээдийг;

4.1.8.“техникийн баримт бичиг” гэж орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд ашиглагдах стандарт, норм, дүрэм, журам зэрэг баримт бичгийг.

5 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар баримтлах зарчим

5.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1.үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй үйл ажиллагаа явуулахгүй байх;

5.1.2.өгөгдөл үнэн зөв, оновчтой, нарийвчлал сайтай, үр ашигтай байх;

5.1.3.нууцын зэрэглэлд хамаарахаас бусад өгөгдөл ил тод байх;

5.1.4.өгөгдөл нэгдмэл, хүртээмжтэй, олон хэрэглэгч зэрэг ашиглах боломжтой байх;

5.1.5.байгаль орчин, экологи, нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн байх;

5.1.6.техник, технологийн дараа үеийн ололтод суурилсан байх;

5.1.7.төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих;

5.1.8.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд хүн, хуулийн этгээд эрх тэгш оролцох.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН АНГИЛАЛ, ТӨРӨЛ, ДҮРСЛЭЛ, ТЭДГЭЭРИЙН БҮРДЭЛ

6 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн ангилал, төрөл

6.1.Орон зайн өгөгдөл нь дараах ангилалтай байна.

6.1.1.орон зайн суурь өгөгдөл;

6.1.2.орон зайн сэдэвчилсэн өгөгдөл.

6.2.Орон зайн суурь өгөгдөлд дараах орон зайн өгөгдлүүд хамаарна.

6.2.1.геодезийн байнгын цэг тэмдэгтийн;

6.2.2.байр зүйн зургийн;

6.2.3.газар зүйн нэрийн;

6.2.4.газар ашиглалтын;

6.2.5.газрын бүрхэвчийн;

6.2.6.барилга байгууламжийн;

6.2.7.инженерийн дэд бүтцийн;

6.2.8.зам тээврийн сүлжээний;

6.2.9.инженер-геологийн;

- 6.2.10.кадастрын нэгж талбарын;
- 6.2.11.орто-зураглалын;
- 6.2.12.өндрийн;
- 6.2.13.түүх, соёл, археологийн өвийн;
- 6.2.14.ус зүйн;
- 6.2.15.хаягийн;
- 6.2.16.хил заагийн;
- 6.2.17.хөрсний;
- 6.2.18.хүн ам, нийгмийн.

6.3.Энэ хуулийн 6.2-т заасан орон зайн суурь өгөгдөл нь өгөгдлийн чанарын үзүүлэлт болон орон зайн суурь өгөгдлийн сангийн бүтэц, дүрслэл, шинж чанарын мэдээлэл, нэгдсэн загварчлалыг тодорхойлсон стандарттай байна.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасан стандартыг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонирхогч талуудтай зөвшилцлийн үндсэн дээр санаачлан боловсруулж, стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

6.5.Орон зайн суурь өгөгдөл нь энэ хуулийн 6.3-т заасан стандартад дурдсан мэдээллийг агуулна.

6.6.Орон зайн суурь өгөгдөлд үндэслэсэн, тодорхой сэдэв, агуулгын хүрээнд нарийвчлан боловсруулсан орон зайн өгөгдөл нь орон зайн сэдэвчилсэн өгөгдөлд хамаарна.

6.7.Орон зайн суурь өгөгдөл нь төрийн нууц болон хуулиар хамгаалагдсан бусад нууцыг агуулсан мэдээ, мэдээлэл, түүнчлэн нэвтрэх эрхийг хуулиар хязгаарласан бусад мэдээллийг агуулж болохгүй.

6.8.Орон зайн суурь болон сэдэвчилсэн өгөгдөл, тэдгээрийн агуулга, мета өгөгдөлд тавигдах шаардлагыг Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц, бусад баримт бичгийг хөтлөх журмын дагуу тогтооно.

7 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн мета-өгөгдөл

7.1.Орон зайн өгөгдлийн мета-өгөгдлийг түүний стандартын дагуу орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулахдаа хамт бүрдүүлнэ.

7.2.Орон зайн өгөгдлийн дор дурдсан мета-өгөгдөл нь нээлттэй байна.

- 7.2.1.солбицол, өндрийн тогтолцоо, тусгаг;
- 7.2.2.өгөгдлийн чанар;
- 7.2.3.өгөгдлийн төрөл;
- 7.2.4.орон зайн дүрслэл;
- 7.2.5.бүрдүүлсэн огноо;
- 7.2.6.өгөгдлийн шинэчлэлт;
- 7.2.7.хариуцагч этгээд;
- 7.2.8.хязгаарлалт.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

8 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа

8.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, ашиглах хамаарна.

8.2.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.

8.3.Орон зайн суурь өгөгдлийг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу геоплатформд төвлөрүүлж, геопорталаар дамжуулан түгээнэ.

9 дүгээр зүйл. Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх

9.1.Орон зайн суурь өгөгдөл нь солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд хийгдсэн байна.

9.2.Орон зайн суурь өгөгдлийг энэ хуулийн 6.3-т заасан стандартын дагуу дараах байгууллага бүрдүүлнэ:

9.2.1.энэ хуулийн 6.2.1, 6.2.2, 6.2.3, 6.2.11, 6.2.12-т заасан орон зайн суурь өгөгдлийг геодези, зураг зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага;

9.2.2.энэ хуулийн 6.2.4, 6.2.5, 6.2.10, 6.2.15, 6.2.16, 6.2.17-д заасан орон зайн суурь өгөгдлийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага;

9.2.3.энэ хуулийн 6.2.6, 6.2.7-д заасан орон зайн суурь өгөгдлийг барилга, хот байгуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага;

9.2.4.энэ хуулийн 6.2.7-д заасан орон зайн суурь өгөгдлийг зам, тээвэр, эрчим хүч, харилцаа, холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллага;

9.2.5.энэ хуулийн 6.2.8-д заасан орон зайн суурь өгөгдлийг авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага;

9.2.6.энэ хуулийн 6.2.9-д заасан орон зайн суурь өгөгдлийг газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон үндэсний геологийн алба;

9.2.7.энэ хуулийн 6.2.13-д заасан орон зайн суурь өгөгдлийг соёлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага;

9.2.8.энэ хуулийн 6.2.14-д заасан орон зайн суурь өгөгдлийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага;

9.2.9.энэ хуулийн 6.2.18-д заасан орон зайн суурь өгөгдлийг статистикийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага.

9.3.Орон зайн өгөгдлийн бүрдүүлэлт нь дараах аргад суурилна.

9.3.1.геодезийн хэмжилт, зураглал;

9.3.2.бүртгэл, тооллого;

9.3.3.шинжлэх ухаан, технологийн ололтод суурилсан бусад арга.

9.4.Орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг бүрдүүлэхэд, мэргэжлийн байгууллага тухайн захиалагчийн ажлын даалгаврын дагуу орон зайн суурь өгөгдлийн байрлал, өндрийн нарийвчлал, масштабыг өөрчлөхгүйгээр хийж гүйцэтгэнэ.

9.5.Энэ хуулийн 9.2-т заасан этгээд нь орон зайн суурь өгөгдлийн чанар болон үнэн зөв байдлын хариуцагч байна.

9.6.Орон зайн суурь болон сэдэвчилсэн өгөгдлийг тогтмол шинэчилдэг байх бөгөөд үүнийг журмаар зохицуулна.

10 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийг боловсруулах

10.1.Орон зайн өгөгдлийг боловсруулахдаа зориулалтын программ хангамж ашиглана.

10.2.Орон зайн өгөгдөлд машин сургалттай болон хиймэл оюуны аргуудыг ашиглан боловсруулалт хийж болно.

10.3.Орон зайн өгөгдлийн боловсруулалтыг Монгол улсад ашиглахаар батлагдсан солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэнэ.

10.4.Орон зайн өгөгдлийг боловсруулж гарсан өгөгдөл, мэдээлэл, түүний мета-өгөгдөл нь орон зайн суурь өгөгдлийн стандарттай ижил байна.

11 дүгээр зүйл. Орон зайн өгөгдлийг хадгалах, хамгаалах

11.1.Орон зайн өгөгдлийг гэмтэхгүй, алдагдахгүй, гадны халдлагад өртөхгүй, аюулгүй байх техникийн болон технологийн шийдлийг нэвтрүүлж хадгалж, хамгаална.

11.2.Орон зайн өгөгдлийн хадгалалт, хамгаалалтыг орон зайн өгөгдөл, мэдээ, мэдээллийг архивлах, хадгалах, хамгаалах журмын дагуу гүйцэтгэнэ.

11.3.Геоплатформд агуулагдаж буй орон зайн өгөгдөл нь төрийн өмч бөгөөд улсын бүртгэлийн мэдээллийн үндэс байна.

11.4.Орон зайн суурь өгөгдөл, мэдээллийн санг хадгалж буй программ хангамж, сүлжээ, техник хангамж бүхий дэд бүтэц төрийн хамгаалалтад байх ба түүний байрлал нь нууцад хамаарна.

11.5.Орон зайн өгөгдлийн санг устгах, гэмтээхээс сэргийлэхийн тулд тухайн санг хувилж, төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад хадгална.

11.6.Орон зайн өгөгдлийг хадгалах, хамгаалахад төвлөрсөн бус өгөгдлийн сангийн технологийн шийдлийг нэвтрүүлж болно.

11.7.Гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онц байдлын улмаас геоплатформ болон орон зайн суурь өгөгдөлд учрах эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөтэй байна.

12 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийг түгээх

12.1.Орон зайн суурь өгөгдлийг геопорталаар дамжуулан, хандах эрхээр зохицуулагдсан орчинд түгээж, солилцохоос гадна гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онц байдлын үед хэвлэмэл болон цахим хэлбэрээр солилцож болно.

12.2.Түгээх орон зайн суурь өгөгдөл нь дараах төрөлтэй байна:

12.2.1.нээлттэй;

12.2.2.хаалттай.

12.3.Энэ хуулийн 12.2.1-т заасан өгөгдөл нь төлбөртэй болон төлбөргүй байж болно.

12.4.Орон зайн суурь өгөгдөл нь зохиогчийн эрхтэй бол түүнийг түгээхээс өмнө эрх бүхий байгууллагад хандан, хуульд заасны дагуу баталгаажуулсан байна.

12.5.Төрийн байгууллага болон хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх

зорилгоор геопорталаас орон зайн өгөгдлийг харах, татан авч ашиглахад үйлчилгээний хураамж төлөхгүй.

12.6.Энэ хуулийн 12.5-т зааснаас бусад иргэн, хуулийн этгээд үйлчилгээний хураамж төлнө.

12.7. Орон зайн суурь өгөгдлийн төлбөрийг орон зайн өгөгдлийн төлбөрийн хувь, хэмжээг тооцох аргачлалаар тогтооно.

12.8.Төрийн болон албаны нууцад хамаарах орон зайн өгөгдлийг энэ хуулийн 12.2.2-т заасан төрлөөр түгээнэ.

12.9.Энэ хуулийн 12.1-т заасан хандах эрхийг нээх, хаах, өөрчлөх асуудлыг геопорталыг ажиллуулах журмаар зохицуулна.

12.10.Геопорталаар үзүүлсэн үйлчилгээнд улсын тэмдэгтийн хураамж төлнө.

12.11.Гамшиг, гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, онц байдлын үед холбогдох байгууллагыг орон зайн суурь өгөгдлөөр шуурхай хангана.

12.12.Үндэсний аюулгүй байдлыг хангахад зориулсан тусгай геоплатформд шаардлагатай орон зайн суурь өгөгдлийг түгээх үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийг ашиглах

13.1.Орон зайн өгөгдлийг ашиглахдаа геопорталд хандах эрхээр нэвтрэхээс гадна, шаардлагатай тохиолдолд хэвлэмэл болон цахим хэлбэрээр авч ашиглаж болно.

13.2.Геопорталд хандах эрхийн зохицуулалтыг энэ хуулийн 12.9-т заасан журмаар зохицуулна.

13.3.Орон зайн өгөгдөл, мета-өгөгдлийг ашиглахдаа түүний эх сурвалжийг дурдсан байна.

13.4.Гамшиг, гэнэтийн ослын үед иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гаргуулан авна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ, ХЯНАЛТ, САНХҮҮЖИЛТ

14 дүгээр зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн Зохицуулах хороо

14.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, хөгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах, нэгдсэн удирдлагаар хангах, нийгэм, эдийн засгийн салбар бүрт орон зайн өгөгдөл, мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх үүрэг бүхий орон тооны бус Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хороо /цаашид Зохицуулах хороо гэх/-той байна.

14.2.Зохицуулах хорооны дарга нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байна.

14.3.Зохицуулах хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 9 буюу түүнээс дээш хүний бүрэлдэхүүнтэй байна.

14.4.Зохицуулах хорооны гишүүнийг хорооны дарга томилж, чөлөөлнө.

14.5.Зохицуулах хорооны нарийн бичгийн дарга нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга байна.

14.6.Зохицуулах хорооны гишүүдэд энэ хуулийн 6.2-т заасан орон зайн суурь өгөгдлийг бүрдүүлэгч Засгийн газрын гишүүн болон төрийн захиргааны байгууллагын дарга нар байна.

14.7.Зохицуулах хороонд орон зайн өгөгдлийн дэд бүтэц, газарзүйн мэдээллийн системийн чиглэлээр мэргэшсэн мэргэжлийн өндөр мэдлэг, туршлагатай 2-оос доошгүй мэргэжилтэнг оруулна.

14.8.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Зохицуулах хорооны ажлын алба байна.

15 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хорооны чиг үүрэг

15.1.Зохицуулах хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.1.1.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

15.1.2.геоплатформын техникийн нөхцөл, ашиглалт, шаардлагыг тодорхойлсон журмыг батлах;

15.1.3.орон зайн өгөгдлийн төлбөрийн хувь, хэмжээг тооцох аргачлал, хэмжээг батлах;

15.1.4.орон зайн өгөгдлийн бүрдүүлэгчид болон салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагааг зохицуулах;

15.1.5.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэхтэй холбоотой хууль, тогтоомж, бодлого, стандарт, журмыг боловсруулах ажлыг зохион байгуулах;

15.1.6.хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, эдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

15.1.7.зохицуулах хорооны шийдвэрийн биелэлтийг хангуулах;

15.1.8.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн оролцогч талуудыг мэргэжлийн болон арга зүйн удирдлагаар хангах;

15.1.9.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр Төрийн захиргааны байгууллагын хийсэн ажлын жил бүрийн тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх;

15.1.10.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

15.2.Зохицуулах хорооны үйл ажиллагаа нь хурлын хэлбэртэй, шийдвэр нь тогтоол, тэмдэглэл, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

15.3.Зохицуулах хороо нь албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

16 дугаар зүйл. Засгийн газрын чиг үүрэг

16.1.Засгийн газар орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

16.1.1.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх, оновчтой ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор 4 жил тутамд бодлогын үндсэн төлөвлөгөө батлах;

16.1.2.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

16.1.3.зохицуулах хороог байгуулах, үйл ажиллагааны дүрмийг батлах;

16.1.4.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг зохицуулах журмыг батлах;

16.1.5.орон зайн нээлттэй өгөгдлийн жагсаалтыг батлах;

16.1.6.геопорталыг ажиллуулах журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.7.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр өндөр технологийг хөгжүүлэх, бодлогын судалгаа, шинжилгээний байгууллагыг байгуулах, дүрмийг батлах;

16.1.8.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх, тогтвортой үйл ажиллагааг хангахад шаардлагатай төсвийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

16.1.9.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах.

17 дугаар зүйл.Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, үүрэг

17.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

17.1.1.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг хөгжүүлэх бодлогын үндсэн төлөвлөгөөний дагуу орон зайн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр боловсруулах;

17.1.2.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах;

17.1.3.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхжуулах бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

17.1.4.энэ хуулийн 6.2-т заасан орон зайн суурь өгөгдлийг нэгтгэн, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэх;

17.1.5.геоплатформд төвлөрүүлсэн болон бусад эх үүсвэрт байгаа орон зайн өгөгдөл, мэдээллийг хадгалах, хамгаалах, түгээх, нууцлах;

17.1.6.орон зайн суурь болон сэдэвчилсэн өгөгдлийг шинэчлэх ажлыг зохион байгуулах;

17.1.7.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр инноваци, техник технологийг сайжруулах, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах бодлого боловсруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;

17.1.8.орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулахад салбар хоорондын уялдаа, хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулах;

17.1.9.геоплатформын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах;

17.1.10.хэрэглэгчдийг орон зайн өгөгдөл, мэдээллээр хангах;

17.1.11.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч талуудад мэргэжлийн болон арга зүйн туслалцаа үзүүлэх;

17.1.12.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн чиглэлээр хийсэн ажлын тайланг улсын хэмжээнд нэгтгэн Зохицуулах хороонд тайлагнах;

17.1.13.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой заавар, аргачлал боловсруулж, батлах;

17.1.14.орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих.

18 дугаар зүйл. Орон зайн өгөгдөл бүрдүүлэгч байгууллагын чиг үүрэг

18.1.Орон зайн өгөгдлийн бүрдүүлэгч байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

18.1.1.орон зайн суурь өгөгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шинэчлэн, үнэн зөв мэдээллийг бүрдүүлж, түүний чанар, нарийвчлалыг хариуцах;

18.1.2.орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бүрдүүлж, түүний чанар, нарийвчлалыг хариуцах;

18.1.3.орон зайн суурь өгөгдлийг дамжуулах, түгээх, ашиглах боломж нөхцөлөөр хангах;

18.1.4.орон зайн суурь өгөгдөл, түүнийг дамжуулахад хэвийн, найдвартай байдлыг хангах;

19 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын чиг үүрэг

19.1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаар аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, стандартыг хэрэгжүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

19.1.2.байгалийн гамшиг, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын үеийг даван туулах, хариу арга хэмжээг төлөвлөх, шийдвэр гаргах, зохион байгуулахад шаардлагатай орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэхэд орон нутгийн бусад байгууллагыг татан оролцуулах, ажиллах хүч, техник хэрэгслээр хангах, шаардлагатай зардлыг санхүүжүүлэх зэрэг бүх талын дэмжлэг, туслалцааг үзүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

БУСАД

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

20.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20.2.Орон зайн суурь өгөгдлийг хууль бусаар олж авах, ашиглах, өөрчлөн ашиглах замаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээдийн холбогдох үйл ажиллагааг зогсоож, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

20.3.Энэ хуулийн 20.1-д зааснаас бусад тохиолдолд иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

21 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

21.1.Энэ хуулийг 202.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

**ОРОН ЗАЙН ӨГӨГДЛИЙН ДЭД БҮТЦИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АЖЛЫН
ТАЙЛАН**

2021 он

АГУУЛГА

| | |
|---|----|
| 1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ | 3 |
| 2 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ | 4 |
| 2.1 Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал | 4 |
| 2.1.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал | 4 |
| 2.1.2 Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал | 6 |
| 2.1.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал | 8 |
| 2.1.4 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал | 9 |
| 2.1.5 “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал | 10 |
| 3 УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ | 13 |
| 3.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал..... | 13 |
| 3.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал..... | 14 |
| 3.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал..... | 17 |
| 3.4 Нийтээр хүлээн зөвшөөрөх нээлттэй орон зайн өгөгдлийн сангийн хэрэглээ | 24 |
| 3.4.1 Иргэдийн хэрэгцээ | 24 |
| 3.4.2 Хуулийн этгээдийн хэрэглээ | 24 |
| 3.5 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал | 24 |
| 3.6 “харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал..... | 28 |
| 4 ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ..... | 30 |

1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Хууль тогтоомжийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баталсан.

Энэхүү судалгааны зорилго нь Засгийн газраас баталсан аргачлалыг баримтлан Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу орон зайн мэдээллийн хуулийн төсөлд “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийх, нөгөө талаар хуулийн төсөл боловсруулагчид жишиг болохуйц гарын авлага боловсруулахад оршино.

Түүнчлэн энэхүү судалгаагаар “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай” хуулийн төслийн төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорилго.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар хийлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

2 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараахь 5 шалгуур үзүүлэлтийг сонгосон.

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал
4. Ойлгомжтой байдал

5. Харилцан уялдаа зэрэг шалгуур үзүүлэлтийг сонголоо. Ингэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулсан.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй бөгөөд ил тод, нээлттэй болгоход чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хамаарах этгээдүүдээс санал авах, хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

2.1 Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоосон байдал

2.1.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3.6-д “Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.” гэсэн зорилтыг дэвшүүлж, 2031-2040 онд үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформ бий болгон хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байх үр дүнд хүрэхээр заасан бөгөөд “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.6.16, 5.3.7-д “Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.”, “Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх түвшинд ашиглана.” гэж тус тус тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2-т “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын

нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно гэж заасан.

Мөн Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.7.1.3-т “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барина, 3.7.2.5-д “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ”, 3.7.3.5-д “Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно”, 3.7.3.6-д “Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ” гэж тус тус тусгагдсан.

Засгийн газрын 2008 оны 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Монгол Улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгоход мэдээлэл, холбооны технологийн давуу тал, ололтыг ашиглах үндэслэл нь тусгагдсантай нийцэж байна.

Мөн Монгол улсын засгийн газрын 2018 оны төрийн үйлчилгээг цахим болгох тухай 259 тоот тогтоолоор “Төрийн цахим мэдээлэл солилцох системийг ашиглан цахим хэлбэрээр үзүүлэх” төрийн үйлчилгээний жагсаалтаар энэ хуулийн төслийн 2 бүлгийн 6 дугаар зүйлд заасан бүх төрлийн цахим мэдээллийг зааж өгсөн байна. **Улсын бүртгэлийн тухай хуулиар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь асар их мэдээлэл агуулж байдаг учраас эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн баазын даац хэтрэх, хандах хэрэглэгчийн тоо нэмэгдсэнээс мэдээлэл боловсруулах процессын үйлдлүүд удаашрах зэрэг бэрхшээл гарч байна.**

Хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэл, төр, орон нутгийн захиргаа, газар олголт, ашигт малтмал, барилга, авто зам, хил хамгаалах зэрэг байгууллагын бүртгэл, мэдээллийн сангууд нь тусдаа хоорондоо хөрвөх боломжгүй, харилцан холбогдоогүй байгаа нь төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэхэд бэрхшээл учруулж, төр иргэн хоорондын харилцааг холдуулах, хүнд суртал газар авах, улмаар далд эдийн засаг, авлига бий зэрэг, эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Энэ хууль батлагдснаар Цахим засаглал, их өгөгдөлийн дүн шинжилгээ /анализ/ стратеги дээр суурилсан хөгжлийн бодлого төлөвлөлт, урьдчилан таамагласан бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд нэгдсэн бүртгэл, мэдээллийн бааз суурь дээр тулгуурласан төрийн нэгдмэл бодлого нэн чухал байна.

Монгол улсын Засгийн газрын дэд бүтцийн байгууллагууд мэдээллээ тус тусдаа бүрдүүлж, харилцан уялдаагүй мэдээлийн давхардал бий болгож, төрийн их өгөгдлийн үйлчилгээг платформоос үзүүлж, төрийн ой санамжийг бэхжүүлэх зорилгоор орон зайн мэдээлэлд тулгуурласан бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгохоор зорьсон байна.

“Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн зорилт нь тус хуулийн үзэл баримтлал” Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай” хуулийн төслийн зорилт 1.1 дэх заалтыг бүрэн утгаар нь илэрхийлсэн байна. “Орон зайн өгөгдөл” гэж газрын гадаргын дээрх, доорх, ус, агаар, сансрын орон зайд орших байгалийн болон хүний үйл ажиллагаагаар бүтээгдсэн биет юмс, үзэгдлийн байршил, хэмжээ, шинж чанарыг тодорхойлж буй өгөгдлийг, “орон зайн мэдээлэл” гэж орон зайн өгөгдлөөс шийдвэр гаргах зорилгоор боловсруулан гаргаж авсан мэдээллийг доорх байдлаар эрэмбэлэн тусгасан байна.

1/ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах;

2/ Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх хэрэглэх;

3/ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг удирдах, зохион байгуулах, хяналт тавих;

4/ Орон зайн өгөгдлийн ангилал, тэдгээр суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээр нийтэд үйлчлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.¹ Тухайлбал

- Үндэсний орон зайн өгөгдлийн геоплатформийг хөгжүүлэх;

¹ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас иш татав

- Орон зайд суурилсан төрийн бодлого шийдвэр геоплатформд суурилсан байх тогтолцоог бүрдүүлэх;
- Геопорталаар дамжуулан орон зайн нээлттэй өгөгдлөөр нийтэд үйлчлэх, бизнесийн орчинг дэмжих;
- Төрийн байгууллага бүрдүүлэх 18 нэр төрлийн суурь өгөгдлийг тодорхойлж, санхүүжилтийг шийдвэрлэх;
- Төр, хувийн хэвшлийн оролцоог хамтын ажиллагааг нэмэгдүүлж, төрийн ачааллыг бууруулах гэсэн үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалт тусгагдсан байна.

2.1.2 Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7.2-т “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно гэж заасан.

Засгийн газраас батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр, Монгол Улсад бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, хөгжиж байгаа орнуудад цахим засгийг хөгжүүлэх талаар Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмж, хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлснээр иржээ.

Монгол улсын засгийн газрын 2012 оны 101 тоот тогтоолоор цахим засаг үндэсний хөтөлбөрт 2.1.1. “Цахим засаг” (Electronic Government, E-Gov) гэж төрийн үйл ажиллагааг иргэдэд ил тод мэдээлэн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, тэдгээрийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаанд мэдээллийн технологи, харилцаа холбооны дэвшилтэт технологийг ашиглах замаар цахим үйлчилгээг тулгуур болгон улс орны дотоод, гадаад харилцаа, засаглалын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, 2.1.2. “Засгийн газрын энтерпрайз архитектур” (Government Enterprise Architecture) гэж цахим засгийг бий болгох үйл явцад чиглэгдсэн стандарт, харилцан уялдаа бүхий бизнес архитектур, мэдээллийн архитектур, шийдлийн архитектур, техник, технологийн архитектур зэргээс бүрдсэн үр ашигтай системийн шийдлийг хэрэгжүүлэх, 2.1.3. “Мэдээллийн технологийн дэд бүтэц” гэж мэдээллийн сүлжээ, техник (хатуу) болон программ хангамж, мэдээллийн сан, мэдээллийн системийн загвар (зөөлөн) бий болгосон, 2.1.4. “Хөдөлгөөнт холбоо” гэж утасгүй зөөврийн харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, таблет гэх мэт)-ийг ашиглан мэдээлэл солилцох, 2.1.5. “Үүлэн тооцоолол” гэж компьютер болон бусад төхөөрөмж нь программ хангамж, дундын өгөгдөл, мэдээллийг интернэтийн орчинд дамжуулан боловсруулдаг тооцооллыг Үндэсний Дата төв бий болгож чаджээ. Одоо ХУР, ДАН системээр дамжуулан практикт хэрэглэж байна.

1/ Орон зайн дэд бүтцийн системийн цахим хэлбэрээр бүртгэл хийх, цахимаар үзүүлэх үйлчилгээ;

2/ Төрийн болон Хуулийн этгээдийн мэдээлэл солилцох;

3/ иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ хүртээмж зөв эсэхийг тогтоох зэрэг зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцсон болно.

Мөн 2012 оны 4 дүгээр сарын 04 өдрийн 101 тоот тогтоолоор батласан цахим засаглал үндэсний хөтөлбөрт олон улсад энэхүү орон зайн өгөгдөлийн системийг газрын кадастер байр зүйн дээр суурилсан мэдээллийн системийг ашиглаж байгаа бөгөөд, цахим үйл ажиллагааг хуулиар процесс болон тусгасан байна. Олон салбарын мэдээллийг нэг хавтгайд цуглуулснаар манай улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, төслийн болон хөрөнгө оруулалтын давхардал арилж, шаардлагатай дэд бүтэц хөрөнгө оруулалтыг эдийн засгийн ашигтай байдлаар тодорхойлох боломжтой байна.

Энэ хуулийн төсөл нь зорилгодоо нийцэж байгаа болон практикт хэрэглэх боломжтойг эсэхийг сонгосон зүйл заалтуудыг хүснэгтээр үзүүлвэл

Хүснэгт 1 Практик хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

| № | Практикт хэрэгжих боломж | Сонгосон зүйл заал |
|---|---|--|
| 1 | Хуулийн төслийн цахимаар үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зүйл заалтууд | 5.1.5 инновацад суурилах; 5.2.1 орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч нь төрийн нууцад хамааруулсан мэдээллийг агуулж буй орон зайн өгөгдлөөс бусдыг дамжуулж ашиглах эрхээр хангах, |
| 2 | Төрийн болон Хуулийн этгээдийн мэдээлэл солилцох | 3.1 ... монгол улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн, тоон хэлбэр бүхий орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд хамаарна. 5.1.4-д заасан төр, хувийн хэвшлийн түншлэлийг дээшлүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: энэ хуулийн Error! Reference source not found. -д зааснаас бусад хувийн хэвшилтэй хамтран ажиллах тохиолдолд түүнийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр сонгох энэ хуулийн 5.5.2-т заасан үндэсний хувийн хэвшлийн хүний нөөцийг бэхжүүлэх, шинэ техник, технологиор хангах замаар дэмжих. |
| 3 | иргэд, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ хүртээмж | 14.1 орон зайн өгөгдлийг хэрэглэх гэдэгт тухайн өгөгдлийн үр өгөөжийг шууд ба шууд бус байдлаар хүртэх үйл ажиллагаа хамаарна. 14.2 Иргэн, хуулийн этгээд нь ашиг олох зорилгоор орон зайн өгөгдлийг хэрэглэхдээ энэ хуулийн .Т заасан журмыг баримтална. 14.4 Аливаа төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн орон зайд суурилсан бодлого, төлөвлөлт, шийдвэр, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь геоплатформоор дамжуулан түгээж буй орон зайн өгөгдөлд үндэслэсэн байна. 14.6 Суурь орон зайн өгөгдлийг хууль бусаар олж авах, ашиглах, өөрчлөн ашиглах замаар ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан иргэн, хуулийн этгээдийн холбогдох үйл ажиллагааг түүнийг бий болгоход гаргасан зардлыг нөхөн төлөхгүйгээр зогсооно. 14.7 Гамшиг, гэнэтийн осол болон онц байдлын үед төрөөс иргэн, хуулийн этгээдийн эзэмшилд байгаа орон зайн сэдэвчилсэн өгөгдлийг хуулийн дагуу гаргуулан авна. 14.8 Монгол улсын иргэн, хуулийн этгээдийн дараах шалгуурын 3 ба |

| | | |
|--|--|---|
| | | түүнээс дээш үзүүлэлтийг хангаж буй орон зайн өгөгдөлд суурилсан ухаалаг үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлж болно. |
|--|--|---|

Төсвийн болон олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр төлөвлөгдөж буй зам, гүүр барилга байгууламжийн газрын маргаан, дэд бүтцийн хүртээмж хязгаарлагдмал, засаг захиргааны нэгжид тулгуурласан хаягжилтын өнөөгийн байдал нь нэгдсэн стандарт, системгүй, ойлгомжгүй байгаа нь төрийн болон хувийн бизнесийн үйлчилгээний шаардлага хангахгүй байгааг энэ хуулиар зохицуулах боломжтой байна.

Хэд хэдэн төрийн байгууллага, орон нутгаас газар түүнийг ашиглах тусгай зөвшөөрөл олгодог тул хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эмх цэгцгүй газар олголтын байдал нь татвараас зайлсхийх, эрхийн бүртгэл давхардах, бизнесийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байдлыг арилгах боломжтой байна.

Хаягжилтийн тухай хуулиар үл хөдлөх хөрөнгө орон сууц, барилга байгууламжийн албан ёсны хаяг бүртгэлийн тогтолцоо бүрэн гүйцэд төгөлдөршөөгүй, төрийн байгууллага хоорондын мэдээлэл зөрүүтэй, аль мэдээлэл үнэн эсэх тодорхойгүй байна.

Энэ хууль батлагдсанаар эд хөрөнгийн эрхийн бүртгэл, төрийн захиргааны байгууллага, барилга хот төлөвлөлтийн бүртгэл, байгалийн баялагийн нөөцийн стратеги зам тээврийн хөрөнгө оруулалт, мэдээллийн сангууд хоорондоо хөрвөх боломжтой болж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүртээмжтэй болж, эдийн засгийн хөгжилд хэмнэлтэй бөгөөд ухаалаг төлөвлөлт болно гэж харж байна.

2.1.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төсөл нь төрийн олон байгууллагын мэдээллийн сангийн мэдээлэл, түүнд нэвтрэх эрхийн асуудал, мэдээллийн технологийн зохицуулалт агуулсан бөгөөд мэдээллийн аюулгүй байдлын нууц, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох шаардлагатай байна. Төрийн байгууллагуудын нь тус тусын хуулиар бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, түүнтэй холбогдох харилцааг 10 гаран хууль, 20 гаран засгийн газрын тогтоол, журмаар зохицуулсан байна. Уг хуулиар энэхүү харилцааг нарийвчлан зааж өгөх шаардлагатай байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар төрийн нэгдсэн дэд бүтцийн бүтээн байгуулалт, төлөвлөлт хувийн хэвшлийн үйл ажиллагаа давхцал, зах зээлийн либералчлал, өрсөлдөөнийг дэмжих бодлого салбар хоорондын үр ашиг, орлого, улсын эдийн засаг, нийгмийн бүх салбар, иргэдийн амьдралд мэдээлэл, харилцаа холбооны салбарын дэвшилтэт технологи нэвтэрч, өдөр тутмын хэрэгцээ, шаардлага, үйл ажиллагааных нь салшгүй хэсэг болсон байна. Монгол улсын засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 08 өдрийн 47 тоот тогтоол төрөөс мэдээлэл харилцаа холбооны баримтлах бодлогын баримт бичиг, Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэх чиглэлээр 1999-2016 онд “Мэдээлэл, холбооны технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал” (1999-2010), “Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги” (2002-2006), “Цахим Монгол” үндэсний хөтөлбөр (2005-2012), “Цахим засаг” үндэсний хөтөлбөр (2012-2016), “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2010-2015), “Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр” (2011-2015) зэрэг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг батлан үндсэнд нь амжилттай хэрэгжүүлсэн байна. Түүнчлэн цахим засаг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах бас нэгэн эрх зүйн акт болсон байна.

Засгийн газрын 2005 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Цахим Монгол" Үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт цахим бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгоход мэдээлэл, холбооны технологийн давуу тал, ололтыг ашиглах үндэслэл нь тусгагдсан байна.

Цахим засаглал, их өгөгдөлийн анализ стратеги дээр суурилсан хөгжлийн бодлого төлөвлөлт, урьдчилан харсан бодлого, стратеги боловсруулж хэрэгжүүлэхэд нэгдсэн бүртгэл, мэдээллийн бааз суурь дээр тулгуурласан төрийн нэгдмэл бодлого нэн чухал байна.

Төрийн үйлчилгээний байгууллагууд мэдээллээ тус тусдаа мэдээлийн сан бүрдүүлж, харилцан уялдаагүй мэдээллийн сангуудад хадгалж, үйлчилгээ үзүүлж байгаа явдлыг арилган, төрийн ой санамжийг бэхжүүлэх зорилгоор боловсруулсан байна.

Тус хуулийн 3.1 дэх хэсэгт Монгол Улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн, тоон хэлбэр бүхий орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагаанд оролцогч төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэнд хамаарна.

Мөн дараах хуулиудад заасан мэдээллийн сангийн нэгдмэл байдал болон олон зарчим хангасан байна

- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- Барилгын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Геодези, зураг зүйн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Улсын бүртгэлийн тухай ерөнхий хууль;
- Авто замын тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль.

2.1.4 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 3.6-д “Ухаалаг, иргэн төвтэй газрын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх замаар тэгш байдал, шударга ёс, үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангана.” гэсэн зорилтыг дэвшүүлж, 2031-2040 онд үндэсний орон зайн мэдээллийн нэгдсэн платформ бий болгон хөгжүүлж, хэрэглэж хэвшсэн байх үр дүнд хүрэхээр заасан бөгөөд “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 3.6.16, 5.3.7-д “Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлнэ.”, “Орон зайн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлж шийдвэр гаргах бүх төвшинд ашиглана.” гэж тус тус тусгагдсан гэж,

Мөн Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.7.1.3-т “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барина, 3.7.2.5-д “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ”, 3.7.3.5-д “Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно”, 3.7.3.6-д “Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ” гэж тус тус тусгагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/-ын баримт бичиг”-ийн 3.4.8-д “гео-орон зайн мэдээллийн дэд бүтцийг ашиглан төрийн байгууллага, иргэдэд үнэн зөв, нарийвчлалтай мэдээлэлд үндэслэсэн орон зайн дүн шинжилгээ, ухаалаг төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлнэ.”

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ын “3.Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого”-ын Байгалийн нөөц баялаг, дэд бүтцийн онцлогт тулгуурлан хүн амын нутагшилт, суурьшил, хот суурины оновчтой тогтолцоог бий болгож, иргэдийн аюулгүй ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх 8 дугаар зорилтын 8.3 “Орон зайн

өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх.”,

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 70 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс барилгын салбарын талаар баримтлах бодлого”-ын “2.2.8. барилгын салбарыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцэд тулгуурлан газрын харилцааны бодлого, төлөвлөлттэй уялдуулан хэрэгжүүлэх.” гэж тус тус заасны дагуу орон зайд суурилсан өгөгдөл мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх төвшний эрх зүйн харилцааг зохицуулснаар хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлт хангагдсан байна.

2.1.5 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” гэсэн шалгах хэрэгслээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг судлан, хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдаа уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2 Харилцан уялдааг үнэлсэн байдал

| № | Аргачлалд заасан асуулт | Хуулийн төслийг үнэлсэн байдал |
|---|--|--|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх | |
| 2 | Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх, | |
| 3 | Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх | Олон улсын нэр үг нэр томъёо болон Монгол улсын хэл шинжлэл, утга өгүүлбэр зүйд хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо салаа утга, давхар агуулгагүй тодорхойлж, тайлбар хийсэн байх бөгөөд энэ нь хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байна гэж үзсэн |
| 4 | Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх | 1 бүлэгт: Хуулийн зорилт, үйлчлэх хүрээг тодорхойлж, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, зарчмыг хэрэгжүүлэх арга, нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан. 2 бүлэгт: Орон зайн өгөгдлийг ангилал, дүрслэл, тэдгээрийн бүрдэл, түүнд хамаарах өгөгдлийн жагсаалтыг тодорхойлсон. Ингэхдээ суурь орон зайн өгөгдлийн бүрэлдэхүүн мэдээллүүдийг өнөөгийн нөхцөл байдал, олон улсын түвшинтэй харьцуулан гаргасан. Мөн өгөгдлийн тухай мэдээлэл буюу мета-дата бүрдлийн тухай, мэдээллийг ашиглах эрхийн төрлийг тусгасан. 3 бүлэгт: Өгөгдөл бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэхтэй холбогдсон техникийн зохицуулалт, тэдгээрт тавигдах шаардлагыг тодорхойлсон. Геоплатформыг бүрдүүлэгч, хэрэглэгч |

| | | |
|----|---|---|
| | | <p>талуудын хоорондох эрхзүйн харилцаа, орон зайн суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих эрх зүйн зохицуулалт, нээлттэй ба хаалттай өгөгдлийн зохистой харьцааг нарийвчлан тусгалаа.</p> <p>4 бүлэг: Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг улсын хэмжээнд хэрхэн удирдах, засгийн газрын дэргэд ажиллах зохицуулах хорооны эрх үүрэг, байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, хүлээх үүргийн талаар тусгасан. Мөн санхүүжилт, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын эрх зүйн орчныг тодорхойллоо.</p> <p>5 бүлэг: Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааг заасан.</p> |
| 5 | Хуулийн төслийн зүйл заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх | Хуулийн төслийн 6 дугаар зүйл бүхэлдээ нэр томъёог агуулсан. 8 дугаар зүйлийг тус хуулийн 14 дугаар зүйлтэй нэгтгэх, 7.2 дугаар заалт 11.3 давхардалтай. |
| 6 | Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх | Хуулийн төслөөр 4 дүгээр бүлэг 16 дүгээр зүйлээр хуулийн төслийг хэрэгжүүлэх байгууллагыг тодорхой тусгасан байна. |
| 7 | Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх | Энэ хуулийн төсөлд оролцогч талуудын эрх, үүрэг хандах эрхийн төвшин, үйл ажиллагааны процессыг нарийн тусгах шаардлагатай байна. Мөн төрийн байгууллагын эрх үүргийг хуулиар тодорхойлох шаардлагатай байна. Мөн хуулийн 16.7 заасан Хорооны дарга нь мэдээллийн технологийн болон бусад мэдээлэл бүрдүүлэгч салбарын хууль эрхзүйг мэддэг байх шаардлагатай байна. Зөвхөн орон зайн, газарзүйн мэдээллийн технологи мэддэг байх нь шаардлага хангахгүй байна. Удирдан зохион байгуулах чадвар шаардлагатай тул мэргэжилтний ажлын байрны заалт тавьсан нь дутмаг байна. |
| 8 | Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх | Тус хуулийн 6 дугаар зүйлд заасан санд бүрдүүлэх мэдээлийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг бусад төрийн байгууллагын чиг үүрэгт тусгасан байна. Үндэсний статистик хороо, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар эрх олгосон зарим байгууллагын зохицуулаагүй харилцааг давхардалгүй зохицуулах шаардлагатай байна. |
| 9 | Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх | Тус хуулийн төслийн 9 дүгээр заалт нь улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулинд заасан төлбөрийн хэмжээ тогтоогүй байна. |
| 10 | Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.16 дах хэсэгт 15.16.5 “Орон зайн |

| | | |
|----|---|---|
| | ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх | мэдээллийн контентийн үйлчилгээ” гэж нэмүүлэх |
| 11 | Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх | Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл заалт байхгүй. |
| 12 | Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх | Хуулийн төслөөр шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн, бий болгосон заалт байхгүй. |

3 УРЬДЧИЛАН СОНГОСОН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулья.

3.1 “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг хангалттай эсэх байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Монгол Улсад нэгдсэн мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, хөгжиж байгаа орнуудад цахим засгийг хөгжүүлэх талаар Дэлхийн банкнаас гаргасан зөвлөмж, судалгааг энэхүү хөтөлбөрийг боловсруулахад үндэслэл болгов. Хөтөлбөрийг боловсруулах явцад цахим засгийг хөгжүүлэн, амжилттай хэрэгжүүлж байгаа АНУ, ХБНГУ, БНСУ, Шинэ Зеланд Улс, Япон Улс, БНЭУ зэрэг орны туршлагыг судалсан болно.

Хуулийн төслийн хэрэгжүүлэх техник, технологийн боломж нь манай улсын 360 сум, суурин газар 41000 км орчим өндөр хурдны шилэн кабелийн сүлжээгээр холбогдсон бөгөөд бүх сум, суурин газрыг шилэн кабелиар бүрэн холбохоор ажиллаж байна. 2018 оны байдлаар гаргасан судалгаагаар төрийн байгууллага албан ажлын хэрэгцээнд нийт 100,000 гаруй компьютер ашиглаж байна. Засгийн газрын төрийн захиргааны төв байгууллагын хэмжээнд мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад 82 мянга орчим хүн ажиллаж, байгаа нь хангалттай үзүүлэлт юм. Мөн Орон зайн өгөгдлийн мэдээллийн технологийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн салбарын ажилтны мэргэжлийн ур чадварыг сайжруулах шаардлагатай байна. Цаашид төрийн байгууллагыг шилэн кабелийн сүлжээгээр холбосон нэгдсэн сүлжээ бий болгож, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, нэгдсэн бүртгэлтэй мэдээллийн систем, контентийг хөгжүүлэх, хүний нөөц, мэдээллийн технологийн менежментэд шинэчлэл хийх зэрэг арга хэмжээ авснаар цахим засгийн хөгжүүлэх энэ хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой байна. Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн түгээмэл хэрэглээ болсон хөдөлгөөнт холбоонд суурилсан цахим засгийн үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн бүр хэрэгцээтэй үйлчилгээг шууд гар дээрээсээ хүртэх бүрэн боломжтой байна.

Хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл төслийн үр нөлөөг үнэлэхдээ нийгэмд чиглэсэн үйлчлэл бүхий заалтыг сонгон үр нөлөөг судалсан.

Түүнчлэн хуулийн төсөл батлагдсанаар тодорхой зардал үүсгэж болохуйц, эсхүл тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой, мөн тодорхой субъектэд үүрэг хүлээлгэсэн, тодорхой байгууллагад шинээр чиг үүрэг хүлээлгэж байгаа, мөн тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор шинээр хэлтэс, нэгж, байгууллага бий болгох шаардлагатай эсэх зэргийг харгалзан үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон.

Ингээд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу авч үзье.

1. Хуулийн төсөл нь 1/ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах; 2/ Орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх хэрэглэх; 3/ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг удирдах, зохион байгуулах, хяналт тавих; 4/ Орон зайн өгөгдлийн ангилал, тэдгээр суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээр нийтэд үйлчлэхтэй холбогдон үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулах гэсэн зорилгодоо хүрсэн байна;

2. Хуулийн төсөлд тусгагдсан асуудлууд болох 1/ Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг удирдах хорооны үйл ажиллагаа; 2/ орон зайн өгөгдлийн ангилал, түүний мета-дата бүрдүүлэлт, ашиглалт 3/ Иргэн, хуулийн этгээдийн оролцоо, тэдгээрийг дэмжих бодлого; 4/

Суурь орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, түүгээр үйлчлэхэд хамаарах зохицуулалт нь практикт хэрэгжих боломжийг тодорхойлсон журам гаргах шаардлагатай байна.

3. Хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан байна. Жишээ нь өөрийн зохицуулалтай байгууллага буюу Харилцаа холбооны зохицуулах хороо, Эрчим хүчний зохицуулах хороо, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт өөрийн зохицуулалт шаардлагатай байгуулгатай дүйцүүлэх боломжтой юм. Гэхдээ тухайн хуулийг дагаж гарах журмыг хэн батлаж, мөрдүүлэх нь тодорхойгүй байна.

Хууль тогтоомжийн хууль болон захиргааны ерөнхий хуулинд хуулиар эрх олгосон субъектын эрхзүйн байдлыг тодорхойлж, дүрэм журам гаргах эрхийг нь дурдсан байна.

4. Хуулийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэх зэргийг тус тусад нь шалгасан.

Хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас хамгийн эхэнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Мөн хуулийн төслийн 10 дугаар зүйлд Орон зайн өгөгдлийг боловсруулах, дүн шинжилгээ хийх, хөгжлийн стратеги боловсруулах гэж нэмэх зүйтэй байна.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” хэмээн ерөнхий зорилгыг тодорхойлж өгсөн байна.

Ерөнхий зорилгоос авч үзэхэд орон зайн өгөгдлийг бүрдүүлэхээс эхлээд түүнийг хэрэглэх хүртэл бүх үе шатыг байгууллагаар бус оролцох хүрээгээр зааж Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтцийн оролцогчдыг бүрэн хамруулсан нь хуулийн төслийн зорилгод нийцсэн байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Улсын нутаг дэвсгэрийг дүрсэлсэн, тоон хэлбэр бүхий орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх гэдгийг тодорхойлсон байх бөгөөд хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1 Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.2. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.3. төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;

5.1.4. судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;

5.1.5. нөөц бололцоонд үндэслэсэн байх;

5.1.6. ил тод, нээлттэй байх;

5.1.7. олон нийтийн оролцоог хангасан байх гэсэн төрөл, хэлбэрээс үл хамааран, хуулийн үйлчлэл, зорилгод нийцсэн байна.

Мөн хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2-т Нууцад хамаарах орон зайн өгөгдлийг тусгайлсан хуулиар зохицуулахаар тусгасан нь нууцад хамаарах мэдээллийг хэрхэн ашиглах талаар зохицуулалтыг тодорхойгүй үлдээсэн байна. Энэ нь тусгай зориулалтын орон зайн өгөгдлийн хувьд энэ хуулийн зорилгод үл нийцэх заалт болсон байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-т орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд ил тод, хүртээмжтэй, нэгдмэл, тогтвортой хөгжилд чиглэсэн, түншлэлийг дэмжсэн, инновацийг нэвтрүүлэх зарчмыг тусгаж, 5.2-5.6 хэсгүүдэд энэ зарчмыг хэрхэн хэрэгжүүлэхийг нарийвчлан зохицуулсан нь хуулийн зорилгод нийцжээ.

3.2 “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Судалгааны багийн зүгээс “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо хуулийн төсөлд заасан 2 үе шатанд оролцогч субъектүүдийн дунд хэлэлцүүлэг хийх, суурь орон зайн өгөгдлийг бүрдүүлэгч байгууллагын тайлан, гаргасан зардал, гадаадын ижил төстэй бодлогын баримт бичиг, өгөгдөл бүрдүүлэх, түгээх явцад үүсч байсан процесс зэрэгт дүн шинжилгээ хийх замаар шалгасан.

Орон зайн өгөгдлийн хэрэглээ нь Өнөөдөр Монгол улсад орон зайн өгөгдлийн санг бүрдүүлэх, ашиглах асуудлыг зохицуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй 13 хуульд давхардсан тоогоор 44 мэдээллийн сан²-ийн талаар тодорхой зохицуулалт байгаа боловч сангуудын хоорондын уялдааг хангах, орон зайд дүрслэгдэх өгөгдөл, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, орон зайн өгөгдлийн нэгдмэл байдлыг хангахтай холбоотой эрх зүйн зохицуулалт байхгүй байна. Үүний улмаас орон зайн өгөгдлийн сан /газар зүйн мэдээллийн сан/-г яам, агентлаг, байгууллага, төслийн нэгж бүр өөрсдийн төвшинд, янз бүрийн аргаар байгуулсаар ирсэн байна. Жишээлбэл:

Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, Усны газар, Ойн газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа мэдээлэл, тооцооллын төв, байгаль хамгаалах олон улсын төслүүд /нэлээд олон төсөл бий/,

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, газар, олон улсын төслүүд,

Эрчим хүч, эрдэс баялгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, Ашигт малтмалын газар, Газрын тосны газар, мэдээллийн төв, Дэлхийн банкны төсөл,

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй яам, замын газар, тээврийн газар, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар /Үндэсний газрын мэдээллийн систем/, олон улсын төслүүд,

Нийслэлийн захирагчийн албаны холбогдох газар, албад /Барилга, хот байгуулалтын алба, Газрын алба г.м/ зэргээр энэ жагсаалт цааш үргэлжлэх юм.

Эдгээрийн уялдаа, холбоог хангахад нэгдсэн стандартын дагуу бүрдүүлж, ашигласнаар төсвийн давхардал, мэдээллийн шинэлэг, баталгаатай байдал хангагдах юм.

Дээр дурдсанаар практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтуудыг сонгон судалсан болно.

Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Орон зайн өгөгдлийн хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект нь тус хуулийн 16 дугаар зүйлд Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үндэсний хороо бөгөөд төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага байхаар зохицуулсан байна.

Мөн Хороо нь өдөр дутмын ажлыг уялдуулан зохион байгуулах ажлын албатай байна. Ажлын албаны чиг үүргийг орон зайн өгөгдлийн түгээх асуудлыг хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэх ба Хорооны нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна гэж заасан боловч бүтэц орон тоо, харилцан хамааралтай бусад орон зайн сан бүрдүүлэгч бүртгэлийн байгууллагын тогтолцоо тодорхойлох шаардлагатай байна.

Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэхийг хүснэгтээр үзүүлэв.

| № | Асуулт | Хариулт буюу дүн шинжилгээ |
|---|---|---|
| 1 | Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх; | 1.1 орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, орон зайн өгөгдлийг бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах, хяналт тавих, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулах. |
| 2 | Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх; | 2.1 Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Харилцаа, холбооны тухай хууль, Иргэний хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль иргэний хуулийн зохицуулалт хасах, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль, улсын бүртгэлийн ерөнхий хууль нэмэх саналтай |

² Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг боловсруулах, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангаас

| | | |
|----|--|--|
| 3 | хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх; | Олон улсын нэр үг нэр томьёо болон Монгол улсын хэл шинжлэл, утга өгүүлбэр зүйд хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томьёог тодорхойлж, тайлбар хийсэн байх бөгөөд энэ нь хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байна гэж үзсэн |
| 4 | хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх; | Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл Хоёрдугаар бүлэг. Орон зайн өгөгдлийн төрөл, дүрслэл, тэдгээрийн бүрдэл Гуравдугаар бүлэг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа Дөрөвдүгээр бүлэг. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт Тавдугаар бүлэг. Бусад давхардалгүй |
| 5 | хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх | |
| 6 | хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх; | 16 дугаар зүйл. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн зохицуулах хороо |
| 7 | хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх; | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх; |
| 8 | хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх | Бусад төрийн байгууллагын чиг үүргийн мэдээлийн нэгтгэлийг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан өгөгдөл нь дараах мэдээллийг агуулсан байна. |
| 9 | төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх; | 17 дугаар зүйл. үйлчилгээ эрхлэх байгууллага, аж ахуйн нэгжийн үүрэг бүхий .-д ... эзэмшигчээс орон зайн өгөгдлийг өөрчлөх, нэмэх, устгах, вектор хэлбэрээр хадгалах эрхийг хэрэглэгчид олгосон үйлчилгээ хамаарна. |
| 10 | татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх; | 8.1 Орон зайн өгөгдөлд хандах эрхийн төвшин нь дараах ангилалтай байна 16.9.6 энэ хуульд заасан журмын дагуу үйлчилгээний хураамжийн хувь хэмжээг тогтоох |
| 11 | тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх; | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.16 дахь хэсэгт 15.16.5 “орон зайн мэдээллийн контентийн үйлчилгээ” гэж нэмэх |
| 12 | Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх; | Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулга тусгагдаагүй. |
| 13 | хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх; | Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй. |
| 14 | хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөл нь шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй. |
| 15 | хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх; | Хуулийн төсөл нь авлига, хүнд бий болгоход чиглэсэн зохицуулалт тусгагдаагүй. |

| | | |
|----|---|---|
| 16 | хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх | Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай “12.13 дугаар зүйл.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль зөрчих 1.Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албан тушаалтныг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, байгууллагыг тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн 14.4 заасныг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг барагдуулж, хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. |
|----|---|---|

3.3 “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөлд санал авахаар Засгийн газрын бүх гишүүд /бүх яамд/, төрийн бус байгууллагад санал авах тухай албан бичгийг хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөл, түүний хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгааны тайлангийн хамтаар хавсарган хүргүүлж, саналыг хэлэлцэв.

Дээрх байгууллагуудаас ирүүлсэн саналуудаас хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд өгсөн саналыг нэгтгэн судлаад санал өгсөн байгууллагуудын тухайд ойлгомжгүй байгаа зохицуулалтуудыг дараах байдлаар тогтоолоо.

Мөн Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 3.7.1.3-т “Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль”-ийн төслийг боловсруулж УИХ-д өргөн барина, 3.7.2.5-д “Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ”, 3.7.3.5-д “Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно”, 3.7.3.6-д “Геопорталаар дамжуулан төрийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтын “Нэг газрын зураг”, иргэд, олон нийт, бизнесийн зориулалттай “Нээлттэй газрын зураг” цахим үйлчилгээг улсын хэмжээнд нэвтрүүлнэ” гэж тус тус тусгагдсан.

Цахим мэдээллийн сангийн Төрийн байгууллагуудын хууль, журмаар эрх олгосон 6 дугаар зүйлийн мэдээллийн агуулгатай хамааралтай хуулийн тандан судалгааг дараах хүснэгтээс харна уу.

| № | хууль | журам | тогтоол, дугаар |
|---|---|---|---|
| 1 | байгаль орчныг ... https://www.legalinfo.mn/additional/details/1793?lawid=8935 байгаль орчны мэдээллийн сан. 33 дугаар зүйл. мэдээллийн сангийн хэлбэр. 1. мэдээллийн санг цахим хэлбэрээр бүрдүүлнэ. 2. мэдээллийн ... | Төрийн байгууллагаас төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам https://www.legalinfo.mn/law/details/14451?lawid=14451 | засгийн газрын 2019 оны 220 дүгээр тогтоолын хавсралт |
| 2 | кадастрын зураглал ба газрын кадастрын тухай | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам https://www.legalinfo.mn/law/details/13955 | хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн |

| | | | |
|---|---|---|--|
| | https://www.legalinfo.mn/law/details/308 кадастрын зураглалын мэдээллийн сан” гэж бүх төрлийн кадастрын зураг, орон зайн өгөгдлүүдийг цэгцлэн иж бүрдэл болгосон мэдээллүүд, тэдгээрийг .. | ?lawid=13955 журам батлах тухай /мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх/. | үйлдвэрийн сайдын 2019 оны а-09 дугаар тушаалын хавсралт |
| 3 | Улсын бүртгэлийн ерөнхий хууль /шинэчилсэн найруулга https://www.legalinfo.mn/law/details/13537 улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан” гэж нэгдсэн ангилал, код, индекс, арга зүй, стандарт, баримт бичгийн шаардлага болон хуульд заасны дагуу | Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх https://www.legalinfo.mn/annex/details/6415?lawid=10449 | Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн а-86 дугаар тушаалын хавсралт |
| 4 | иргэний улсын бүртгэлийн тухай /шинэчилсэн найруулга https://www.legalinfo.mn/law/details/13540 иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан” гэж улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 6.1-д заасан иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримт бичиг ... | /малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай/ . https://www.legalinfo.mn/law/details/8178 малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай журмыг 1 дүгээр хавсралтаар, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн бүтцийг 2 дугаар ... | 2011 оны 5 дугаар дугаар а/74 |
| 5 | байгаль орчныг хамгаалах тухай https://www.legalinfo.mn/law/details/8935 9/“байгаль орчны мэдээллийн сан” /цаашид “мэдээллийн сан” гэх/ гэж байгаль орчны өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх, цуглуулах, дамжуулах, ... | Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай https://www.legalinfo.mn/law/details/13538 1 дүгээр зүйл. улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөхөөс өмнө төрийн цахим мэдээллийн сан /цаашид “үндэсний дата төв” гэх/-д газрын ... | |
| 6 | мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай www.legalinfo.mn/law/details/374 мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомж 22.1.2.мэдээллийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх, түгээх, ... | журам батлах тухай /улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх ... https://www.legalinfo.mn/law/details/10449 усны тухай хуулийн 7.2 дахь хэсэгт заасныг үндэслэн тушаах нь: 1.улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам-ыг хавсралт ёсоор ... | |

| | | | |
|----|---|---|---|
| 7 | ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга https://www.legalinfo.mn/law/details/12458 6.1.7.гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх. Хэвлэх . | ойн мэдээллийн сангийн бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг ... https://www.legalinfo.mn/annex/details/6053?lawid=9515 ойн мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/ гэж ойн тухай хуулийн 6.1-д заасан ойн сангийн эзлэх талбай, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, ... | |
| 8 | ОЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга https://www.legalinfo.mn/law/details/12171 ойн сан" гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор 13.1.9. улсын ойн мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэрэгжилтэд хяналт тавих,. | сум, аймаг, нийслэлд байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх ... https://www.legalinfo.mn/annex/details/4336?lawid=7917 сум, аймаг, нийслэлийн байгаль орчны мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх / тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрийн газар, газрын ... | |
| 9 | | өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах www.legalinfo.mn/annex/details/6620?lawid=10835 өрхийн мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн сан" гэх) нь үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн ... | Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоол |
| 10 | | хог хаягдлын мэдээллийн санг бүрдүүлэх ... https://www.legalinfo.mn/annex/details/6386?lawid=10401 энэхүү журмын зорилго нь хог хаягдлын мэдээллийн сан /цаашид "мэдээллийн сан" гэх/-гийн үзүүлэлтийг тогтоох, бүрдүүлэх, нэгтгэн боловсруулах, ... | Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны 04 дугаар сарын 09-ны а-115 дугаар тушаалын хавсралт |
| 11 | | төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан ... https://www.legalinfo.mn/annex/details/8028?lawid=12885 төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (цаашид "мэдээллийн сан" гэх) байгуулах, ашиглах, түүний нууцлал, аюулгүй байдлыг ... | Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт |
| 12 | | Усны мэдээллийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх ... https://www.legalinfo.mn/annex/details/4268?lawid=7944 усны мэдээллийн сан нь байгаль орчны улсын мэдээллийн төв сангийн дэд сан байж, мэдээллийн бүрдүүлэх, дамжуулах үйл ажиллагааг "сум, аймаг, .. | |
| 13 | | Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн санг ашиглах журам | Засгийн газрын 2017 |

| | | | |
|----|--|---|--|
| | | https://www.legalinfo.mn/annex/details/5900?lawid=9260 цахим мэдээлэл солилцох систем нь төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад бүрдсэн цахим бүртгэл, мэдээллийн сан, нэгдсэн сан ... | ны 159 дүгээр тогтоол хүчингүй болсон |
| 14 | | Өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх https://www.legalinfo.mn/annex/details/6943?lawid=11418 өрийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, | Сангийн сайдын 2015 оны 11 сарын 02-ны өдрийн 300 15дугаар тушаал |
| 15 | | Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх https://legalinfo.mn/annex/details/9091?lawid=13955 энэхүү журмын зорилго нь мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сан /цаашид "бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"гэх/-г бүрдүүлэх, ... | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2019 оны А-09 дугаар тушаалын хавсралт |
| 16 | | Архивын баримтад улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам https://www.legalinfo.mn/annex/details/8590?lawid=13565 архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаанд архивын тухай хууль, зөрчлийн тухай хууль, ... | Архивын ерөнхий газрын даргын 2018 оны 07 сарын 05-ны өдрийн А/97 дугаар тушаалын хавсралт |
| 17 | | Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны https://www.legalinfo.mn/annex/details/7643?lawid=12524 цахим мэдээллийн санг иргэн, хуулийн этгээдийн хөдлөх эд хөрөнгө болон цахим мэдээллийн сан нь бүртгэгдсэн барьцааны мэдэгдлийн талаар ... | Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/50 дугаар тушаалын хавсралт |
| 18 | | Үндэсний соёлын өвийг бүртгэн баримтжуулах 2 дахь шатны ... https://www.legalinfo.mn/annex/details/6444?lawid=10507 хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйгээр хангах ажлыг соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан хариуцан зохион байгуулна. 6.3. | Засгийн газрын 2014 оны 215 дугаар тогтоолын хавсралт |
| 19 | | Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ... https://www.legalinfo.mn/annex/details/2078?lawid=4675 үүнтэй холбоотойгоор мэдээллийн технологи асар их хөгжсөн эрин үед төрийн архивын нэг үндсэн үүрэг нь санхөмрөгтөө хадгалагдаж буй түүхэн ... | Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсрал |

| | | | |
|----|--|--|---|
| 20 | | Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо https://www.legalinfo.mn/annex/details/8775?lawid=13765 энэхүү журмын зорилго нь хог хаягдлын менежментийн мэдээллийг бүрдүүлэх, мэдээллээр хангах хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сан (цаашид ... | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн а/428 дугаар тушаалын хавсралт |
| 21 | | монгол улсад бүртгэлмэдээллийн нэгдсэн https://www.legalinfo.mn/annex/details/2317?lawid=3230 хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бүртгэлийн нэгдсэн тогтолцооны шинэ эрх зүйн орчин, мэдээллийн сан, техник технологийн дэд бүтцийг бүрдүүлж, хүн ... | Засгийн газрын 2008 оны 78 дугаар |
| 22 | | гадаадын зээл, тусламжийн бүртгэл, мэдээллийн ... https://www.legalinfo.mn/annex/details/5215?lawid=8094 гадаадын зээл, тусламжийн нэгдсэн мэдээллийн санг /цаашид "нэгдсэн мэдээллийн сан" гэх/ зээл, тусламжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны ... | Сангийн сайдын 2006 оны 447 дугаар тушаалын хавсрал /сс-ын 2017 оны 13-р тушаалаар хүчингүй болсон/ |
| 23 | | авто зам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар https://www.legalinfo.mn/annex/details/7262?lawid=11870 журмын 3 дугаар хавсралт. авто зам, замын байгууламжийн бүртгэлийг хөтлөх, бүртгэл-мэдээллийнцахим сан байгуулах журам. | 2016 оны 2 дугаар сарын 18-ны өдөр |
| 24 | | мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам https://www.legalinfo.mn/annex/details/6103?lawid=9623 "мэдээллийн сан" гэж энэхүү журмаар зохицуулагдах хуульд заасан мэдээллийн нэгдсэн ангилал код, индекс, арга зүй, стандартаар ижилтгэсэн баримт ... | Засгийн газрын 2013 оны 411 дүгээр |
| 25 | | геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ... https://www.legalinfo.mn/annex/details/8250?lawid=13183 энэхүү журмын зорилго нь геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн сан /цаашид "геомэдээллийн сан" гэх/-г бүрдүүлэх, боловсруулах, ашиглах, .. | Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн |

| | | | |
|----|--|--|---|
| | | | а/19 дугаар тушаалын хавсралт |
| 26 | | Мэдээллийн нэгдсэн сан байгуулах тухай https://www.legalinfo.mn/law/details/9297 "засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, зохицуулах журам"-ыг 1 дүгээр хавсралт ёсоор, "мэдээллийн санд төвлөрүүлэх мэдээлэл, тэдгээрийг гаргах байгууллагын жагсаалт" | 2013 оны 6 дугаар сарын 214 |
| 27 | | Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших ... https://www.legalinfo.mn/annex/details/8761?lawid=13744 сум, хорооны улсын бүртгэгч иргэний байнга оршин суугаа газрын хаягийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь хаягийн бүртгэлээр ... | засгийн газрын 2018 оны 332 дугаар тогтоолын хавсралт |
| 28 | | Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулан хадгалах хөтөлбөр | засгийн газрын 2005 оны 244 дүгээр тогтоолын хавсралт |
| 29 | | Засгийн газрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах, зохицуулах журам | засгийн газрын 2013 оны 214 дүгээр тогтоолын хавсралт |
| 30 | | Монгол орны гео мэдээллийн сан бүрдүүлэх .https://www.legalinfo.mn/annex/showprint/1389 геологийн судалгааны болон ашигт малтмалын мэдээллийн сан байгуулах ажлын эхлэлийг 1993-1994 онд нүб-ын төслийн шугамаар гүйцэтгэсэн юм. | засгийн газрын 2001 оны 183 дугаар тогтоолын хавсралт |
| 31 | | Мал бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай https://www.legalinfo.mn/annex/details/5511?lawid=8178 хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын. 2011 оны а/74 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт. малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн ... | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2011 оны А/74 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт |
| 32 | | Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох https://www.legalinfo.mn/annex/details/7280?lawid=11902 Авто үйлчилгээний мэдээллийн сан" гэж "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.-д заасан Замын хөдөлгөөний ... | Зам, тээврийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт |

| | | | |
|----|--|---|---|
| 33 | | Монгол улсад бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ... https://www.legalinfo.mn/annex/details/2319?lawid=3230 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын одоо ашиглагдаж байгаа мэдээллийн санг шинээр суурилуулах, мэдээллийн сан руу хөрвүүлэх бэлтгэл ... | Засгийн газрын 2008 оны 78 дугаар |
| 34 | | Цөлжилттэй тэмцэх хөтөлбөр https://www.legalinfo.mn/annex/details/2653?lawid=5560 Цөлжилтийн үндэсний нэгдсэн мэдээллийн сантай болно. ... цөлжилт, газрын доройтлын хяналт-шинжилгээний нэгдсэн мэдээллийн сан бий болгох; | Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 90 дүгээр тогтоол |
| 35 | | Органик хүнсийг бүртгэх,нийтийн хэрэгцээнд гаргах https://www.legalinfo.mn/annex/details/8751?lawid=13739 Хоёр.Органик хүнсний бүртгэл, мэдээллийн сан. 2.1.Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Цаашид “яам” гэх) нь | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2018 оны 10 дүгээр сарын 25-ны өдр А-180 дугаар тушаалын хавсралт |
| 36 | | “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам | 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 74 |
| 37 | | Байгалийн ургамлын тухай https://www.legalinfo.mn/law/details/76 Ургамлын нөөцийн мэдээллийн сан дараахь үзүүлэлтээс бүрдэнэ: ... Ургамлын мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг ... | |
| 38 | | Үндэсний архивын газар https://www.legalinfo.mn/law/details/13565 Үндэсний архивын сан хөмрөгийн баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, ... нэгтгэх, архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээллийн сан ... | |
| 39 | | Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд ... https://www.legalinfo.mn/annex/details/6378?lawid=10391 1.2.2 “Системийн хэрэглэгчид” гэж системд нэвтрэх эрх бүхий төв төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, аймаг, нийслэл ... | Сангийн сайдын 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 95 тоот тушаалын хавсралт |
| 40 | | Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох https://www.legalinfo.mn/annex/details/9190?lawid=14005 ... бүртгэл хөтлөх, улсын | Монгол Улсын Шадар сайд, Зам, |

| | | | |
|----|--|---|---|
| | | дугаар олгох, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 1.2. | тээврийн хөгжлийн сайдын 2018оны 192 дугаар тушаалын хавсралт |
| 41 | | төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн ... https://www.legalinfo.mn/annex/details/7633?lawid=12496 1.2.1.5. бүх нийтийн үйлчилгээний сан байгуулах эрх зүйн орчин бүрдсэн; 3.9.4. төрийн цахим ой санамж болох мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн ... | Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолын хавсралт |
| 42 | | тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр https://www.legalinfo.mn/annex/details/3191?lawid=7015 ... бололцоог ашиглан тусгай хамгаалалттай газар нутгийн сан байгуулж ажиллана. ... сүлжээг улсын хэмжээнд байгуулж, мэдээллийн сан бүрдүүлнэ;. | Улсын Их Хурлын 1998 оны 29 дүгээр тогтоолын хавсралт |

3.4 Нийтээр хүлээн зөвшөөрөх нээлттэй орон зайн өгөгдлийн сангийн хэрэглээ

3.4.1 Иргэдийн хэрэгцээ

Хот орон нутгийн хүн амын өсөлтийг хэрхэн төлөвлөж шийдвэрлэх вэ? Сургууль, цэцэрлэг, ясли, дэлгүүр, автобусны буудалд ойрхон, үйлдвэрийн утаанаас зайтай байр, хашаа хаана байна вэ?, Ард Аюушийн 10-р гудамж хаанаас эхлээд хаана дуусдаг юм бол? Багахангай дүүрэг хаана байдаг вэ?, аль аймгийн ямар сумтай хиллэдэг юм бэ? гэх мэт асуултын хариуг иргэн хүн өөрийн ая тухтай орчинд амьдрах, сурч боловсрох, мэдээлэл олж авах үндсэн эрхийнхээ хүрээнд төрийн үйлчилгээгээр дамжуулан авах хүсэлтэй байдаг боловч төр шинэлэг, баталгаат мэдээллээр хангах боломж хомс байдаг. Үүний улмаас иргэд нэгнээсээ асуух, интернетээс хайх, Google Earth, Openstreetmap газрын зураг гэх мэт тодорхойгүй, гаднын эх сурвалжаас мэдээлэл авч байна.

3.4.2 Хуулийн этгээдийн хэрэглээ

Ашигт малтмал, газар тариалан, хөдөө аж ахуй, барилга, зам дэд бүтцийн бүтээн байгуулалтын байгаль орчны үнэлгээ агаарын бохирдол юунаас болж байна вэ?, Хэдэн гол, мөрөн, нуур, ургамал амьтаны хэдэн хувь нь устаж үгүй болох сөрөг нөлөөтэй эсэхийг урьдчилан тооцох боломжтой.

Мөн технологийн компаниуд болон гарааны бизнес эрхлэгчид ухаалаг хотыг тодорхойлогч нэг хүчин зүйл нь аюулгүй, түгжрэлгүй, эдийн засгийн хэмнэлттэй замчлах системийн хэрэглээ буюу байрлалд суурилсан замчлах систем /roadmap/ хөгжүүлэх боломжтой болно. Манай улсын хот суурин газруудын суурь орон зайн өгөгдлийн баталгаатай, нээлттэй байдал хангалтгүй байгаагаас дэлхийн байрлал тодорхойлох тогтолцоо (GPS)-ны болон авто замын навигацийн, байрлалд суурилсан төрөл бүрийн хайлтын, онлайн бүтээгдэхүүн үйлчилгээ /автомашинны газрын зураг, бараа, бэлэн хоол хүргэлтийн үйлчилгээ, шуудан /-ний хязгаарлагдмал, ухаалаг хотыг дэмжсэн бизнесийн орчин бүрдэхгүй байгаа нь энэхүү хуулийн төслийн хэрэгцээ ойлгомжтой байдлыг илэрхийлсэн байна.

3.5 “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд судалгаа хийхэд тухайн хуулийн төсөлд тодорхой этгээдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж байгууллагад

ачаалал, хүндрэл үүсгэх, эсхүл төрийн байгууллагад шинэ бүтэц бий болгох, шинээр чиг үүрэг нэмэгдэх зэрэг зохицуулалт байгаа тохиолдолд судалгаа хийхийг ойлгоно.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд баримтлах зарчим

5.1.Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

- 5.1.1.үндэсний язгуур эрх ашигт нийцсэн байх;
- 5.1.2.нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 5.1.3.төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх;
- 5.1.4.судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх;
- 5.1.5.нөөц бололцоонд үндэслэсэн байх;
- 5.1.6.ил тод, нээлттэй байх;

5.1.7.олон нийтийн оролцоог хангасан байх.. гэсэн зарчмыг тус тус хуулийн төсөл хангасан байна.

Мөн 2017 оны 09 сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийг зааж, уг жагсаалтын хүрээнд төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй, нийтэд хүртээмжтэй байх зарчмыг хангасан байна. Судалгааны багийн зүгээс “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” гэсэн энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектээс орон зайн өгөгдөл бүртгэл үүсгэгч байгууллагын үйл ажиллагааны тайлан, бүртгэх явцад үүсэх процесс ажиллагаа зэрэгт дүн шинжилгээ хийх замаар шалгасан. Төрийн мэдээллийн систем хангамж болон Үндэсний дата төвийн эрх үүрэг

- Төрийн өгөгдөл мэдээллийг төрийн байгууллагууд хамтран ашиглах талаар дүрэм, журам боловсруулагдсан
- Төрийн мэдээлэл солилцоо болон өгөгдлийг дундаа хамтран ашиглах, төрийн мэдээллийг удирдах зэрэг зохицуулалтыг хангах шаардлагатай
- Өгөгдөл хамтран ашиглах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаар журам болон нэгдсэн код ашиглах журам
- Төрийн байгууллага хоорондын цахим баримт бичиг солилцооны талаар нэгдсэн журам
- Төрийн удирдах албан тушаалтны тоон гарын үсэг ашиглах талаар журам
- Төрийн мэдээллийн санд хандах, түүнийг ашиглах талаар журам боловсруулж төрийн мэдээллийн санг зохион байгуулах
- Төрийн байгууллагуудад ашиглагдах программ хангамж, мэдээллийн системийн боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт
- Төрийн байгууллагуудыг холбосон өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх, нөөц сүлжээ үүсгэх зэрэг 2012 оын 101 тоот Цахим засаг хөтөлбөрөөр дээрх ажил салбарт бүрд хангалттай хийгдсэн байна.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлын нэг том шалгуур үзүүлэлт нь орон зайн өгөгдөлийн дэд бүтцийн үйл ажиллагаа төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдох байдлын судалгааны нэгтгэлийг харуулав.

| № | Цахим засаг хөгжүүлэх бодлого зохицуулалттай, холболт хийх |
|---|--|
| 1 | Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх болон контент хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах хуулийн төсөл боловсруулж, батлуулах |
| 2 | Цахим төлбөр тооцоог боловсронгуй болгох эрх зүйн орчинг сайжруулах |
| 3 | Төрийн өгөгдөл мэдээллийг төрийн байгууллагууд хамтран ашиглах талаар дүрэм, журам боловсруулах |
| 4 | Өгөгдөл хамтран ашиглах, хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлын талаар журам болон нэгдсэн код ашиглах талаар зөвлөмж боловсруулах |
| 5 | Төрийн байгууллага хоорондын цахим баримт бичиг солилцооны талаар нэгдсэн журам боловсруулах |
| 6 | Төрийн удирдах албан тушаалтны тоон гарын үсэг ашиглах талаар журам боловсруулах |

| | |
|----|--|
| 7 | Төрийн мэдээллийн санд хандах, түүнийг ашиглах талаар журам боловсруулж төрийн мэдээллийн санг зохион байгуулах зөвлөмж гаргах |
| 8 | Төрийн байгууллагуудад ашиглагдах программ хангамж, мэдээллийн системийн боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт болон нэвтрүүлэх талаархи бодлогын чиглэл боловсруулах |
| 9 | Тухайн салбарын болон байгууллагын мэдээллийн энтерпрайз архитектур боловсруулах |
| 10 | Мэдээллийн технологийн аудит, байгууллагуудын мэдээллийн технологийн хөгжлийн үнэлгээ хийх тогтолцоог бий болгоход баримтлах бодлогын чиглэл, холбогдох журмыг боловсруулж, нэвтрүүлэх |
| 11 | Монгол Улсын Мэдээлэл, харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах |
| 12 | Төрийн үйлчилгээг хөдөлгөөнт холбооны сүлжээ ашиглан дамжуулах, түүнийг иргэд хялбар ашиглах бололцоог дэмжсэн зохицуулалтын таатай орчинг бий болгох |
| 13 | Цахим засгийн үйлчилгээг найдвартай, аюулгүй явуулах программ хангамж, контент хөгжүүлэх асуудлыг дэмжих бодлого зохицуулалтыг бий болгох |
| 14 | Төрийн мэдээлэл солилцоо болон өгөгдлийг дундаа хамтран ашиглах, төрийн мэдээллийг удирдах зэрэг зохицуулалтыг бий болгох |
| 15 | Засгийн газрын нэгдсэн энтерпрайз архитектур боловсруулж, нэвтрүүлэх |
| 16 | Төрийн байгууллагуудыг холбосон өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх, нөөц сүлжээнд холбогдох |
| 17 | Утасгүй өргөн зурвасын сүлжээнд холбогдох, өргөтгөх үйл ажиллагааг дэмжих |
| 18 | Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг бий болгох, цахим гарын үсэг холбох |
| 19 | Мэдээллийн нууцлал, хамгаалалтын системийн нэгдсэн төлөвлөлт, дизайн боловсруулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| 20 | Программ хангамжийг лицензтэй болгох, программ хангамжийн хууль ёсны хэрэглээг бий болгох |
| 21 | Үүлэн тооцооллын технологи, нэвтрүүлж эхлэх |
| 22 | III. Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох зорилтын хүрээнд: |
| 23 | Төрийн байгууллагын вэбсайтын контентийн чанарыг сайжруулах, тухай бүр нь баяжилт, шинэчлэлт хийж хэвшүүлэх |
| 24 | Систейн үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох нэвтрүүлэх ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ: |
| 25 | Эмнэлэгүүдийг өндөр хурдны сүлжээнд холбох, мэдээлэл (өвчний түүх) солилцох боломжоор хангах |
| 26 | Өвчлөлтийн тандалт, статистик мэдээллийн сан, мэдээллийн систем бий болгох |
| 27 | Иргэний эрүүл мэндийн даатгалын хяналтын системийг хөгжүүлэх БОЛОВСРОЛЫН САЛБАРТ: |
| 28 | Цахим номын сангийн харах боломжийг нээх, барилгын техникийн болон дэд бүтцийн нөхцөл шаардлаг |
| 29 | Сургууль, цэцэрлэгийн багш нарт бүртгэлийн системийг харуулах |
| 30 | Ногоон бүсийн хүүхдийн зуслангийн бүртгэлийн мэдээллийн систем боловсруулах |
| 31 | Түүхийн дурсгалт мэдээллийн системийн сан бий болгох УУЛ УУРХАЙН САЛБАРТ: |
| 32 | Уул, уурхайн олборлолт, ашиглалт явуулсан талбайн нөхөн сэргээлтийн талаархи мэдээллийн систем бий болгох |
| 33 | Экологийн хохирлын болон нөхөн төлбөр, хураамжийг тооцох, хариуцуулах, төлүүлэх, хянах мэдээллийн систем нэвтрүүлэх |
| 34 | Улсын болон хувийн хөрөнгөөр хийгдсэн эрдэс баялгийн бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнг нэгтгэн боловсруулж, үндэсний геомэдээллийн сан бий болгох |
| 35 | Уул уурхайн кадастрын бүртгэлийн системийг бүрэн автоматжуулах |
| 36 | Уул уурхайн үйлдвэрлэлийн тээврийн хяналтын систем нэвтрүүлэх |

| | |
|----|---|
| | ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ: |
| 37 | Газар тариалангийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх |
| 38 | Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн цогц шийдэл бүхий программ хангамж, сүлжээг бий болгох |
| 39 | Биржийн мэдээллийн технологийн шаардлагад нийцсэн мэргэжилтнийг орон нутагт бэлтгэх, |
| 40 | Малын бүртгэл, хөдөлгөөнийг хянахтай холбоотой цогц системийг хөгжүүлэх |
| 41 | Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний голомт, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүртгэж, онлайн зөвлөгөө өгөх |
| 42 | Хүнсний аюулгүй байдал, хүнсний нөөцийн мэдээллийн нэгдсэн систем үүсгэх |
| 43 | Хөнгөн үйлдвэрийн салбарт мэдээллийн системийг бий болгох |
| | ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ |
| 44 | Ашиглалтад орсон болон шинээр баригдах барилга байгууламж, гэр хороолол, тэдгээрийг дулаан, цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх |
| 45 | Хотын авто замын дагуух бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, орц, гарц, зогсоолын ажлын төлөвлөлт, трасс сонголт, эдэлбэр газарт барилга барих, зам сэтлэх, зогсоол барих барилгын ажлын зөвшөөрөл олгох зэрэг үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх |
| 46 | Авто зам, замын байгууламжтай холбоотой өргөдөл, хүсэлт, санал, гомдлыг хүлээн авах, барагдуулах мэдээллийн систем боловсруулж, нэвтрүүлэх |
| 47 | Нийтийн тээврийн хэрэгслийн сүлжээний мэдээллийн систем бий болгох |
| 48 | Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох мэдээллийн систем бий болгох, холбох |
| 49 | Зорчигч тээврийн хэрэгслийн тасалбар борлуулах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх мэдээллийн систем бий болгох |
| 50 | ЦАХИМ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, ЛАВЛАГАА ОЛГОХ |
| 51 | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгож байгаа зарим тусгай зөвшөөрлийг цахим үйлчилгээнд бүрэн шилжүүлэх |
| 52 | Жижиг, дунд үйлдвэрлэл, шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох мэдээллийн систем бий болгох |
| 53 | Архивын лавлагаа олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх |
| 54 | Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ шинээр олгох, шилжүүлэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх |
| | БАНК, САНХҮҮГИЙН САЛБАРТАЙ |
| 55 | Санхүүгийн төлбөр тооцоо, үйл ажиллагааг дэмжих мэдээллийн системтэй холбогдох |
| 56 | НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН САЛБАРТАЙ |
| 57 | Мэргэжлийн хүний цогц цахим системийг хөгжүүлэх |
| | ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ |
| 58 | Төрийн албаны хүний нөөцийн үндэсний хэмжээний мэдээллийн систем бий болгох |
| 59 | Төрийн албаны бодлогын мэдээлэл, дүн шинжилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийн систем нэвтрүүлэх |
| 60 | ИРГЭДЭД ХҮРГЭХ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМЖУУЛАХ: |
| 61 | Иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнтэй холбоотой цогц системийг хөгжүүлэх |
| 62 | Төрөөс засаг захиргааны анхан шатны нэгжээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээ, мэдээ мэдээллийг хүргэхэд цахим шуудангийн хаяг болон мэдрэгч бүхий технологийг нэвтрүүлж эхлэх |
| 63 | Үндэсний дата төв рүү байгууллагын мэдээллийн системийг шилжүүлэн төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэх |
| 64 | Иргэний бүртгэл, эд хөрөнгийн бүртгэл, хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээнд “Ухаалаг дараалал систем”-ийг нэвтрүүлэх |
| 65 | Үндэсний дата төвийн нөөц төвийг байгуулахад дэмжлэг үзүүлэх |

| | |
|-----|---|
| 66 | Бүх төрлийн даатгалын үйлчилгээнд иргэний цахим үнэмлэхийг хэрэглэх боломжийг бүрдүүлэх |
| 67 | Цахим засгийн үндэсний портал систем, платформ бий болгох |
| 68 | Нийтийн түлхүүрийн дэд бүтэц, цахим гарын үсэг, иргэний цахим үнэмлэхтэй холбон өгсөн банкны үйлчилгээ, бусад аюулгүй байдлын өндөр түвшин шаардсан системд холбох |
| 69 | Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж байгаа явцыг хянах нэгдсэн мэдээллийн систем бий болгох |
| 70 | Иргэний цахим үнэмлэх уншигч, холбогдох бусад тоног төхөөрөмж, программ хангамжинд холбогдох |
| 71 | Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын үйлчилгээнд |
| 72 | Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнд |
| 73 | Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн үйлчилгээнд |
| 74 | Цагдаа, онцгой байдлын ажил үйлчилгээнд |
| 75 | Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг бий болгох: |
| 76 | Гэмт халдлага, байгалийн гамшиг, малын онц халдварт өвчнийг мэдээлэх |
| 77 | Системээс мессежтэй болгох |
| 78 | Номын сангийн үйлчилгээний мэдээллийг хүргэх |
| 79 | Хөдөлмөрийн биржид бүртгүүлсэн иргэдэд мэдээ хүргэх |
| 80 | Замын хөдөлгөөний мэдээллийг хүргэх |
| 81 | Жуулчдад зориулсан түүхт соёл үйлчилгээний мэдээлэл |
| 82 | орон сууцны хаягын мэдээлэл |
| 83 | Малчдад түүхий эдийн үнэ, ханш илгээх |
| 84 | Тендерийн мэдээлэл, лавлагаа |
| 85 | Замын цагдаагийн мэдээлэл түгээх |
| 86 | Банкны үйлчилгээний төлбөр тооцоо, дансны мэдээлэлтэй холбох |
| 87 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл, лавлагааны систем |
| 88 | Иргэдэд үйлчлэх үйлчилгээний газрын байршил, цагийн хуваарийн мэдээлэл хүргэх |
| 89 | Улаанбаатар хотын агаарын бохирдлын тухай мэдээлэл хүргэх |
| 90 | Тээврийн хяналтын систем |
| 91 | Улсын тэмдэгтийн хураамж төлөх |
| 92 | Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг бий болгох чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг дэмжих |
| 93 | Төрийн албан хаагчдад зориулсан мэдээллийн технологийн сургалтын төвийг байгуулах, төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн ур чадварын түвшинг тогтоох тогтолцоог бий болгох |
| 94 | Мэдээллийн технологийн мэргэжилтэн, мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг олон улсын түвшинд хүргэх, хөдөө орон нутагт мэргэжлийн боловсон хүчнээр хангах |
| 95 | Төрийн байгууллагад ажиллаж байгаа мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн ур чадварыг сайжруулах, тогтвортой ажиллуулах урамшууллын механизмыг бий болгох |
| 96 | Мэдээллийн технологийн нарийн мэргэжлийн мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх |
| 97 | Цахим засгийг хөгжүүлэх зорилготой судалгаа шинжилгээний төвийг байгуулах |
| 98 | Иргэд болон төрийн албан хаагчдад зориулсан цахим сургалт, сургалтын агуулгад аудио, видео дүрс ашигласан контент бүхий цахим сургалтыг түлхүү дэмжих, хэвлэл мэдээллийн бүх сувгийг (интернэт, радио, телевиз гэх мэт) ашиглах |
| 99 | Ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт мэдээллийн технологийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх |
| 100 | өндөр настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах |

3.6 “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараахь асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь үнэлэхийг зорилго.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2016 оны 12 сарын 28 өдрийн А/61 Төрөөс мэдээлэл солилцооны системийн баримтлах бодлогын баримт бичигт

Монгол улсад цахим засаг хөгжүүлэх үндсэн шаардлага болох төрийн байгууллагуудын мэдээлэл солилцооны нэгдсэн системийн техникийн болон програм хангамжийн талаар тодорхой тусгагдсан байдаг.

Орон зайн өгөгдлийн дэд бүтцээр дамжуулан, байрлалд суурилсан дүн шинжилгээг ашигласнаар цахим засаглал бэхжих бөгөөд салбаруудын үйл ажиллагаанд дараах байдлаар эдийн засгийн шууд ба шууд бус дэмжлэгийг үзүүлнэ.

Газрын харилцаа:

Газрын бүртгэлийн цэгцтэй, ил тод, баталгаат байдал хангагдах;

Газраас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ бодитой, газрын татвар, төлбөрийн харилцааг зохицуулах цахим орчин бүрдэх;

Газар чөлөөлөхтэй холбогдсон нөхөх олговрын хэмжээг бууруулах.

Хот байгуулалт, стратегийн төлөвлөлт:

Хаягийн систем илүү боловсронгуй болж, иргэн хуулийн этгээдэд цаг хугацаа, эдийн засгийн хэмнэлт бий болох;

Статистик мэдээлэлд орон зайн дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах;

| | <p>хүрээлэн буй орчны төлөв байдал, инженерийн шугам сүлжээний хангамжийн түвшин, барилга байгууламж, хүн амын амьдрах орчны чанарын тухай байр зүйн зураглал, мэдээллийн нэгдмэл санг; 25.1.хот байгуулалтын кадастр нь хот байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл хийхэд зайлшгүй шаардлагатай мэдээлэл бүхий улсын сан мөн.</p> | <p>баримт бичиг болох бөгөөд түүнд дараахь мэдээлэл хамаарна: 25.5.1.геодези, байр зүй, зурагзүйн материал; 25.5.2.газар нутгийн экологи, инженер-геологи, газар чичирхийлэл; 25.5.3.гидрогеологийн тухай мэдээлэл; 25.5.4.хот байгуулалтын хөгжлийн болон газар, барилгажилтын тухай мэдээлэл; 25.5.5.инженерийн, зам тээврийн болон нийгмийн дэд бүтэц ба газар нутгийн тохижилтын тухай мэдээлэл. 25.7.хот байгуулалтын кадастрын мэдээлэл нээлттэй байна.</p> | <p>захиргааны байгууллага хариуцан явуулна.</p> |
| <p>Байгаль орчныг хамгаалах тухай /1995.03.30/</p> | <p>7 дугаар бүлэг байгаль орчны мэдээллийн сан</p> <p>Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах журам ЗГ 2010 85</p> <p>"Байгаль орчны мэдээллийн сангийн эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт"</p> <p>Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх</p> | <p>35 дугаар зүйл.мэдээллийн сангийн бүрдэл</p> <p>1/газар, түүний хөрс; 2/газрын хэвлий, ашигт малтмал; 3/ус, рашаан; 4/ой; 5/байгалийн ургамал; 6/амьтан; 7/агаар, түүний бохирдол; 8/уур амьсгал; 9/байгалийн гамшиг; 10/химийн хорт болон аюултай бодис; 11/хог хаягдал; 12/тусгай хамгаалалттай газар нутаг; 13/байгаль орчны эрх зүй; 14/байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ; 15/байгаль орчны бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт; 16/байгаль орчны статистик мэдээлэл, тайлан; 17/байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал;</p> | <p>38 дугаар зүйл.мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах байгууллага</p> <p>1.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээллийн сангийн үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулна.</p> <p>2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгаль орчны мэдээллийн төв байх бөгөөд уг төв нь улсын мэдээллийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн үйлчилгээний байгууллага байна.</p> |

| | | | |
|------------------------------------|---|---|--|
| | журам Сайд 2014.03.17 А86 | 18/байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хүний нөөц; 19/мета мэдээллийн сан; 20/байгаль орчны талаарх бусад мэдээлэл. 21/байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн мэдээлэл; 22/байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл. 33.4.хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн сан олон нийтэд нээлттэй байна. | |
| Газрын хэвлийн тухай /1988.11.29/ | 4 дүгээр зүйл. Газрын хэвлий, түүний улсын нэгдмэл сан 4.1. Хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ. | 45.3. Ашигт малтмалын нөөц, ордын болон газрын хэвлийн улсын тоо бүртгэл, ашигт малтмалын ордын данс, нөөцийн балансыг Улсын геологийн сан эрхлэн хөтөлнө. | 46 дугаар зүйл. Ашигт малтмалын ордын улсын данс Ашигт малтмалын ордын улсын данс нь үндсэн болон түүнтэй хамт орших ашигт малтмал, тэдгээрт байгаа бүрэлдэхүүн хэсгийн нөөцийн хэмжээ, чанар, ордыг ашиглах уул-техник, гидрогеологийн болон бусад нөхцөл, түүний геологи-эдийн засгийн үнэлгээг орд тус бүрээр, ашигт малтмалыг илрэл бүрээр нь тусган харуулсан байвал зохино. |
| Ашигт малтмалын тухай /2006.07.08/ | 11.1.5.үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах; | 6 дугаар зүйл. Ашигт малтмалын ордын ангилал 6.1.ашигт малтмалын ордыг дор дурдсанаар ангилна: 6.1.1.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд; 6.1.2.түгээмэл тархацтай ашигт малтмалын орд; 6.1.3.ердийн ашигт малтмалын орд. | 11.1.геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага 11.1.3.геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг баяжуулах, нууцын зэрэглэлд хамааруулснаас бусад мэдээллээр сонирхсон этгээдэд үйлчилгээ үзүүлэх; |
| Авто замын тухай /1998.01.02/ | 16 дугаар зүйл. Авто замын | 16.1. Авто замын бүртгэл, мэдээллийн сан нь авто зам, | 16.2. Авто зам, замын байгууламжийн бүртгэл мэдээллийн |

| | | | |
|--|--|---|---|
| | бүртгэл, мэдээллийн сан | замын байгууламжтай холбоотой дараахь мэдээллээс бүрдэнэ: 16.1.1.Техникийн болон ашиглалтын үзүүлэлтүүд; 16.1.2.Ашиглалтад орсон он, сар, өдөр; 16.1.3.Хүчин чадал, зэрэглэл, төлөв байдал; 16.1.4.Төсөвт өртөг; 16.1.5.Тухайн авто зам, замын байгууламжид гарсан эвдрэл, зам тээврийн ослын мэдээ; 16.1.6.Бусад. | санг аймаг, нийслэл дэх авто замын засвар, арчлалтыг хариуцсан байгууллага эрхлэн хөтөлж, бүртгэл мэдээллийн нэгдсэн санд жил тутам тогтоосон хугацаанд өгнө. |
| Төмөр замын тээврийн тухай /2007.07.05/ | 10.1.12.төмөр замын тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх; | - | 10.1.төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага |
| Соёлын өвийг хамгаалах тухай /2014.05.15/ | 14 ¹ .1.9.соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг хөтлөх; | - | 14 ¹ дүгээр зүйл.соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх |
| Барилгын тухай /2016.02.05/ | 33.1.5, 33.1.14 барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан | - | 34.1.Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага |
| Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/ 2017.02.02 | 6.1.7.гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх | 7.3.3.гамшгийн эрсдэлийн үнэлгээнд шаардагдах мэдээ, баримт, өгөгдөл бүхий мэдээллийн сантай байх; 14.2.Гамшгийн мэдээллийн сан дараахь мэдээллээс бүрдэнэ: 14.2.1.гамшгийн эрсдэлтэй нутаг дэвсгэрийн газар зүйн мэдээлэл; 14.2.2.гамшигт нэрвэгдэж болзошгүй хүн ам, дэд бүтцийн бүртгэл, мэдээлэл; 14.2.3.гамшиг, аюулт үзэгдэл, ослын болон хохирлын дүн мэдээ; 14.2.4.бусад мэдээлэл. | 14.1, 29.1.12 онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага |
| Тариалангийн тухай /шинэчилсэн найруулга/ 2016.01.29 | 23 дугаар зүйл. Тариалангийн үйлдвэрлэлийн тайлан, мэдээллийн сан | 26.12.Тариалангийн газрын хөрсний төлөв байдал, чанарт хийсэн агрохими, агрофизикийн шинжилгээний дүн нь тариалангийн үйлдвэрлэлийн мэдээллийн сангийн бүрэлдэхүүн хэсэг байна. | 23.1.Аймаг, нийслэлийн хөдөө аж ахуйн асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллага нь тариалангийн газрын |

| | | | |
|--|--|--|---|
| | | | ангилал тус бүрээр болон тариалсан таримал, сорт, үр, техник, хураасан ургацын мэдээг сум, дүүргээр нэгтгэн, тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 2 болон 4 дүгээр улиралд хүргүүлнэ. |
|--|--|--|---|

Бусад тогтоомж, шийдвэр

2013 оны 06 сарын 05-ны Монгол улсын Ерөнхий сайдын 95 дугаар захирамж - Байрлалд суурилсан төвлөрсөн мэдээллээр төр, олон нийтийг хангах зорилгоор Орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулахад шаардагдах орон зайн өгөгдөл, мэдээллийг нэгтгэж, хуваарилалтыг сайжруулах ажлыг уялдуулан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 32 агентлагийн удирдлагыг оролцуулан 2013 оны 06 сарын 05-ны өдрийн Монгол улсын Ерөнхий сайдын 95 дугаар захирамжаар байгуулсан байдаг. Тус Ажлын хэсгийн үр дүнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) нь бусад байгууллагатай орон зайн мэдээлэл солилцох чиглэлээр хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулан харилцан ойлголцож ажилласан. Хамтын ажиллагааны үр дүнд бусад байгууллагууд орон зайн өгөгдөл, мэдээллийн талаарх ач холбогдолтойг ойлгосон ба өнөөдрийн байдлаар санамж бичиг, мэдээлэл солилцох гэрээнд мэдээлэл солилцох, хэрэглэх үйл ажиллагаатай холбоотой асуудлаа зохицуулан ажиллаж байна.

2013 оны 09 сарын 21-ний Монгол улсын Засгийн газрын, Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтэц байгуулах тухай 323 дугаар тогтоол: Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох ажлын хүрээнд газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, хаягийн мэдээллийн систем байгуулах, гурван хэмжээст байр зүйн зургийн мэдээллийн систем байгуулах, хот суурин газрын 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг шинэчлэх арга хэмжээ авахыг холбогдох байгууллагуудад уг тогтоолоор даалгасан.

Хэдийгээр орон зайн мэдээллийн ач холбогдол, ОЗӨДБ-ийг байгуулах шаардлагатайг төрийн байгууллагуудын хэмжээнд ойлгож, дурдсан мэдээллийн системүүд байгуулагдаж эхэлсэн ч дээр дурдсан асуудлуудыг шийдвэрлэх хууль эрх зүйн зохицуулалт шаардагдсаар байв.

Практик хэрэгжилтийн байдал

Төрийн байгууллагууд дахь хэрэгжилтийн байдал

Төрийн байгууллагуудаас орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, өгөгдлийн сангийн байдал, хэрэглэдэг программ хангамж, баримталж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, үйлчилгээний төлбөр, хөлс, хамтын ажиллагаа зэрэгт тулгамдаж буй бэрхшээлийн талаар судалгаа авахад дараахь үр дүн гарсан. Судалгааны асуулгыг бүх төрийн захиргааны төв байгууллагаас авахад 8 төрийн захиргааны төв байгууллагаас судалгаанд хариу ирүүлсэн. Судалгааны үр дүнгийн нэгтгэлийг Нэгдүгээр хавсралтад хавсаргав.

Орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийн хувьд: Байгаль орчин, аялал жуулчлалын яам Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар заалтын 1 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчны улсын мэдээллийн санг, Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штаб цэргийн байр зүйн зургийг, Эрчим хүчний яамны харьяа “Улаанбаатар дулаан сүлжээ” ТӨХК барилгын дулааны тоноглол, дулааны шугамын трасс, худаг, төв шугамын өргөн диаметр, солигдсон он зэрэг мэдээлэл агуулсан мэдээллийн санг, Зам, тээвэр хөгжлийн яам Монгол Улсын хэмжээнд автозамын болон төмөр замын сүлжээ, түүний дагуух барилга, байгууламжийн тухай орон зайн мэдээллийн санг тус тус бүрдүүлж байна.

Мэдээллийн санг хадгалах хэлбэрийн хувьд: Орон зайн мэдээлэл бүрдүүлдэг байгууллага дээр дурдсан мэдээллийг ихэвчлэн хүснэгтэн, зурган, болон мэдээлэл солилцооны бусад хэлбэрээр хадгалж, цөөхөн байгууллага мэдээллээ бүрэн болон заримыг орон зайн өгөгдлийн санд, өгөгдлийн сан удирдах программ хангамж ашиглан удирдан зохион байгуулж байна (Зам, тээвэр хөгжлийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам гэх мэт)

Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын хувьд: Судалгаанд хариу ирүүлсэн байгууллагуудаас 1 байгууллага нь Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоолын дагуу мэдээллээ бүрдүүлдэг бол бусад байгууллагуудын хувьд байгууллагын дотоод журмын дагуу харьяа байгууллагаасаа өгөгдөл, мэдээллээ авдаг байна.

Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой Үндэсний болон байгууллагын стандарт, нормын хувьд: MNS5774:2007 Газарзүйн мэдээлэл-Мета өгөгдөл, MNS5641-1:2006 Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, ISO/TC-19104:2012 зэрэг үндэсний стандарт ашиглаж байна. Хүснэгтэн, зурган мэдээлэл хэрэглэж буй байгууллагууд тодорхой стандарт, норм мөрддөггүй.

Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомжийн хувьд: Хэрэглэгчдэд нийлүүлж буй мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, мэдээллийн төлбөрийн асуудал тодорхой бус, байхгүй.

Мэдээлэл солилцоонд түлгэмдаж буй асуудал: Мэдээлэл солилцоход гарах төлбөрийн асуудал, мэдээ бүрдүүлэгч байгууллагын орон зайн мэдээлэл бүрдүүлэлт болон мэдээний чанар хангалтгүй, Сум, хорооны түвшинд мэдээлэл солилцоход дэд бүтэц болон хууль эрх зүйн орчин хүндрэлтэй, холбогдох хууль тогтоомжууд харьцангуй сул, файлын нууцлалыг хангах асуудал, цаг тухайд нь хүссэн мэдээллийг ирүүлдэггүй, албан бичгээр харьцаж мэдээлэл солилцоход удаан хүндрэлтэй, газар зүйн байрлалын нэгдсэн тогтсон нэр томъёо байхгүй, 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн тоон зургуудын зарим өндрийн тоотууд буруу болон дутуу, хаялбарын өндөр байхгүй, эсвэл буруу.

Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл: Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн өгөгдөл дээр салбарын тариалангийн болон мал аж ахуйн зориулалтаар ашиглагдах талбайн мэдээлэл шаардлагатай, Байгаль орчны орон зайн мэдээний чанарыг сайжруулах, улсын хэмжээний орон зайн мэдээг шинэчлэх шаардлагатай, өрх, иргэний мэдээллийг орон зайн мэдээллийн сантай холбож ашиглах, орон зайн мэдээний чанарыг сайжруулах, топологи шалгалт явуулах, нэг мэдээгээр үйлчлэх, орон зайн мэдээллийг бодитоор авахад үүрэн холбооны операторуудын сүлжээнүүдийн тасралтгүй байдалд хүндрэл учирч сүлжээ тасарсан газруудад мэдээллийг бодит цагт хүлээн авах боломж бүрддэггүй.

Бусад санал: Судалгаанд хамрагдсан байгууллагуудаас орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотойгоор ирүүлсэн саналуудыг дор жагсаасан байдлаар түүвэрлэв. Үүнд:

- Салбар тус бүрийн газар зохион байгуулалтын мэдээллийг Засгийн газар болон яам, агентлагуудад төлбөргүйгээр хангах боломжийг бий болгох,
- Орон зайн мэдээллийг бүрдүүлэх, боловсруулах талаар мэдээ бүрдүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт явуулах,
- Орон зайн мэдээллийг веб газрын зургийн үйлчилгээ (WMS гэх мэт) ашиглан солилцох,
- Орон зайн мэдээний стандарт, хууль эрх зүйн орчныг бий болгох, төрийн байгууллага хооронд орон зайн мэдээллийг солилцох дэд бүтцийг бий болгох,
- Монгол Улс нь орон зайн мэдээллийн сан, түүнтэй холбоотой системүүдийг боловсруулан хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай,
- Орон зайн мэдээллийг шуурхай хүлээж авах, мэдээллийг ашиглан газрын зургаа хөгжүүлэх, хөдөлгөөний хяналтыг сайжруулахад байршил тогтоох төхөөрөмжөөс ирүүлж буй мэдээллийг үүрэн холбооны сүлжээ ашиглалгүй сансрын хиймэл дагуулаас шууд хүлээн авдаг болох,
- Өндрийн тогтолцооны зөрөөний асуудлыг шийдвэрлэх.

Асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлэг

Үнэлгээний тайлангийн 1.1 дэх хэсэгт дурдсан асуудлаар эрх, хууль ёсны эрх ашиг сонирхол нь хөндөгдөж буй байдлыг Хүснэгт 2-оор үзүүлэн дүгнэв.

Хүснэгт 2 Ашиг сонирхол нь хөндөгдөж буйг судалсан байдал

| Бүлэг | Нөлөөлж буй хэлбэр |
|------------------------------|--|
| 1. Төрийн байгууллага | Төрд орон зайн мэдээллийг бүрдүүлэхэд төсвийн хүндрэлтэй, ажлын давхардал гардаг. Орон зайн мэдээллийн цахим тогтолцоо байхгүйгээс байгууллага хооронд мэдээлэл солилцоход хүндрэлтэй, цаг хугацаа алдаж байна. Шийдвэр гаргалт, бодлого боловсруулалт, төлөвлөлтөд байрлалд суурилсан мэдээлэл ашиглаагүйгээс буруу төлөвлөлт, бодлого боловсруулалтад хүргэдэг. |
| 2. Төрийн бус байгууллага | Өөрийн зорилгыг хэрэгжүүлэх чиглэлээр төрөөс дэмжлэг авах, хөгжих, улмаар төрийг нөхөж ажиллах үүргээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал. Судалгаа, шинжилгээний ажил хийхэд төрөөс дэмжлэг байхгүй, суурь мэдээллээр төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжих зохицуулалтгүй, мэдээллээр хангах тогтолцоогүй. ТББ болон эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааны ажлыг төрийн үйл ажиллагаанд ашигладаггүй, эргэх холбоогүй. Орон зайн мэдээллийн чиглэлээр судалгаа, хөгжил, инновацын дэмжлэг байхгүй. |
| 3. Аж ахуйн нэгж байгууллага | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг эрхлэхэд ТББ, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог хангах зохицуулалт байхгүй. Байрлалд суурилсан орон зайн мэдээллийн үйлчилгээ явуулах бизнесийн орчныг дэмжсэн зохицуулалт, бодлого байхгүй. Орон зайн өгөгдөл, мэдээллийн ашиглах лицензийн эрхийн зохицуулалт байхгүйгээс төрөөс хувийн хэвшилд мэдээлэл ашиглуулах асуудал саармаг, нэмүү өртөг шингээж бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг сул. |
| 4. Иргэн | Иргэд төрөөс хүртээмжтэй, чанартай орон зайн мэдээлэлд суурилсан үйлчилгээг шуурхай хүртэх боломжгүй бөгөөд албан бичиг хүргүүлэх, биечлэн ирэх шаардлагатай байдаг.. |

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Аргачлалын 4-т заасны дагуу тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дараах зорилгуудыг дэвшүүлэв.

А. Суурь орон зайн өгөгдөл, мэдээллийн ангиллыг тодорхой болгох, тэдгээрийг бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг оролцоог сайжруулах замаар орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийн давхардлыг арилгах,

В. Орон зайн өгөгдөл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандартын нэгдсэн тогтолцоо бий болгох замаар баталгаатай, шинэлэг, чанартай орон зайн мэдээллийг шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээх боломжийг бүрдүүлэх,

С. Орон зайн өгөгдөл, мэдээллийг түгээх, ашиглах, солилцох зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх бүрдүүлэгч, хэрэглэгчийн үүрэг, хариуцлага, эрх, нөхцөл, хязгаарлалтын (лицензийн) асуудлыг тодорхой болгох замаар орон зайн мэдээлэлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих,

Д. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч, хамтрагч байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог тодорхой болгох, тэдгээрийг нэгдсэн удирдлагаар зохицуулах замаар бүх салбарт орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлэх.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛУУДЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг тал, бусад орны туршлагыг харьцуулан судалж Хүснэгт 3-т үзүүлэв. Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 3 Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн эерэг, сөрөг тал

| Хувилбар | Зорилгод хүрэх байдал | Зардал, үр өгөөжийн харьцаа | Үр дүн |
|---|---|---|--|
| А. Суурь орон зайн өгөгдөл, мэдээллийн ангиллыг тодорхой болгох, тэдгээрийг бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг оролцоог сайжруулах замаар орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийн давхардлыг арилгах, | | | |
| 1. | “Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах; | Төрийн байгууллага тус бүр өөрсдийн мэдээллийн ангилалтай ба орон зайн өгөгдлийн нэгдсэн ангилал, зэрэглэл байхгүй. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, |

| | | | | |
|----|---|---|--|-----------|
| | | Одоо байгаа хуульд заасан ангилал мэдээлэл нь давхардсан, дутмаг байдаг ба суурь зургуудын талаар тодорхой заасан зохицуулалт байхгүй. Олон улсад хууль, тогтоомждоо суурь өгөгдөл болон бусад өгөгдөл, мэдээллийн ангиллыг бүрдүүлэгчдийн хамт заасан байдаг. | зорилтод хүрэх боломжгүй. | |
| 2. | <i>Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;</i> | Орон зайн өгөгдөл, мэдээллийн ангилал, зэрэглэлийг журамлан тогтоохгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх боломжгүй. Бусад орнууд журамлагдсан мэдээллийн ангиллуудаа тараах материал, дүрст бичлэг болгон олон нийтэд сурталчилдаг. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 3. | <i>Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;</i> | Зорилгод хүрэх боломжгүй | - | Үр дүнгүй |
| 4. | <i>Төрөөс санхүүгийн интервенц хийх;</i> | Интервенц хийж шийдвэрлэх боломжгүй. | - | Үр дүнгүй |
| 5. | <i>Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;</i> | Орон зайн өгөгдөл, мэдээллийн ангилал, зэрэглэлийг тодорхойлох, байгууллагуудын уялдаа холбоог хангуулах үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх нөхцөлд энэ тухайгаа хуульд зааж өгсөн байх шаардлагатай байдаг. Захиргааны ерөнхий хууль 8 дугаар зүйл /Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно/ | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |

| | | | | |
|---|---|---|--|-------------------------|
| 6. | <i>Захиргааны шийдвэр гаргах;</i> | <p><u>Орон зайн өгөгдөл, мэдээллийн ангилал, зэрэглэлийг тодорхой болгоход захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар шийдвэрлэх боломжтой.</u></p> <p>Мөн ОЗӨДБ-ийн суурь өгөгдөл, мэдээллийн ангиллыг хуульчлан тогтоох боломжтой.</p> <p>Бүрдүүлэгч байгууллага, оролцогчдын үүрэг оролцоо, хамтын ажиллагааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулахад тусгайлан олгосон эрх зүйн зохицуулалт одоогийн хуулиудад байхгүй.</p> | <p>Орон зайн өгөгдөл, мэдээллийн ангилал зэрэглэлийг тогтоож болох боловч эрх үүргийг олгох боломжгүй.</p> <p>Асуудлыг цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.</p> | Тодорхой үр дүнд хүрнэ. |
| 7. | <i>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.</i> | <p><u>ОЗӨДБ-ийн суурь өгөгдөл, мэдээлэл, тэдгээрийн бүрдүүлэлт, бүрдүүлэгч нарын хамтын ажиллагаа, эрх үүргийг тодорхой зохицуулах боломжтой.</u></p> <p><u>АНУ нь ОЗӨДБ-ийн ерөнхий зохицуулалтыг ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулж, өгөгдөл, мэдээллийн ангилал, хамтын ажиллагаатай холбоотой зохицуулалтыг журамласан байдаг.</u></p> <p><u>Европын холбоо нь энэ асуудлыг INSPIRE Тогтоолоор зохицуулсан байдаг бол БНСУ, Индонез, Энэтхэг зэрэг улс орнууд өөрсдийн гэсэн хууль эрх зүйн орчинтой.</u></p> | <p>Хувилбар нь асуудлыг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой</p> | Үр дүнтэй. |
| В. Орон зайн өгөгдөл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандартын нэгдсэн тогтолцоо бий болгох замаар баталгаатай, шинэлэг, чанартай орон зайн мэдээллийг шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээх боломжийг бүрдүүлэх, | | | | |
| 1. | <i>“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт</i> | <p>Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа болох орон зайн өгөгдөл,</p> | <p>Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал</p> | Үр дүнгүй. |

| | | | | |
|----|---|--|--|-------------------------|
| | <i>хийхээс татгалзах;</i> | мэдээллийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандарттай байх хууль эрх зүйн орчин байхгүй. Гадаадын улс орнууд үйл ажиллагааны бүрдэл, алхам бүрээр стандарттай байдаг. | хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | |
| 2. | <i>Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;</i> | Зорилгод хүрэх боломжгүй. Стандартын тогтолцоо үүссэнээр уг асуудал шийдэгдэнэ. | - | Үр дүнгүй. |
| 3. | <i>Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;</i> | Зорилгод хүрэх боломжгүй | - | Үр дүнгүй. |
| 4. | <i>Төрөөс санхүүгийн интервенц хийх;</i> | Интервенц хийж шийдвэрлэх боломжгүй. | - | Үр дүнгүй. |
| 5. | <i>Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;</i> | <u>Стандарт боловсруулалтыг сонгон шалгаруулалтын замаар хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.</u> <u>Төрийн бус байгууллагаар төрийн чиг зарим чиг үүргийг гүйцэтгүүлж болох хэдий ч хуульд тусгайлсан заалт байхгүй тул хэрэгжүүлэх боломжгүй.</u> Захиргааны ерөнхий хууль 8 дугаар зүйл /Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно/ | Асуудлыг цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрнэ. |
| 6. | <i>Захиргааны шийдвэр гаргах;</i> | Стандарт нь захиргааны шийдвэрт хамаарахгүй. “Захиргааны ерөнхий хуулийн 60.2.Стандартчилал, | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх | Үр дүнгүй |

| | | | | |
|--|---|---|--|------------|
| | | тохирлын үнэлгээний тухай хуулийн 3.1.2-т заасан баримт бичиг энэ журамд хамаарахгүй.” гэж заасан. | бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | |
| 7. | <i>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.</i> | <u>Орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандарт боловсруулах тухай тусгайлан хуульд заасан тохиолдолд эрх зүйн үндэслэлтэй.</u> <u>Орон зайн суурь өгөгдөл, үйлчилгээг гаргах, төрөл бүрийн өгөгдлийн сангуудын нэгдмэл байдлыг хуульд тусгайлан заасан үндэслэлээр зохицуулна.</u> | Тодорхой зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. | Үр дүнтэй. |
| С. Орон зайн өгөгдөл, мэдээллийг түгээх, ашиглах, солилцох зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх бүрдүүлэгч, хэрэглэгчийн үүрэг, хариуцлага, эрх, хязгаарлалтын (лицензийн) асуудлыг тодорхой болгох замаар орон зайн мэдээлэлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих, | | | | |
| 1. | <i>“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;</i> | Зорилгод хүрэх боломжгүй. Орон зайн мэдээллийн үр шимийг хүртэхгүй. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 2. | <i>Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;</i> | Орон зайн мэдээллийн үр шимийг олон нийтэд сурталчилж, ач холбогдлыг ойлгуулах боломжтой ч бүрдүүлэгч, хэрэглэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах боломжгүй. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 3. | <i>Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;</i> | Зорилгод хүрэх боломжгүй | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, | Үр дүнгүй |

| | | | | |
|---|--|---|--|------------------|
| | | | зорилтод хүрэх боломжгүй. | |
| 4. | <i>Төрөөс санхүүгийн интервенц хийх;</i> | Интервенц хийж шийдвэрлэх боломжгүй. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 5. | <i>Төрийн бус байгууллага, хувийн хэвшилээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;</i> | Захиргааны ерөнхий хууль 8 дугаар зүйл /Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно/ | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 6. | <i>Захиргааны шийдвэр гаргах;</i> | Хамтын ажиллагаа, оролцоог эрчимжүүлэх боломжтой ч эрх олгож, үүрэгжүүлэх боломжгүй. Зорилгод хүрэх боломжгүй | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 7. | <i>Хууль тогтоомжийн төсөл боловсруулах.</i> | Орон зайн өгөгдөл, мэдээллийн үндсэн зарчмыг тодорхойлно, бүрдүүлэгч, хэрэглэгчийн хооронд үүсэх үүрэг, хариуцлага, эрх, хязгаарлалтын (лицензийн) үндсэн асуудлыг тодорхойлно. Орон зайн мэдээлэлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих зохицуулалт хийнэ. | Тодорхой зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой. | Үр дүнтэй |
| D. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч, хамтрагч байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог тодорхой болгох, тэдгээрийг нэгдсэн удирдлагаар зохицуулах замаар бүх салбарт орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлэх. | | | | |
| 1. | <i>“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт</i> | Зорилгод хүрэх боломжгүй | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал | Үр дүнгүй |

| | | | | |
|----|---|--|---|------------------------|
| | <i>хийхээс татгалзах;</i> | | хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | |
| 2. | <i>Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;</i> | <u>Орон зайн мэдээллийн ач холбогдлыг нийтэд сурталчлах боломжтой.</u> | Зорилгыг бүрэн хангахгүй ч төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн ойлголтыг нэмэгдүүлнэ. Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй. | Тодорхой үр дүнд хүрнэ |
| 3. | <i>Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;</i> | Зорилгод хүрэх боломжгүй | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 4. | <i>Төрөөс санхүүгийн интервенц хийх;</i> | Интервенц хийж шийдвэрлэх боломжгүй. | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | Үр дүнгүй |
| 5. | <i>Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;</i> | Захиргааны ерөнхий хууль 8 дугаар зүйл /Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно/ | Асуудлыг цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй . | Үр дүнгүй |
| 6. | <i>Захиргааны шийдвэр гаргах;</i> | Захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар шийдвэрлэх боломжтой | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал хэвээр | Үр дүнгүй. |

| | | | | |
|----|---------------------------------------|--|---|-------------------|
| | | хэдий ч үндэслэх хуулийн заалт байхгүй. | үргэлжлэх бөгөөд зорилго, зорилтод хүрэх боломжгүй. | |
| 7. | Хууль тогтоомжийн төсөл боловсруулах. | <u>Төрийн байгууллагуудын эрх, үүргийг хуулиар зохицуулна.</u> | Өнөөгийн тулгамдаж байгаа асуудал шийдэгдэж зорилгод хүрнэ. | Үр дүнтэй. |

Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд асуудлыг шийдвэрлэх зорилгуудыг хангахад Хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэсэн зохицуулалтын хувилбарыг сонгов.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.

Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан хүснэгтэд үндэслэн асуудлыг шийдвэрлэхээр дэвшүүлсэн 4 зорилгыг бүгдийг нь шийдвэрлэж чадах зохицуулалтын хувилбар (хууль тогтоомжийн төсөл боловсруулах)-т хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг тандан судлав. Судалгааны үр дүнг дор хүснэгтэд үзүүлэв.

Судалгаануудад үндэслэн Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн талаарх тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгыг хангахад Хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэсэн зохицуулалтын хувилбарыг сонгов. Энэхүү хувилбараар асуудлыг шийдвэрлэснээр хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх сөрөг үр нөлөөгүй.

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---|---|---------|-------------|---|
| 1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх | 1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх | | | |
| | 1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.2. Оролцоог хангах | | | |
| | 1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |

| | | | | |
|--|--|------|------|---|
| | 1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага | | | |
| | 1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| | 1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийн суурь зарчмуудыг хөндөхгүй |
| 2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх | 2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй |
| | 2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх | Тийм | Үгүй | Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт байхгүй |
| 3.Эрх агуулагч | 3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Эрх агуулагч байхгүй |
| | 3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Эрх агуулагч байхгүй |
| | 3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх | Тийм | Үгүй | Эрх агуулагч байхгүй |
| | 3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй) | Тийм | Үгүй | Эрх агуулагч байхгүй |
| 4.Үүрэг хүлээгч | 4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх | Тийм | Үгүй | Үүрэг хүлээгч байхгүй |
| 5.Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх | 5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх | Тийм | Үгүй | Жендерийн эрх тэгш байдлыг хөндөхгүй |
| | 5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Жендерийн эрх тэгш байдлыг хөндөхгүй |

Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | Тайлбар | |
|---|---|---------|---------|--------------------------------|
| 1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар | 1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|---|--|------|------|--|
| | (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан) | | | |
| | 1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал | 2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал | 3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал | 4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Өмчлөх эрх | 5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Инновац болон судалгаа шинжилгээ | 6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх | Тийм | Үгүй | Тодорхой үр дүнг дэмжих зохицуулалт тусгана. Шүүд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| | 6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх | Тийм | Үгүй | Тодорхой үр дүнг дэмжих |

| | | | | |
|------------------------------------|--|-------------|-------------|--|
| | | | | зохицуулалт тусгана. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| 7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв | 7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| | 7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| 8.Тодорхой бус нутаг, салбарууд | 8.1.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| | 8.2.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| 9.Төрийн захиргааны байгууллага | 9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Төсвийн хэмнэлт гарна. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| | 9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй |
| | 9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх | Тийм | Үгүй | Нийтлэгээр бус гэрээ байгуулсан тохиолдолд |

| | | | | |
|--------------------------------|---|------|------|--|
| | | | | хуулийн дагуу чиг үүрэг үүснэ. |
| 10.Макро эдийн засгийн хүрээнд | 10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. Шууд бус нөлөөллөөр үр дүн гарна. |
| | 10.3.Инфляци нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 11.Олон улсын харилцаа | 11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

Нийгэмд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|--|--|---------|------|---|
| 1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл | 1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх | Тийм | Үгүй | ТББ-ууд байгуулагдах, өргөжихөд нөлөөлнө. |
| | 1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх | 2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| 3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал | 3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|--|---|------|------|--------------------------------|
| | 3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун | 4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал | 5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем | 6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Эерэг нөлөө үзүүлнэ. |
| | 6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал | 7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|--------|--|------|------|--------------------------------|
| | 7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 8.Соёл | 8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

| Үзүүлэх үр нөлөө | Холбогдох асуулт | Хариулт | | Тайлбар |
|---------------------------------|---|---------|------|--------------------------------|
| 1.Агаар | 1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 2.Зам тээвэр, түлш, эрчим хүч | 2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 3.Ан амьтан, ургамлыг хамгаалах | 3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 4.Усны нөөц | 4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

| | | | | |
|---|---|------|------|--------------------------------|
| | 4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 5.Хөрсний бохирдол | 5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 6.Газрын ашиглалт | 6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| 7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг | 7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |
| | 7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх | Тийм | Үгүй | Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй |

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙХ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулан батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх, сөрөг үр дагаврыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах, орон зайн мэдээллийг ашиглах судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжтой байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Эрх зүйн зохицуулалтын судалгаа

Олон улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийхдээ сайн туршлагыг хэрэгжүүлж, илүү дэвшилттэйгээр зохицуулж байгаа Америкийн Нэгдсэн Улс, Европын холбоо, Индонез, Япон, БНХАУ, БНСУ-ыг сонгов. Дэлгэрэнгүй харьцуулалтыг Хоёрдугаар хавсралтад үзүүлэв.

Хүснэгт 4 Олон улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааны ерөнхий хүснэгт

| Улсын нэр | Эрх зүйн зохицуулалтын нэр | Дагалдан гарсан журам | Хариуцагч байгууллага |
|--|---|--|---|
| АНУ | Ерөнхийлөгчийн Зарлиг 12906, 1994.04.11 | Захирамж А-16 <i>Газарзүйн мэдээлэл болон холбогдох орон зайн өгөгдлийн үйл ажиллагааны зохицуулалт</i> 1990.10.19, 2002.08.19 | Холбооны Газарзүйн Мэдээллийн Хорвоо The Federal Geographic Data Committee |
| https://www.archives.gov/files/federal-register/executive-orders/pdf/12906.pdf https://www.fgdc.gov/policyandplanning/a-16/index_html | | | |
| Европын холбоо | INSPIRE Тогтоол, 2007.05.15 | Дагалдан гарсан техникийн шаардлага, гарын авлага, стандарт, зааварчилгаануудтай | Орон зайн мэдээллийн дэд бүтцийн Европын зөвлөл INSPIRE Infrastructure for Spatial information in the European Community |

| | | | |
|---|---|---|---|
| http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:32007L0002&from=EN | | | |
| Индонез | Орон зайн мэдээллийн тухай хууль, 2011 | Дагалдан гарсан техникийн шаардлага, гарын авлага, стандарт, зааварчилгаануудтай | Орон зайн мэдээллийн агентлаг, Badan Informasi Geospasial |
| http://www.un-ggim-ap.org/article/Information/unggimap_meetings/plenary/LawNo.4Year2011GeoSpatialInformationofIndonesia-EnglishVersion.pdf | | | |
| Япон | Орон зайн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх ерөнхий хууль 2007.05.30 | Дагалдан гарсан техникийн шаардлага, гарын авлага, стандарт, зааварчилгаануудтай | Газар, дэд бүтэц, тээвэр, аялал жуулчлалын яам, Орон зайн мэдээллийн агентлаг, Ministry of Land, Infrastructure, Transport and tourism, Geospatial Information Authority of Japan |
| http://www.gsi.go.jp/kokusaikoryu/kokusaikoryu-e30004.html | | | |
| БНХАУ | БНХАУ-ын хэмжил, зураглалын тухай хууль 1992.12.28 2002.08.29 | Газрын зургийн удирдлага, зохион байгуулалтын журам 2015.11.26 /2016.01.01/ Хэмжил, зураглалын үр дүнг зохион байгуулах журам | Хэмжил зураглал, геомэдээллийн агентлаг National Administration of Surveying, Mapping and Geoinformation of China |
| http://en.nasg.gov.cn/lawsandregulations/ | | | |
| БНСУ | Үндэсний газар зүйн мэдээллийн системийг байгуулах, ашиглах тухай хууль, 2002 Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн хууль, 2009.02.06 Орон зайн мэдээллийн салбарыг дэмжих тухай 2010.10.03 | Дагалдан гарсан техникийн шаардлага, гарын авлага, стандарт, зааварчилгаануудтай | Газар, дэд бүтэц, тээврийн яам Ministry of Land, Infrastructure and Transport |
| http://gisc.lx.or.kr/UserFiles/pds/01_02_EN.pdf | | | |

Асуудал шийдвэрлэх зорилго тус бүрээр хийсэн судалгаа

Асуудал шийдвэрлэх зорилго А

“Суурь орон зайн өгөгдөл, мэдээллийн ангиллыг тодорхой болгох, тэдгээрийг бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг оролцоог сайжруулах замаар орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийн давхардлыг арилгах” зорилгын хүрээнд

Практикт төрийн байгууллагаас гаргаж буй мэдээллийг “баталгаажсан өгөгдөл” гэж үздэг. Баталгаажсан өгөгдөл гэдгийг тухайн өгөгдөл тодорхой нарийвчлалд ямар нэгэн чанарын алдаагүй байна гэж ойлгох ба хэрэглэгч өөрийн зорилгоор мэдээллийг хэрэглэх үед түүнийг нийлүүлж буй байгууллага, ихэнх тохиолдолд төрийн байгууллага, тухайн өгөгдлийн чанар, нарийвчлалд баталгаагаар хангадаг. Түүнчлэн орон зайн өгөгдлийн нэгэн онцлог чанар бол түүний хөрвөх чадвар буюу нэг төрлийн өгөгдөл олон зориулалтаар ашиглагдах байдал юм. Гэхдээ өгөгдлийн чанар (нарийвчлал, шинэлэг байдал, бүрэн бүтэн байдал гэх мэт) нь бүх төрлийн хэрэглээнд тохиромжтой байна гэсэн үг биш. Эдгээр онцлогоос хамааран баталгаатай суурь орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийг төрөөс хариуцаж хэрэглэгчдэд түргэн шуурхай түгээх нь чухал.

Дээрх онцлогийг харгалзан улс орнуудад суурь орон зайн өгөгдөл, мэдээллээ тогтоож, хариуцах байгууллагыг тодорхойлж, баталгаатай суурь орон зайн мэдээллийг түгээхэд онцгой анхаардаг байна. Сонгож авсан улс орнуудад судалж үзэхэд салбар тус бүр мэдээллээ ангилж бус өгөгдөл, мэдээллийн агуулга, онцлогоос хамааран ангилсан байна (Хүснэгт 5). Эдгээрийн дэлгэрэнгүй ангиллыг Гуравдугаар хавсралтад хавсаргав.

Хүснэгт 5 Орон зайн суурь өгөгдлийн ангиллын олон улсын судалгаа

| Улсын нэр | Суурь өгөгдлийн ангилал |
|------------------------------|--|
| Европын холбоо ¹¹ | <u>Хавсралт-1</u> Солбицлын тогтолцоонууд Газар зүйн торлолын систем Газар зүйн нэр Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж Хаяг Кадастрын нэгж талбарууд Авто замын шугам сүлжээ Ус зүй Тусгай хамгаалалтын газар нутаг <u>Хавсралт-2</u> Өндрийн зураг Газрын бүрхэвч Орто зураг Геологи |
| Шинэ Зеланд ¹² | Байрлал Кадастр, үл хөдлөх хөрөнгө Хаяг Агаар, сансрын зураг Газар ашиглалт, газрын бүрхэвч Газар зүйн нэр Засаг захиргааны нэгж Өндөр, гүн |

11 <https://inspire.ec.europa.eu/Themes/Data%20Specifications/2892>

12 <https://www.linz.govt.nz/about-linz/our-vision-strategy-and-values/our-location-strategy/geospatial-data-themes-and-datasets>

| | |
|------------------------|--|
| | Тээвэр Ус |
| Япон улс ¹³ | Геодезийн тулгуур цэг Далайн эргийн шугам Замын хил зааг Гол усны хил Засаг захиргааны хил Төмөр замын чиглэл Өндөр Эргийн шугам Барилга, байгууламжийн хил зааг Суурин газрын хил Гудамжны блокийн хил |
| АНУ ¹⁴ | Геодезийн тулгуур сүлжээний өгөгдөл Ортофото ¹⁵ зураг Өндрийн болон усны ёроолын зураг Зам, тээврийн сүлжээ Ус зүй (газрын болон далай тэнгисийн) Кадастр Засаг захиргааны нэгж, бусад төрлийн хил зааг Хаяг |
| БНСУ ¹⁶ | Засаг захиргааны нэгж Тээвэр Шугам сүлжээ Кадастр Усны нөөц Далай Байр зүй Геодези тулгуур цэг Агаар, сансрын зураг |
| Австрали ¹⁷ | Хаяг Засаг захиргааны хил Байрлалын сүлжээ Газрын нэр Үл хөдлөх хөрөнгө, газрын нэгж талбар Агаар, сансрын зураг Тээвэр Ус Өндөр, гүн Газрын бүрхэвч |

Дээр дурдсан улс орнуудын суурь орон зайн мэдээллийн ангилал, тэдгээрийн нэн тэргүүнд бэлэн байх шаардлагатай онцлог, хэрэгцээг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн орон зайн мэдээллийн менежментийн

¹³ <http://www.gsi.go.jp/kokusaikoryu/kokusaikoryu-e30057.html>

¹⁴ <https://www.fgdc.gov/policyandplanning/a-16/appendixe/20170324-ngda-themes-fgdc-sc-revised-appendixe.pdf>

¹⁵ Агаар, сансрын зурагт байрлал, өндрийн засвар хийгдэж боловсруулагдсан зураг

¹⁶ <http://www.ngii.go.kr/en/contents/contentsView.do?rbsIdx=57>

¹⁷ <https://link.fsdf.org.au/>

Зөвлөхүүдийн хороо¹⁸ (Зөвлөхүүдийн хороо) 2017 оны долоодугаар хуралдаанаар байвал зохих 14 суурь орон зайн мэдээллийн жагсаалтыг гишүүн улс орнуудад чиглэл болгохоор баталсан. Эдгээрт,

1. **Дэлхийн геодезийн тулгуур сүлжээ:** Дэлхий дээрх байрлалын мэдээллийг өндөр нарийвчлалтайгаар тодорхойлох, илэрхийлэх боломжийг олгохоос гадна орон зай, цаг хугацаанд дэлхийн өөрчлөлтийг тодорхойлоход хэрэглэгддэг. Бусад бүх төрлийн орон зайн өгөгдлийн найдвартай бүрдүүлэлт, нэгтгэл, ашиглалтад шаардлагатай үндсэн өгөгдөл юм.

2. **Хаяг:** Хаяг нь нэгэн төрлийн зохион байгуулалттай шошго ба гол төлөв өмчийн дугаар, замын нэр, орон нутгийн нэр зэргийг агуулдаг, тодорхой хэсэг газар, байшин, барилга байгууламж зэргийг тодорхойлоход газар зүйн солбицолтой хамт хэрэглэгддэг.

3. **Барилга, суурин газар:** Төрөл бүрийн зориулалтын барилга байгууламж. Суурин газар нь барилга байгууламжийн нийлэмж

4. **Өндөржилт, гүн:** Өндрийн тогтолцоотой хамааралтай газар дээрх болон усан доорх гадаргуугийн мэдээлэл

5. **Хил зааг:** Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хил, сонгуулийн тойргийн хил, статистикийн хил, хууль тогтоомжоор тодорхойлсон бусад хил, үйлчилгээ үзүүлэх хил гэх мэт

6. **Газар зүйн нэр:** Дэлхийн гадаргуу дээрх физик болон нийгэм, соёлын биетүүдийн байрлалыг илтгэдэг. Газар зүйн нэрс нь ихэвчлэн суурин газар, байгалийн биет гэх зэрэг бусад өгөгдлийн төрлийн төлөөлөл байдлаар хэрэглэгддэг.

7. **Геологи, хөрс:** Хөрс, ашигт малтмалын нөөц, геоморфологи, чулуулаг гэх мэт геологийн элементүүд

8. **Газрын бүрхэвч, ашиглалт:** Хүний гараар бүтсэн объект, хөдөө аж ахуйн талбай, ой, байгалийн цогцолбор газар, ус зэрэг дэлхийн гадаргын физик болон биологийн бүрхэвч. Нийгэм, эдийн засгийн зорилгыг хангах одоогийн ашиглалт болон ирээдүйн төлөвлөлтийн мэдээлэл

9. **Газрын нэгж талбар:** Нийтийн эзэмшлийн болон өмчлөл, ашиглалт бүхий нэгж талбарууд

10. **Ортозураг:** Хиймэл дагуул, агаараас авсан Дэлхийн гадаргууг дүрсэлсэн байрлалын засвар хийгдсэн зурган өгөгдөл. Хэдийгээр өгөгдлийн нэг

¹⁸ UN-GGIM – UN Committee of Experts on Global Geospatial Information Management <http://ggim.un.org/>

төрөл болохгүй ч гэсэн тайлал хийгдсэний дараа бусад бүх төрлийн өгөгдлийн багцуудад өргөн хэрэглэгддэг өгөгдлийн нэг нөөц.

11. **Дэд бүтэц:** Төрийн захиргааны байгууллага, хүн ам хамгааллын байрлалууд, сургууль, эмнэлэг гэх мэт засгийн газрын, аж үйлдвэрлэлийн үйлчилгээнүүд

12. **Хүн ам зүйн тархалт:** Хүн амын газар зүйн тархалт, хүн амын шинж чанарын мэдээлэл

13. **Тээврийн сүлжээ:** Авто зам, төмөр зам, шугам сүлжээ, ус хангамж/татуургын сүлжээ, дэд бүтцийн мэдээлэл

14. **Ус зүй:** Гол мөрөн нуур далай тэнгис тэдгээртэй холбоотой хил зааг, шинж чанар.

Монгол орны хувьд дээрх жагсаалтад өөрийн орны онцлогийг харгалзаж, “Түүх соёл, археологийн өв”, “Байр зүйн зураг” зэрэг хоёр ангиллыг шинээр нэмж, “Газрын бүрхэвч, ашиглалт” болон “Хөрс, геологи” зэрэг ангиллуудыг зааглах байдлаар 18 төрөл болгон баяжуулж, орон зайн суурь өгөгдлийн хүрээ, тэдгээрийн техникийн үзүүлэлтийн стандартыг Монгол Улсын Шадар сайдаар ахлуулсан Газрын шинэтгэлийн үндэсний хорооны 5 дугаар хурлаар хэлэлцүүлж, батлуулаад байна (Хавсралт 4).

Асуудал шийдвэрлэх зорилго В

“Орон зайн өгөгдөл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандартын нэгдсэн тогтолцоо бий болгох замаар баталгаатай, шинэлэг, чанартай орон зайн мэдээллийг шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээх боломжийг бүрдүүлэх” зорилгын хүрээнд

Баталгаатай, шинэлэг, чанартай орон зайн мэдээллийг шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээх боломжийг орон зайн стандартын тогтолцоо олгодог. Орон зайн стандартууд нь төрөл бүрийн эх сурвалжийн байрлалд суурилсан мэдээллийн нэгдмэл байдал (interoperability¹⁹)-ыг хангахад зориулагдсан интерфэйс болон кодчиллыг тодорхой тусгасан техникийн баримт бичиг.

¹⁹ Тайлбар: Interoperability буюу нэгдмэл байдал гэдэг нь системийн синтактик, схемийн болон семантик түвшинд мэдээлэл солилцох үйл ажиллагаа юм.

- Сүлжээний протоколын нэгдмэл байдал-бүрэлдэхүүн хэсгүүдийн үндсэн холбоо
- Стандарт интерфэйсийн тодорхойлолтууд-Remote системд байгаа клиент хэрэглээний программ хангамжийг удирдах боломж.
- Өгөгдөл дамжуулах нэгдмэл байдал-Өгөгдөл болон үйлчилгээг мэдээллийн форматаас хамааралгүйгээр солилцох.
Семантик нэгдмэл байдал-Өгөгдлийг ижил хэлбэрээр дүрслэх хөрвүүлэлтийн хэрэглээний программ хангамж.

Стандартчилагдсан болон бүтэцлэгдсэн мэдээллийн аюулгүй байдлыг ханган хадгалах, шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээхэд үр ашигтай. Олон улсад энэ чиглэлээр Олон улсын стандартчиллын байгууллага (ISO), Нээлттэй Орон зайн консорциум (OGC) зэрэг байгууллагууд боловсруулж гаргадаг.

Монгол Улсад орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой 20 стандарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

- Газар зүйн мэдээлэл – Мета өгөгдөл MNS 5774:2007
- Газар зүйн мэдээлэл – Нэр томъёо MNS-ISO-TC-19104:2012
- Газар зүйн мэдээлэл - Геодезийн байнгын цэг тэмдэгтийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-1 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Байр зүйн зургийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-2 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Газар зүйн нэрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-3 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Газар ашиглалтын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-4:2021
- Газар зүйн мэдээлэл - Газрын бүрхэвчийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-5 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Барилга, байгууламжийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-6 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Дэд бүтцийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-7 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Зам тээврийн сүлжээний орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-8 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Инженер - геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-9 : 2021
- Газарзүйн мэдээлэл - Кадастрын нэгж талбарын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-10 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Орто-зураглалын орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-11 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Өндрийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-12 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Түүх, соёл, археологийн өвийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-13 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Ус зүйн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-14 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-15 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Хил заагийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-16 : 2021

- Газар зүйн мэдээлэл - Хөрсний орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-17 : 2021
- Газар зүйн мэдээлэл - Хүн ам, нийгмийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-18 : 2021

Уг 20 стандарт нь орон зайн мэдээллийн үйлдвэрлэл, ашиглалтад хангалттай биш бөгөөд өгөгдлийн загварчлалын стандарт, мэдээллийн сангийн стандарт, өгөгдөл, мэдээлэл солилцох, дамжуулах стандарт, өгөгдлийн чанарын стандарт, өгөгдөл хоорондын нэгдмэл байдлын стандарт зэрэг олон стандартууд шаардлагатай. Цаашид боловсруулах шаардлагатай олон улсын стандартын дэлгэрэнгүйг тавдугаар хавсралтад жагсаав.

Асуудал шийдвэрлэх зорилго С

“Орон зайн өгөгдөл, мэдээллийг түгээх, ашиглах, солилцох зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх бүрдүүлэгч, хэрэглэгчийн үүрэг, хариуцлага, эрх, нөхцөл, хязгаарлалтын (лицензийн) асуудлыг тодорхой болгох замаар орон зайн мэдээлэлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих” зорилгын хүрээнд

Олон улсад орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалт, өгөгдлийн нээлттэй байдал, өгөгдлийн лиценз болон төлбөр, өгөгдлийн стандарт, аюулгүй байдал, өгөгдлийн баталгаат байдал зэрэг асуудлаар сайн туршлага, мэдлэг солилцож байснаас харахад хууль, бодлогын орчны хүрээнд улс бүр тодорхой асуудалтай тулгарч байна. Ихэнх тохиолдолд хууль, бодлогын орчин нь орон зайн өгөгдөл, мэдээллийг хэрэглэх, үйлчилгээг нэмэгдүүлэх, шинэлэг технологийг нэвтрүүлэх үйл ажиллагаанаас үргэлж нэг алхам хоцорч, үүнээс үүдэн орон зайн мэдээллийг бүрдүүлэх, хэрэглэх, хуваалцахтай холбогдсон эрх зүйн тогтолцоо тодорхой бус байдаг.

Аливаа өгөгдлийг төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, эсхүл хувь хүн бүрдүүлэх нь тодорхой. Харин тэдгээр субъектүүд хоорондоо өгөгдлөө солилцоход тухайн өгөгдлийг ашиглах, солилцох лицензийн асуудал үүсдэг. Өгөгдлийн төрөл бүр нь түүнийг хэрэглэх нөхцөл, хязгаарлалт, дүрэмтэй.

Сүүлийн жилүүдэд орон зайн өгөгдөл, мэдээллийн лицензийн талаарх асуудлууд өргөн хүрээг хамаарч НҮБ-ийн зүгээс үндсэн асуудлуудыг олон улсын түвшинд хөндөж байна. Орон зайн хууль, бодлогын төв (Centre for Spatial Law and Policy), UN-GGIM хамтран олон улсын түвшинд хэрэглэгдэж болохуйц орон зайн мэдээллийн лицензтэй холбоотой бүхий л асуудлыг хамаарсан “Орон зайн өгөгдөл, мэдээллийн лицензийн хураангуй тайлбар²⁰”-ыг гаргасан. Тус хураангуй тайлбарт

²⁰ Compendium on Licensing of Geospatial Information http://ggim.un.org/meetings/GGIM-committee/8th-Session/documents/E-C20-2018-9-Add_2%20Legal_and_Policy_Frameworks_rev.pdf

лицензийн хэд хэдэн элементүүдийг зааж асуудал шийдвэрлэхэд гишүүн орнуудад анхаарахыг зөвлөсөн байдаг. Тухайлбал,

Орон зайн мэдээллийн лицензийн хувьд хэд хэдэн **хууль эрх зүйн асуудал** урган гардаг байна. Эдгээрт:

- Хувийн нууц
- Оюуны өмчийн эрх
- Төлбөр/хариуцлага
- Нээлттэй өгөгдөл
- Үндэсний аюулгүй байдал

Нууцлал

Орон зайн өгөгдөл, мэдээллийг солилцох, түгээхэд мэдээллийн нууцлал, хамгаалалтын асуудал хөндөгддөг. Энэ нь мөн л түүний биет бус чанар, түгээх хэлбэр, мэдээллийн нууц, зохиогчийн эрх, оюуны өмчийн эрхийг хамгаалахтай холбоотой юм. Орон зайн өгөгдөл, мэдээлэл нь нууц мэдээлэл агуулсан, эсвэл агуулсан байж болзошгүй, төрийн нууц мэдээллийн жагсаалтад багтсан бол түүнийг хэрэглүүлэх түгээхэд хязгаарлалт тогтоох ба лицензийн гэрээгээр өгөгдөл, мэдээллийг хамгаалах, нууцлалын тухай хууль тогтоомжтой холбоотой талуудын хариуцлагыг тусгах хэрэгтэй. Орон зайн мэдээлэл, технологийн үсрэнгүй хөгжил нь байрлалд суурилсан мэдээлэл, бүтээгдэхүүнийг хэрэглүүлэх, түгээхэд мэдээллийн нууцлалыг хамгаалах асуудал, хариуцлагын хууль эрх зүйн орчныг улам боловсронгуй болгохыг шаардаж байна.

Орон зайн өгөгдөл мэдээллийн аюулгүй байдлыг хангах, нууцлалыг хамгаалах бодлого, журмын зохицуулалтын талаар засгийн газрын түвшинд шийдвэр гаргах нь илүү үр дүнтэй юм.

Монгол улс орон зайн өгөгдлийн аюулгүй байдал, өгөгдлийг тоон хэлбэрт хадгалахтай холбоотойгоор “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн. Мөн мэдээллийн аюулгүй байдал, нууцлалтай холбоотой “Үндсэн хууль”-ийн 16-ын 17-р заалт, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай”, “Байгууллагын нууцын тухай” “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, шаардлага”, “Мэдээллийн аюулгүй байдлын үйл ажиллагааны дүрэм” зэрэг MNS стандартууд байдаг.

Оюуны өмчийн эрх

Монгол улсын “Оюуны өмчийн тухай” хуульд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг хамгаалах, оюуны өмчийн эдийн засгийн эргэлтийг дэмжих талаар заасан байхаас гадна лицензийн гэрээний журмыг засгийн газар хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Орон зайн өгөгдөл мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээ нь биет бус бөгөөд оюуны өмчтэй холбоотой эрхзүйн баримт бичгээр зохицуулагдаж, хамгаалагдаж байдаг. Оюуны өмч нь өөрийн гэсэн үнэ цэнэ бүхий, эдийн засгийн эргэлтэд оруулан ашиг олж болох хөрөнгө юм.

Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд худалдах, өөр бизнес болгон хөгжүүлэх, хамтран ажиллаж ашиг хүртэх, лицензийн болон бусад төрлийн гэрээгээр ашиглуулах замаар оруулдаг. Оюуны өмчийг эрх шилжүүлэх, лицензийн, мерчендайзингийн, франчайзингийн, барьцааны зэрэг гэрээгээр ашиглуулдаг бөгөөд олон улсад орон зайн өгөгдөл, мэдээллийн бүтээгдэхүүн үйлчилгээг түгээх, солилцоход лицензийн гэрээг ашиглаж байна. Лицензийн гэрээ нь лиценз олгогч нь өмчлөлийнхөө бүтээл, бүтээгдэхүүнийг лиценз авагчид гэрээнд заасан эрхзүйн болон хэрэглүүлэх нөхцөл болзлын дагуу ашиглах эрх олгох, хэлбэр, төлбөрийг тодорхойлсон тохиролцоо юм.

Төлбөр

Орон зайн өгөгдөл, мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, түгээхэд тодорхой хэмжээний зардал гардаг бөгөөд нээлттэй бус орон зайн мэдээллийг ашиглуулахад төлбөртэй байж болдог. Өгөгдөл, мэдээлэл, бүтээгдэхүүн үйлчилгээнд тогтоосон үнээр шууд худалдан авалтаар үйлчилгээ авч болох ба ашгийн зориулалттай лицензийн гэрээнд төлбөрийн нөхцөлийг тусгаж өгдөг.

Манай оронд орон зайн өгөгдөл, мэдээллийг цахимаар түгээх, борлуулах, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнийг тодорхойлсон хууль, дүрэм журам, нэгдсэн бодлого одоогоор байхгүй.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь үйл ажиллагааныхаа хүрээнд бүх хэрэглэгчдэд орон зайн суурь өгөгдөл, архивын цаасан бичиг, баримтаар хангах ажлыг дор дурдсан хууль тогтоомжийн дагуу хийж байна. Үүнд:

- Төрийн болон албаны нууцын тухай хууль,
- Геодези, зураг зүйн тухай хууль,
- Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль,
- Архивын тухай хууль,
- Цахим гарын үсгийн тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”-ын баримт бичиг
- “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр” батлах тухай Засгийн газрын 2006 оны 64 тоот тогтоол;
- “Цахим засаг” үндэсний хөтөлбөр Засгийн газрын 2012 оны 101 тоот тогтоол;
- “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам” Засгийн газрын 2017 оны 6 сарын 7-ны өдрийн 159 дүгээр тогтоол
- Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам Засгийн газрын 2017 оны 12 сарын 14-ний өдрийн 411 дүгээр тогтоол
- ГЗБГЗЗГ-ын даргын 2013 оны 9 сарын 18-ны өдрийн А/258 дугаар тушаалаар батлагдсан Мэдээллийн төвөөс баримт /нууц болон нууц биш/ ашиглуулах, буцаан авах, мэдээллийн төвд шинээр баримт хүлээн авах журам

- Төрийн архивын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай Архивын ерөнхий газрын даргын 2021 оны 03 сарын 12-ны өдрийн А/24 дүгээр тушаал

ГЗБГЗЗГ дээр дурдсан тушаалын дагуу хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байгаа ба 2017 оны 3 дугаар улирлын байдлаар Төрийн архивын 3 сан нийт 3823000 төгрөгийг улсын төсөвт оруулсан. Үүнд:

- Геодези, байр зүй, зураг зүйн бүтээгдэхүүн, кадастрын мэдээллээр нийт 76 байгууллага, иргэнд 159 баримтын 420 ХН-ээр үйлчилж 2257000 төгрөгийн орлого
- Газар зохион байгуулалтын мэдээллийн сан байгууллагын хэрэгцээнд тайлан, мэдээ, материалаар 65 мэргэжилтэнд нийт 199 ХН-ийн мэдээллээр, 30 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд нийт 199 хадгаламжийн нэгжийн мэдээллээр үйлчилж нийт 1 366000 төгрөгийн орлого
- АСЗМС-ийн тайлан, мэдээ, материалаар байгууллагын 15 мэргэжилтэнд нийт 25 ХН-ийн мэдээллээр, 5 аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд нийт 50 ХН-ийн мэдээллээр үйлчилж нийт 200000 төгрөгийн орлого оруулсан.

ГЗБГЗЗГ-ын Төрийн архивын 4 сан хөмрөгт нийт 37 төрлийн 43 000 ХН нэгж бүхий баримт материал хадгалагдаж байгаагаас байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн байнга ашигладаг цаасан суурьтай болон тоон баримтын судалгааг **Error! Reference source not found.**-д үзүүлэв.

| Д/д | Төрийн болон ААНБ, байгууллагын албан хаагчдын хэрэглээнд гаргасан баримтын тоо, хэмжээ төрөл | 2013 он | | 2014 он | | 2015 он | | 2016 он | |
|-----|---|----------------------|--------|---------|--------|---------|--------|---------|--------|
| | | Хадгаламжийн нэгжээр | | | | | | | |
| | | Тоон | Цаасан | Тоон | Цаасан | Тоон | Цаасан | Тоон | Цаасан |
| 1 | Нийтийн болон нууцын зэрэглэлтэй жижиг, дунд, масштабын байр зүйн зураг | 1584 | 2140 | 1089 | 1897 | 897 | 1789 | 1025 | 958 |
| 2 | Геодезийн цэг тэмдэгтийн өгөгдөл, хувийн хэрэг, | 6589 | 254 | 3541 | 320 | 1594 | 158 | 958 | 97 |
| 3 | Геодези зураг зүйн ажлын тайлан | 250 | 189 | 105 | 210 | 98 | 78 | 120 | 75 |
| 4 | Кадастрын зураг | 1849 | - | 678 | - | 759 | - | 578 | - |
| 5 | Кадастрын зураглалын ажлын тайлан | 20 | 78 | 15 | 35 | 23 | 51 | 14 | 41 |
| 6 | Улсын болон аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө | 20 | 20 | 21 | 25 | 18 | 26 | 17 | 15 |
| 7 | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажил | 154 | 200 | 145 | 198 | 178 | 215 | 137 | 167 |
| 8 | Газрын нэгдмэл сангийн тооллогын баримт | 78 | 50 | 80 | 78 | 45 | 67 | 59 | 71 |
| 9 | Хөрс, ургамлын судалгаа | - | - | - | - | - | - | 25 | - |
| 10 | Уур амьсгалын зураг | - | - | - | - | 15 | 21 | 17 | 10 |
| 11 | Аж ахуйн дотоодын газар зохион байгуулалтын тайлан | - | 55 | - | 30 | - | 67 | - | 25 |
| 12 | Атар, бэлчээр, газар зохион байгуулалт, хөрс, ургамалын судалгааны баримт | - | 70 | - | 55 | - | 47 | - | 87 |
| 13 | Тариалангийн талбайн төлөв байдал, чанарын хянан баталгааны ажил | 40 | 40 | 32 | 45 | 57 | 67 | 62 | 59 |
| 14 | Агаарын зураглалын ажлын журнал | - | 5 | - | - | - | 3 | - | - |
| 15 | Бүх төрлийн масштабын агаарын зураг | 50 | - | 38 | - | 78 | - | 115 | - |
| 16 | Ортофото зураг | 510 | - | 328 | - | 458 | - | 678 | - |
| 17 | Сансрын зураг | 125 | - | 98 | - | 57 | - | 145 | - |
| 18 | Агаарын зураглалын ажлын өгөгдөл, тайлан | - | 15 | - | 5 | - | 3 | - | 7 |
| 19 | Түүхэн болон сэдэвчилсэн зураг | - | 10 | - | 15 | - | 8 | - | 21 |
| 20 | Цалин, НДШ-ийн лавлагаа | - | 65 | - | 78 | - | 53 | - | 92 |
| 21 | Ирсэн, явсан бичгийн хуулбар | - | 600 | - | 358 | - | 587 | - | 798 |
| 22 | Тушаал, шийдвэрийн хуулбар | - | 550 | - | 678 | - | 874 | - | 782 |
| 23 | Нотлох баримт гаргах | - | 15 | - | 20 | - | 18 | - | 24 |

Дээрх судалгаанаас харахад цаасан суурьтай баримтаар үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн тоо жил ирэх тусам багасаж, цахим мэдээллээр, ялангуяа байр

зүйн зураг, үйлчлүүлэгчдийн тоо өссөн үзүүлэлт харагдаж байгаа нь техник технологийн дэвшилттэй холбоотой бөгөөд цаасан суурьтай баримтаар үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгчдийн цаг хугацааг их үрсэн, ашиглахад хүндрэлтэй асуудлууд их байдагтай холбоотой юм.

Архивын ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/24 ²¹дугаар тушаалаар “Төрийн архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-г шинэчлэн тогтоосон тушаалын дөрөвдүгээр хавсралтаар “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээг” батлан гаргасан. Тус үнийн жагсаалтын сул тал нь тухайн орон зайн өгөгдлийн шинж чанар, объектын тоо, цаг хугацааны итгэлцүүр, талбайн хэмжээнээс үл шалтгаалж шууд оноох байдлаар нэгжийн үнийг тогтоосон байна.

ГЗБГЗЗГ-т 2012-2021 оны хооронд үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн суурь мэдээллийг бий болгох, хаягийн мэдээллийн систем байгуулах, газрын кадастрын мэдээллийн санг солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэн нийт 18 суурь орон зайн өгөгдөл, 240 гаруй дэд ангилал бүхий тоон мэдээлэлээр байгууллагын орон зайн өгөгдлийн мэдээллийн санг үүсгэснээр орон зайн өгөгдөл, мэдээллийг иргэд, олон нийтэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн. Дээрх 18 суурь орон зайн өгөгдөл, 240 гаруй мэдээллээс, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний жагсаалтад 3 төрлийн 87 дэд ангилалын мэдээлэл багтсан бөгөөд ихэнх мэдээллийн үнийг орхигдуулсан.

“Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх” ажлын хүрээнд орон зайн өгөгдөл, мэдээлэл түгээх үйлчилгээний төлбөр тогтоох динамик шинж чанартай аргачлалыг олон улсын туршлагад үндэслэж боловсруулсан.

Нээлттэй өгөгдөл

Аливаа өгөгдөл, мэдээллийг цахимаар дамжуулан авч хэрэглэх үзэгдэл ихэссэнтэй холбогдуулан интернет орчин ашиглаж, хаанаас ч хандах боломжийг бүрдүүлэх алхмуудыг шат дарааллан хэрэгжүүлж эхлэв. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011), Шилэн дансны тухай хууль (2014), Засгийн газрын 159 дүгээр тогтоол (2017) болон Засгийн газрын үйл ажиллагааны 2020 хүртэлх төлөвлөгөөнд тусгасан нээлттэй өгөгдлийн бодлого боловсруулах, нээлттэй өгөгдөлд суурилсан хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2020 оны 05 дугаар сард Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хэрэгжүүлж байгаа Дэлхийн банкны санхүүжилттэй Ухаалаг засаг төслийн хүрээнд мэдээллийн технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа оновчтой ашиглах замаар төрийн үйлчилгээг илүү үр ашигтай, ил тод, хүртээмжтэй болгох, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эдийн

²¹ <https://www.gazar.gov.mn/p/487>

засгийн боломжийг бий болгох, баялаг бүтээх, инновацийг дэмжих зорилгоор төрийн өгөгдлийг иргэдэд нээлттэйгээр ашиглуулах "Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал"-ыг хөгжүүлж, ашиглалтад оруулав. ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/217 тоот тушаалаар Нээлттэй өгөгдлийн жагсаалтыг батлуулж, тус портал дээр орон зайн өгөгдөл, мэдээлэл, тайлан судалгааг байршуулж эхлээд байна (Хавсралт 6).

Үндэсний аюулгүй байдал

Батлан хамгаалах, тагнуулын байгууллагуудаас зарим байрлалтай холбогдсон орон зайн мэдээлэл нь улсын аюулгүй байдалд нөлөөлнө гэж үздэг учир ихэнх улс орнууд Үндэснийхээ аюулгүй байдлыг хамгаалах үүднээс орон зайн мэдээлэлд хязгаарлалт тавьдаг. Олон улсын туршлагаас харахад өндөр нарийвчлалтай батлан хамгаалах зорилгоор ашигладаг хиймэл дагуулын зурагт хязгаарлалт тавьж, нууцалдаг байна.

Манай орны хувьд том масштабын байр зүйн зургийн зарим элементийг нууцын зэрэглэлтэй болгож, нийтэд задруулахгүй түгээхгүй байхаар зохицуулдаг.

Орон зайн мэдээллийн лицензлүүлэхэд анхаарах зүйлс:

- Өгөгдлийн төрөл
- Зохиогчийн эрхийн асуудал
 - Өгөгдөл
 - Газрын зураг
- Өгөгдлийн чанартай холбоотой хариуцлага
- Хувь хүний нууц/төрийн нууц
- Нээлттэй бүртгэл, мэдээллийн эрх чөлөө

Орон зайн өгөгдлийн лицензийн элементүүд:

Юуг лицензлүүлэх тухай:

- Агаар сансрын зураг /түүхий, боловсруулсан/
- Өгөгдөл – GPS, хаяг, солбицол, өгөгдлийн сан гэх мэт
- Мета өгөгдөл
- нэр томъёог тодорхой болгох
- юуг лицензлүүлэхгүй тухай тодорхой заах

Лиценз олгогчийн олгох лицензийн төрөл

- Хуулбарлах
- Ашиглах
- Нийтлэх
- Боловсруулж гаргасан бүтээгдэхүүн, мэдээ
- Бусад

Ашиглах эрхүүд:

- Эрхийн хугацаа
- Онцгой эрх/хязгаарлалт
- Арилжааны болон арилжааны бус

- Хил хязгаар
- Хэлбэр /хэвлэмэл, тоон вектор өгөгдөл гэх мэт/

Ашиглах эрх дэх хязгаарлалт:

- Тодорхой этгээдэд өгөх хязгаарлалт/хориглолт
- Тодорхой хэрэглээнд тавигдах хязгаарлалт/хориглолт
- Зөвхөн арилжааны бус ашиглалт

Төлбөрийн талаар анхаарах асуудал

- Бэлэн
 - Шууд
 - Тодорхой хугацаанд
 - Итгэл
- Мөнгөн тэмдэгт/валют
- Төрөл
 - Үйлчилгээ
 - Өгөгдөл, мэдээлэл

Манай Улсын хувьд орон зайн өгөгдөл, мэдээлэл, үйлчилгээг түгээх, ашиглуулах, солилцоход үүсэх дээр дурдсан лицензийн асуудлын зохицуулалт байхгүй.

Дэлхийн нийтэд орон зайн мэдээллийн лицензийн асуудал

АНУ нь 1994 онд хамгийн анхны геопортал үүсгэж байжээ. Тухайн улсын Холбооны газарзүйн мэдээллийн хороо “ Federal Geospatial Data Committee (FGDC)” нь төлбөр тооцооны сүлжээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж байсан байна. Орон зайн мэдээллийг ихэвчлэн өгөгдөл цуглуулагчаас хэрэглэгчдэд зардаг байсан бол орон зайн мэдээллийн зах зээл хөгжсөн өнөө үед орон зайн мэдээллийг зарахаас илүүтэйгээр нэг талаас нөгөө тал руу лицензлүүлдэг болсон. Өнөөгийн байдлаар олон улсад өгөгдлийн багцад түгээмэл хэрэглэгддэг орон зайн лицензийн төрлүүдийг судалж үзэхэд Open data commons, Creative commons, Community Data License Agreement гэх лицензүүдийг хэрэглэгчид түгээмэл хэрэглэж байна. Олон орны туршлагаас үзэхэд албан байгууллагууд, хүрээлэнгүүд, засгийн газрууд өгөгдөл хуваалцах зорилгоор *Creative Commons* лицензийг ашиглаж байна.

Creative commons лиценз

Creative Commons (CC) лиценз нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан “бүтээл”-ийг үнэгүй түгээх боломжийг олгодог олон нийтийн зохиогчийн эрхийн лицензүүдийн нэг бөгөөд анх 2002 онд АНУ-ийн ашгийн бус байгууллага гаргасан.


Creative Commons нь дэлхийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд мэдлэг, бүтээлч сэтгэлгээгээ хуваалцахад тулгарч буй хууль эрх зүйн орчны бэрхшээлийг зохицуулахад тусалдаг ашгийн бус байгууллага бөгөөд мэдээллийн хэрэгслээр дамжуулан хуулийн хүрээнд мэдлэг мэдээлэл хуваалцах, ашиглах боломжийг олгодог бөгөөд зохиогчийн эрхийн "бүх эрх хуулиар хамгаалагдсан" гэсэн үндсэн ойлголтыг "зарим эрх хуулиар хамгаалагдсан" болгон өөрчлөх

боломжийг олгож байгаа юм. Мөн дэлхийн хэмжээнд лицензийнхээ үйл ажиллагааг баталгаажуулахын тулд оюуны өмчийн мэргэжилтнүүдтэй хамтран ажилладаг.

Creative Commons лицензийн төрлүүд:



CC BY: Энэхүү лиценз нь мэдээ, мэдээлэл, дүрсийг ямар ч хэлбэрээр хуулж, тараах, материалыг засах, өөрчлөх, шинэчлэх мөн арилжааны зорилгоор ашиглах боломжтой.



CC BY-SA: Энэхүү лиценз нь мэдээ, мэдээлэл, дүрсийг түгээх, засах, өөрчлөх боломжийг олгодог бөгөөд арилжааны зорилгоор ашиглахыг зөвшөөрдөг. Таны өгөгдөл материал дээр үндэслэсэн бүх шинэ бүтээлүүдийг ижил нөхцөлөөр лицензлүүлэх ёстой.

Энэхүү лицензийг ихэвчлэн “copyleft” үнэгүй, нээлттэй эхийн программ хангамжийн лицензтэй харьцуулдаг. ижил лицензтэй байх тул деривативууд нь арилжааны зориулалтаар ашиглахыг зөвшөөрнө. Энэ бол Википедиагийн ашигладаг лиценз юм.



CC BY-NC: Энэхүү лиценз нь бусдад танай мэдээ, мэдээлэл, дүрсийг арилжааны бус хэлбэрээр засах, тараах, өөрчлөх боломжийг олгодог бөгөөд хэдийгээр тэдний шинэ бүтээлүүд таныг хүлээн зөвшөөрч, арилжааны бус шинж чанартай байх ёстой боловч тэд өөрсдийн үүсмэл бүтээлээ ижил нөхцөлөөр лицензлэх шаардлагагүй юм.



CC BY-NC-SA: Энэхүү лиценз нь танд зээл өгч, шинэ мэдээ, мэдээлэл, дүрсийг ижил нөхцөлөөр лицензлүүлсэн тохиолдолд бусдад таны бүтээлийг арилжааны бус хэлбэрээр засах, өөрчлөх, шинэчлэх боломжийг олгодог.



CC BY-ND: Энэхүү лиценз нь өөрчлөгдөөгүй, бүхэлд нь танд олгосон зээлээр дамжуулагдсан тохиолдолд арилжааны болон арилжааны бус хэлбэрээр дахин хуваарилах боломжийг олгодог.



CC BY-NC-ND Энэхүү лиценз нь манай зургаан үндсэн лицензээс хамгийн хязгаарлагдмал нь бөгөөд ямар ч зөөвөрлөгч эсвэл форматаар зөвхөн тохируулгагүй хэлбэрээр, зөвхөн арилжааны бус зорилгоор хуулж, түгээх боломжийг олгодог.

Creative Commons олон нийтийн домэйн:



CC0 (CC Zero гэж нэрлэдэг) нь зохиогчид зохиогчийн эрхээсээ татгалзаж, бүтээлээ дэлхийн нийтийн хүртээл болгох боломжийг олгодог олон нийтийн зориулалтын хэрэгсэл юм. CC0 нь дахин хэрэглэгчдэд материалыг ямар ч нөхцөлгүйгээр, ямар ч орчин,

хэлбэрээр тараах, өөрчлөлт хийх, шинэчлэх, суурилуулах боломжийг олгодог.

Creative commons лицензийн элементүүд:



BY “BY” гэдэг нь атрибутыг илэрхийлнэ (зохиогч болон бусад этгээдэд хамааруулахаар заасан этгээдэд зээл олгох үүрэг). CC BY нь тухайн агуулгыг ашиглах хязгааргүй лиценз олгодог. Мэдээ, мэдээлэл, дүрсийг ямар ч хэлбэрээр хуулж, тараах, материалыг засах, өөрчлөх, шинэчлэх мөн арилжааны зорилгоор ашиглах боломжтой.



NC Бусдад бүтээлээ хуулах, түгээх, үзүүлэх, сурталчлах, өөрчлөх, ашиглахыг зөвшөөрдөг ба арилжааны зорилгоор ашиглахаас бусад зорилгоор ашиглах боломжтой.



SA Мэдээ, мэдээлэл, дүрсийг хувиргаж өөрчлөн бусдад хуулах, үзүүлэх, түгээх, сурталчлах, өөрчлөхийг хүсвэл эх хувьтай ижил лицензийн дагуу лицензлүүлэх ёстой.



ND Бусдад мэдээ, мэдээлэл, дүрсний эх хувийг хуулбарлах, түгээх, үзүүлэх, сурталчлахыг зөвшөөрдөг. Харин өөрчлөхийг хүсвэл зөвшөөрөл авах ёстой.

CC BY лицензийн үүрэг:

- Зохиогчийн болон атрибутыг хүлээн авахаар томилогдсон бусад этгээдийн захиалсан атрибутын хэлбэр нь боломжийн л бол лиценз олгогчийн хүссэн аргаар нэрлэсэн байх ёстой.
- Лиценз олгогчоос ирүүлсэн бол зохиогчийн эрхийн мэдэгдэл, CC-ийн лицензийн талаарх лавлагааг (CC-ийн вэбсайтын холбоос болгон ашиглах нь зүйтэй), баталгаа, хариуцлагын талаарх мэдэгдэл, анхны эх сурвалжтай холбогдсон холбоосыг хадгалах шаардлагатай.
- Бүтээлийг шинэчилсэн хувилбараар хуваалцсан бол өөрчлөгдсөн хувилбар гэдгийг зааж өгөх ёстой. Өөрчлөлтийн талаарх өмнөх заалтыг хэвээр хадгалах ёстой.
- Лиценз эзэмшигч нь тэдгээрийн ашиглалтыг лиценз олгогч эсвэл аливаа шинж чанарыг хүлээн авахаар товлосон этгээд баталж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх ёсгүй.

CC BY тавигдах шаардлага:

- Зохиогчийн эрхийн талаарх бүх мэдэгдлийг оруулах. Хэрэв уг бүтээлд зохиогчийн эрх эзэмшигчийн байрлуулсан зохиогчийн эрхийн тухай мэдэгдэл байгаа бол уг мэдэгдлийг хэвээр үлдээх буюу бүтээлийг дахин хэвлэж буй орчинд үндэслэлтэйгээр хуулбарлах шаардлагатай.
- Зохиогчийн нэр, дэлгэцийн нэр эсвэл хэрэглэгчийн ID гэх мэтийг иш татна уу. Хэрэв бүтээл интернэтэд нийтлэгдэж байгаа бол тухайн нэрийг тухайн хүний профайл хуудас руу холбох.
- Нэр, гарчгийг иш татах. Хэрэв бүтээлийг интернэтэд нийтэлж байгаа бол нэр, гарчгийг нь эх бүтээлтэй нь шууд холбож өгөх.

- Бүтээлийн дор байгаа тусгай CC лицензийг иш татах. Хэрэв бүтээлийг Интернет дээр нийтэлж байгаа бол лицензийн эшлэл нь CC вэбсайт дээрх лицензтэй холбоотой байх.
- Бүтээл нь үүсмэл бүтээл эсвэл шинэчилсэн ажил болсныг дурдана уу. Дээрхээс гадна тэдний бүтээл нь дериватив бүтээл болохыг олж мэдэх хэрэгтэй, жишээлбэл, "Энэ бол [зохиогчийн] Финлянд хэл дээрх [анхны бүтээлийг] орчуулсан бүтээл юм." эсвэл "[анхны бүтээл] дээр үндэслэсэн [зохиолч] зохиол."

Мэдээ, мэдээлэл, дүрсийг онлайнаар үнэн зөвөөс үл хамааран чөлөөтэй хуваалцах болсон энэ ертөнцөд Creative Commons (CC) нь бусад хүмүүст дахин ашиглах, судалгаа шинжилгээний ажлыг хялбархан хийх боломжийг олгосон.

Creative commons-ийн лицензүүд нь боловсролын нөөц, хөгжим, гэрэл зураг, мэдээллийн сан, засгийн газрын болон олон нийтийн салбарын мэдээлэл, бусад олон төрлийн материалыг багтаасан байдаг. Харин лицензээ өгөхийг зөвлөдөггүй бүтээлүүдийн цорын ганц ангилал бол компьютерын программ хангамж, техник хангамж юм.

Шинжлэх ухааны салбараас PLOS (Public Library of Science), BioMed Central, Hindawi, Nature Publishing group гэх мэт олон газар CC лиценз ашигладаг.

Эдгээрээс цөөн хэдэн газруудыг үзвэл:



PLOS (Public Library of Science) нь эрдэм шинжилгээний болон анагаах ухааны хэвлэн нийтлэх ашгийн бус байгууллага бөгөөд эрдэмтэн, эмч нарт хамгийн чухал бүтээлээ хэвлэн нийтлэх өндөр чанартай, нэр хүнд бүхий сэтгүүлээр хангадаг. Нээлттэй хандалтын загварын дагуу PLOS сэтгүүлийг онлайнаар шууд авах боломжтой бөгөөд үүнд Creative Commons Attribution Лицензэд заасны дагуу зохиогч (ууд) ба эх сурвалжийг дурдсан тохиолдолд нэвтрэх төлбөргүй бөгөөд дараа нь дахин хуваарилах, ашиглахад хязгаарлалт хийхгүй.



BioMed Central нь STM (Шинжлэх ухаан, технологи, анагаах ухаан) хэвлэн нийтлэгч бөгөөд нээлттэй нэвтрүүлгийн хэв загварыг анх санаачилж, 2008 онд Спрингер Верлаг худалдан авсан юм. BioMed Central нь судалгааны үр дүнгийн хурдан бөгөөд үр дүнтэй харилцаа холбоог хангахын тулд судалгаанд нээлттэй хандах боломжийг зайлшгүй чухал гэж үздэг.

Open data commons

2008 оны 3-р сард анхны нээлттэй мэдээллийн лицензийг Public Domain Dedication and License (PDDL) эхлүүлсэн. Энэхүү вэбсайтын эх кодыг Github-ээр дамжуулан MIT лицензээр авах боломжтой.

Open data commons лицензийн төрлүүд:

1. Open Data Commons Open Database License (ODbl) Нээлттэй мэдээллийн баазын лиценз – Attribution Share-Alike for data/databases
2. Open Data Commons Атрибутын лиценз- "Attribution for data/databases "

3. Open Data Commons Public Domain Dedication and License (PDDL) Олон нийтийн домэйн зориулалт ба лиценз- Public Domain for data/database

| | |
|-------------|--|
| ODC-BY | Энэхүү лиценз нь хэрэглэгчид танд зээл олгосон тохиолдолд өгөгдлийн санг хуваалцах, өөрчлөх боломжийг хэрэглэгчдэд олгодог. |
| ODC-ODbL | Энэхүү лиценз нь хэрэглэгчид танд өгөгдөл өгч, энэ лицензийн дагуу таны өгөгдлийн санд ямар нэгэн нэмэлт, өөрчлөлт, өөрчлөлтийг түгээх бусадтай хуваалцах, шинэчлэх боломжийг олгодог. |
| Атрибут | Та мэдээллийн баазын олон нийтийн ашиглалт, мэдээллийн сангаас бүтээсэн бүтээлийг ODbL-д заасан журмын дагуу хамааруулах ёстой. Мэдээллийн санг ашиглах, дахин хуваарилах, эсвэл үүнээс бүтсэн бүтээлийг хийхдээ та мэдээллийн сангийн лицензийг бусдад ойлгуулж, анхны мэдээллийн сан дээрх мэдэгдлийг хэвээр хадгалах ёстой. |
| Share-Alike | Хэрэв та энэ мэдээллийн баазын тохируулсан хувилбар, эсвэл тохируулсан мэдээллийн сангаас бүтээсэн бүтээлийг олон нийтэд ашиглаж байгаа бол ODbL-ийн дагуу тохируулсан мэдээллийн санг санал болгох ёстой. Мэдээллийн сан нь олон янзын агуулгыг агуулж болно (зураг, дүрс бичлэгийн материал, дуу чимээ бүгд ижил мэдээллийн санд байгаа), тиймээс ODbL нь зөвхөн мэдээллийн баазын эрхийг зохицуулдаг болохоос мэдээллийн сангийн агуулгыг дангаар нь зохицуулдаггүй. |
| ODC-PDDL | Энэхүү лиценз нь мэдээллийн бааз эсвэл тэдгээрийн агуулгад ("өгөгдөл") хамтад нь эсвэл дангаар нь ашиглахад зориулагдсан болно. Энэхүү олон нийтийн домэйн лиценз нь ямар ч зорилгоор, хязгаарлалтгүйгээр чөлөөтэй хуваалцах, өөрчлөх, ашиглах, шинэчлэх боломжтой. |

Олон мэдээллийн сан зохиогчийн эрхээр хамгаалагдсан байдаг. Европ, голдуу Европын зарим улсууд "*sui generis*" мэдээллийн баазын эрх гэж нэрлэгддэг мэдээллийн санг хамарсан тусгай эрхтэй байдаг. Эдгээр хоёр багц эрх, түүнчлэн мэдээллийн бааз, өгөгдлийг хамгаалахад ашигладаг бусад хууль ёсны эрхүүд нь мэдээллийн бааз болон тэдгээрийн суурь өгөгдлийг хуваалцахыг хүссэн хүмүүст тодорхойгүй байдал эсвэл практик бэрхшээлийг бий болгож болох боловч "зарим эрхээр хамгаалагдсан" хязгаарлагдмал эрхээ хадгалах болно.

Аливаа Олон нийтийн хэм хэмжээ, мэдээллийн сан эсвэл өгөгдлийг ашиглахтай ижил төстэй мэдэгдэл нь энэхүү баримт бичгийн нэг хэсгийг бүрдүүлэхгүй бөгөөд мэдээллийн сан эсвэл өгөгдөлд нэвтрэх, ашиглах бусад нөхцөлөөр гэрээ байгуулахгүй.

Мөн арилжааны зорилгоор ашиглах, техникийн хамгаалалтын арга хэмжээ авах, энэ өгөгдөл эсвэл мэдээллийн санг бусад мэдээллийн сан эсвэл өгөгдөлтэй нэгтгэх, тэдгээрийн өөрчлөлт, нэмэлтийг хуваалцах, нууцлах боломжтой. Хүлээн

авагчид цаашдын хэрэглэгчдэд энэхүү лицензийн хуулбарыг өгөх, эсвэл өгөгдөл, мэдээллийн баазын анхны бүтээгчийг эх сурвалж болгох шаардлага тавигдахгүй. Зорилго нь өгөгдөл, мэдээллийн баазыг анх бүтээсэн хүний бусдад ашиглах хязгаарлалтыг арилгах явдал юм.

Орон зайн өгөгдлийн дэд бүтэц нь өндөр хөгжсөн улс орнуудын цахим үйлчилгээний талаар товч судлахад орон зайн өгөгдөл, мэдээллийн үйлчилгээний лицензийн асуудал нь тодорхой, ямар төрлийн өгөгдөл, мэдээллийг хэрхэн ашиглах эрх (хуулбарлах, ашиглах, дахин нийтлэх, нэмүү өртөг шингээх гэх мэт), ашиглах үйлчилгээний төлбөр зэрэг нь тодорхой болсон байна. Зарим улс орнуудын жишээнээс товч дурдвал:

| Улсын нэр | Платформ | Тайлбар | Үнэ | Эх сурвалж |
|------------|---------------------|--|----------------------------------|---|
| Ирланд | GeoHive | Газрын зураг, өгөгдлийн каталог харах үйлчилгээ | Үнэгүй нээлттэй | https://www.osi.ie/services/ Тоон зургаас гадна хэвлэмэл төрөл бүрийн газрын зураг зардаг |
| | Геодезийн үйлчилгээ | Байнгын ажиллагаатай станцын ажиглалтын үр дүн, солбицол, Солбицол хөрвүүлэлт | Үнэгүй | |
| | MapGenie | Өндөр нарийвчлалын өгөгдөл, мэдээлэлд хандах /нийтийн, тусгай зориулалтын суурь зураг, орто зураг, дунд, том масштабын тоон газрын зураг, агаарын зураг, түүхийн зураг гэх мэт/ | Худалдаална | |
| Их Британи | OS MasterMap | Байр зүйн зураг, өндөр нарийвчлалын агаар, сансрын зураг, шугам сүлжээ, зам, тээвэр, ус хангамж | Ашиглалтын зориулалтаар ялгаатай | https://www.ordnancesurvey.co.uk/ Харах – үнэгүй, худалдааны зориулалт, медиа, нийтлэлд ашиглах зэрэг ашиглалтын хэлбэрээс хамааран лиценз бүр өөр өөр Тоон зургаас гадна хэвлэмэл төрөл бүрийн газрын зураг зардаг |
| | OS OpenData | Нээлттэй өгөгдөл хуваалцах платформ Засаг захиргааны нэгж, нэрийн өгөгдөл, гол мөрөн, зам | Нээлттэй | |
| | AddressBase | Хаягийн өгөгдөл Дотроо 3 төрөл <ul style="list-style-type: none"> • AddressBase • AddressBase Plus | Төрлөөрөө ялгаатай. | |

| | | | | |
|----------------|---------------------------|---|--|---|
| | | • AddressBase Premium | | |
| БНХАУ | Global vector map service | Төрөл бүрийн вектор болон растер өгөгдлийг харах, хандах боломжтой үйлчилгээнүүд Хятадаас гадна бусад улсын мэдээллийг агуулсан | Нээлттэй. | http://www.tianditu.com/ |
| | Global Image Map Service | | | |
| | General Services | | | |
| | Online map | | | |
| | Хөдөлгөөнт утасны апп | | | |
| Европын холбоо | Өгөгдлийн каталог | Өгөгдлийн каталог бүхий нэгдсэн геопорталтай. | Хайхад нээлттэй. Хайсан мэдээлэлд хандахад тухайн улсын холбогдох платформ руу холбогдоно. | http://inspire.ec.europa.eu/ |
| АНУ | Өгөгдөл хайх платформ | GeoPlatformArcGIS Organization Search Catalog Search Marketplace Resources | Нээлттэй, хандалтын эрхтэй | https://www.geoplatform.gov/ |
| | Өгөгдөлд хандах платформ | Map Viewer Map Manager Marketplace Preview Performance Dashboard FGDC Service Status Checker | Хандалтын эрхтэй | |

Орон зайн өгөгдөл, мэдээлэл, үйлчилгээний лицензийн талаар дэлгэрэнгүй судалгааг Литва Улсын жишээн дээр хийснийг долоодугаар хавсралтад үзүүлэв.

Асуудал шийдвэрлэх зорилго D

“Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч, хамтрагч байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог тодорхой болгох, тэдгээрийг нэгдсэн удирдлагаар зохицуулах замаар бүх салбарт орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлэх” зорилгын хүрээнд

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог хангасан судалгааг Хоёрдугаар хавсралтаар дэлгэрэнгүй харууллаа.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Орон зайн өгөгдөл, мэдээлэл нь олон жилийн туршид хуримтлагдсан, орон зай, цаг хугацааны хувьд өргөн цар хүрээтэй, маш олон үзүүлэлт бүхий өндөр үнэ өртөгтэй мэдээ байдаг. Судалгаанаас үзэхэд улс орнууд нь Байрлалын сүлжээ, зам,

тээврийн сүлжээ, кадастрын нэгж талбар, хаяг, ус зүй, өндөр, агаар, сансрын зураг, газар зүйн нэр зэргийг орон зайн суурь өгөгдөлд хамруулсан нь харагдаж байна. Манай улс ч мөн адил өөрийн орны онцлог шинжээс хамааран орон зайн суурь өгөгдлөө тодорхойлох нь чухал.

Техник технологи хөгжиж сайжрахын хирээр эх мэдээний суурь үнэ, нэг мэдээг бүрдүүлэхэд зарцуулах хөрөнгө мөнгө, мэдээ боловсруулалтын үнэ өртөг нэмэгдэж байна. Энэ тохиолдолд мэдээний өртгийг мэдээ, чиг үүргийн давхардлыг аль болох арилгах, мэдээг дундаа хэрэглэх хэрэглээг өргөжүүлж байж мэдээний өртгийг нөхөх боломжтой. Ямар байгууллага дээр ямар мэдээ байгааг ил тод нээлттэй болгох шаардлагатай.

Орон зайн өгөгдлийн нэгдмэл дэд бүтэц байгуулснаар орон зайн өгөгдөл, мэдээллийг хамтран ашиглах боломж бүрдэх, мэдээллийн хүртээмж, хандалт сайжрах, давхардал арилах, эх мэдээний өртөг буурах, мэдээллийн чанар сайжрах, мэдээний үнэ цэнэ, ач холбогдол нэмэгдэх, мэдээлэлд тулгуурласан бүтээгдэхүүн болон үйлчилгээг өргөжүүлэх, ашиглах асуудлыг хялбар, боловсронгуй болгох, шийдвэр гаргах үйл явцад сайнаар нөлөөлөх, улмаар төрийн цахим засаглал, бизнесийн орчныг дэмжих зэрэг олон талын ач холбогдолтой.

Орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлт, хэрэглээ нэмэгдэхийн хэрээр түүнийг хамгаалах, нууцлах, аюулгүй байдлыг хангах асуудал урган гарна. Өгөгдлийг хамгаалах, нууцлах, аюулгүй байдлыг ихэнх хууль, журам нь байрлалд суурилсан мэдээлэл хэрэглээнд нэвтрэхээс өмнө боловсруулагдсан байдаг тул тэдгээрийг одоогийн бүрдүүлэгдсэн байрлалын мэдээлэлтэй холбоход хүндрэл үүсдэг. Үр дүнд нь байрлалтай холбогдсон орон зайн мэдээллийн хамгаалалтыг хэн хариуцах, хэрхэн хамгаалах талаар тодорхойгүй байдал үүсдэг. Орон зайн мэдээллийн нууцлалтай холбоотой тодорхой зохицуулалт хийх нь тухайн орон зайн мэдээллийг буруу бүрдүүлэх, хэрэглэх, хуваалцах эрсдэлээс сэргийлнэ.

Орон зайн мэдээлэл нь хөрвөх чадвартай буюу нэг төрлийн орон зайн мэдээллийг олон зориулалтаар ашиглах боломжтой. Тухайлбал, сургуулийн байрлалын мэдээллийг төлөвлөлтийн зориулалтаар, онцгой байдлыг үед нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээний зориулалтаар ашиглах боломжтой. Зарим тохиолдолд мэдээллийг буруу зорилгоор ашиглах боломжтой байх ба үүнээс сэргийлэхийн тулд буруу/гэмт хэргийн шинжтэй зорилгоор ашиглахыг хориглох, сэргийлэх зохицуулалтыг хууль тогтоомжид тусгах хэрэгтэй.

Орон зайн мэдээлэл нь хиймэл дагуулын технологи, тандан судалгаа, вебд суурилсан зураглалын үйлчилгээ, ухаалаг утас, газар зүйн мэдээллийн систем, геодезийн хэмжил, зураглал зэрэг технологи ашиглан бүрдүүлэгдэж, аж үйлдвэрлэлийн олон салбарт ашиглагддаг. Иймд энэ олон талт уялдаа холбоог хууль эрх зүйн орчинд харгалзаж үзэх нь чухал.

Цаашид Үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийн мэдээллийн системийн тогтолцоог үндэсний хэмжээнд байгуулах, байгаль, нийгэм, эдийн засгийн бүх салбарт орон зайн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг Монгол улсад болон олон улсад мөрдөж буй норм, дүрэм, стандарт хангасан зөв мэдээллээр баяжуулж, үр дүнтэй ашиглахын тулд байгууллагуудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Орон зайн мэдээллийн чадавхыг сайжруулахын тулд дор дурдсан оролцогчдын оролцоо, үүрэг хариуцлага, дэмжлэгийг харгалзах хэрэгтэй. Үүнд:

Төрийн байгууллага – бүх шатны төрийн байгууллага нь орон зайн мэдээллийн менежментэд голлох үүрэг гүйцэтгэдэг. Ихэвчлэн эдгээрт газрын кадастр, газрын төлөвлөлт, хэмжил зураглал, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал эрхэлсэн байгууллагууд ордог хэдий ч өнөөдрийн орон зайн мэдээллийн хэрэглээ ихэссэн өнөө үед бусад төрийн байгууллагууд ч орох болсон.

Хувийн хэвшил – хувийн хэвшил нь орон зайн мэдээллийн менежментэд мэдээллийг бүрдүүлэгч болон хэрэглэгчийн үүрэгтэйгээр оролцдог тул хууль, эрх зүйн орчинд энэ хоёр үүргийн талаарх зохицуулалтыг хамтад нь оруулах нь чухал.

Иргэн – Хуучинд иргэн орон зайн мэдээллийн үйлчилгээг хүртэгч, төрийн байгууллагууд нь үйлчилгээг хүргэгч байсан бол технологийн дэвшлийн үр дүнд иргэн нь мөн мэдээллийг бүрдүүлэгчийн үүрэг гүйцэтгэж байна.

Боловсролын байгууллага болон төрийн бус байгууллага (ТББ) – Өнгөрсөнд ч, одоо ч гэсэн ТББ нь орон зайн мэдээллийн менежментэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ба тэдний оролцоог хангах, дэмжих асуудлыг хууль эрхзүйд зайлшгүй зохицуулах хэрэгтэй. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх тухай тусгайлсан зохицуулалт тусгасан хуулийн заалт хэрэгтэй.

Орон зайн мэдээллийн чанар, шинэлэг байдал, баталгаажилт, нээлттэй байдал, бүрэн бүтэн байдал, лицензийн асуудал, үнэ өртөг, солилцоо, нууцлал, аюулгүй байдал, хариуцлагын асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүйн орны асуудал байгааг онцолж, Аргачлалын 9-д заасны дагуу дараахь зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулах нь тулгамдаж буй асуудал, хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэхээр байна. Үүнд:

a. Орон зайн өгөгдлийн дэд бүтэц, түүний бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, хамрах хүрээг тодорхойлох,

b. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах этгээдийг тодорхойлох, оролцогчдын эрх, үүргийг тогтоох,

c. Суурь орон зайн өгөгдлийн ангиллыг тогтоож, нэн тэрүүнд тэдгээр суурь мэдээллийн бэлэн байдал, нэгдмэл байдлыг хангаж ажлыг зохион байгуулах,

d. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийг байгуулах, үйл ажиллагааг эрхлэхэд баримтлах зарчмыг тогтоох,

e. Орон зайн өгөгдөл, мэдээллийн лицензтэй холбоотой асуудлын зарчмыг тодорхойлох,

f. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг дэмжих бодлого, хөтөлбөр, судалгаа-хөгжил, хүний нөөцийн асуудлыг тусгах,

2. Байрлалд тулгуурласан буюу орон зайн өгөгдөл, мэдээллийн хэрэглээг байгаль, нийгэм, эдийн засгийн бүх төрлийн шийдвэр гаргалтад нэмэгдүүлэх нь түүний эдийн засгийн үр өгөөжийг өсгөх төдийгүй нийгэм, экологийн тэнцвэрт байдлыг хангах тулгуур хүчин зүйл болох юм.

--oOo--

ХАВСРАЛТУУД

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ОРОН ЗАЙН СУУРЬ ӨГӨГДЛИЙН АНГИЛЛЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГАА

ҮНДЭСНИЙ ОРОН ЗАЙН СУУРЬ ӨГӨГДЛИЙН ХҮРЭЭ

ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫН СУДАЛГАА (ISO/TC 211)

ГЗБГЗЗГ-ЫН НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ЖАГСААЛТ

ОРОН ЗАЙН ӨГӨГДӨЛ, МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЛИЦЕНЗИЙН ТАЛААР
ДЭЛГЭРЭНГҮЙ СУДАЛГААГ ЛИТВА УЛСЫН ЖИШЭЭ

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС АВСАН СУДАЛГААНЫ НЭГТГЭЛ

| | | | |
|--|---|---|--|
| Байгууллагын нэр | Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Батлан хамгаалах яам (Зэвсэгт хүчний жанжин штабын Тусгай төлөвлөлтийн хэлтэс Зэвсэгт хүчний 284 дүгээр анги) |
| Албан тоотын дугаар | 2017.12.22 01/3990 | 2018.01.11 03/229 | 2018.01.17 1в/225 |
| Танай байгууллага эрхлэх асуудлын хүрээнд ямар төрлийн мэдээлэл бүрдүүлдэг бэ? /Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй бол 9-11 дэх асуулт руу шилжинэ үү! | EXCEL файлаар зөөвөрлөж хүлээж авч байгаа. Одоогоор төвлөрсөн мэдээллийн систем байхгүй. | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар заалтын 1 дэх хэсгийн Байгаль орчны улсын мэдээллийн сан | Цэргийн байр зүйн зураг, орон зайн өгөгдлийн мэдээллийн сан |
| Мэдээллийн санг ямар төрлөөр хадгалдаг вэ? (хүснэгтэн, зурган, газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл, *.GDB, *.SHP гэх мэт) | Хүснэгтэн хэлбэрээр хадгалж байна. | Орон зайн мэдээг PostGIS-ийн geometry форматаар, хүснэгтэн хэлбэрээр, *.GDB, *.SHP форматаар | Зурган хэлбэрээр, GDB, SHP |
| Орон зайн анхдагч мэдээ боловсруулахад ямар программ хангамж ашиглаж байна вэ? | Одоогоор ашиглаж байгаа программ хангамж байхгүй байна. | ArcGIS, QGIS, MapInfo | ArcGIS, Панорама, ENVI, Google Earth |
| Ямар төрлийн өгөгдлийн сан удирдах систем (DBMS) хэрэглэдэг бэ? (MySQL, PostgreSQL, EnterpriseDB, Microsoft SQL Server, Oracle гэх мэт) | Систем хийгдээгүй байгаа тул өгөгдлийн сангийн суурь систем хэлэх боломжгүй байна. | PostgreSQL | ЗХЖШ, түүний харьяа байгууллагууд орон зайн өгөгдлийн сан удирдах системийн талаар интернэтэд суурилсан нээлттэй программ хангамж ашигладаггүй болно. |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх ямар хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж байна вэ? | Мэдээлэл бүрдүүлэхдээ статистикийн мэдээлэл бүрдүүлэх арга замаар аймаг нийслэлийн харьяа газар сумдын нэгжүүдээс файл болон бичгэн хэлбэрээр хүлээн авч байна. | Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р бүлэг, Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоол | MNS 5774:2007 Газарзүйн мэдээлэл-Мета өгөгдөл /Стандартчилал, хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 50 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын стандарт/ |

| | | | |
|---|--|---|--|
| <p>Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой ямар Үндэсний болон байгууллагын стандарт, нормтой вэ?</p> | <p>Үндэсний статистикийн хорооны зөвшөөрснөөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 169 тоот тушаалаар баталсан маягт болон зааврын дагуу мэдээлэл авч байгаа болно.</p> | <p>MNS 5774:2007 Газарзүйн мэдээлэл-Мета өгөгдөл MNS 5641-1:2006 Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код 1-р хэсэг. Аймаг, нийслэл MNS 5641-2:2006 Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код 2-р хэсэг. Сум, дүүрэг</p> | <p>MNS 5774 : 2007 MNS-ISOTC-19104:2012 /Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх талаар ЗХЖШ-ын даргын "Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах" тухай тушаал, ЗХЖШ-ын мэдээллийн аюулгүй байдлын албанаас гаргасан зөвлөмж/</p> |
| <p>Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомж?</p> | <p>Мэдээллийн сангийн хувьд ашиглаж байгаа байгууллагын шуудан, холбооны зардлаас санхүүжигдэж байгаа.</p> | <p>Байхгүй</p> | <p>Батлан хамгаалах салбарын хувьд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотооддоо мэдээллийн сан бүрдүүлэх талаар ямар нэг мөрдөгдөж буй төлбөр, хууль тогтоомж байхгүй.</p> |
| <p>Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал ямар байдаг вэ? Тулгамдаж буй асуудал гардаг уу?</p> | <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн өгөгдөл дээр тулгуурлан газар тариалангийн мэдээллийн сан болон малын бэлчээрийн сан үүсгэх талаар ажиллаж байна. Мэдээлэл солилцоход гарах төлбөрийн асуудал цаашид тулгамдах асуудал гэж үзэж байна.</p> | <p>Мэдээ бүрдүүлэгч байгууллага мэдээллийн санд онлайнаар орон зайн мэдээ оруулдаг. Хэрэглэгчийн хүсэлтээр XSL, SHP форматаар мэдээ гаргаж үйлчилдэг. Мэдээ бүрдүүлэгч байгууллагын орон зайн мэдээ бүрдүүлэлт болон мэдээний чанар хангалтгүй</p> | <p>ЗХЖШ, түүний харьяа байгууллагын хувьд бусад төрийн болон хувийн байгууллагатай мэдээлэл солилцох байдал хязгаарлагдмал бөгөөд орон зайн мэдээлэл бүрдүүлэх, газар зүйн мэдээллийн системийг хөгжүүлэх талаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай /ГЗБГЗЗГ/-тай хамтран ажиллах санамж бичгийг 2015 онд байгуулсан ба орон зайн шаардлагатай нарийн мэргэжилтнийг мэргэшүүлэн сургах тал дээр "Монмэп" ХХК-тай хамтран ажилладаг.</p> |

| | | | |
|---|--|--|---|
| <p>Үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэг бэ? Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл</p> | <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэдээллийн өгөгдөл дээр салбарын тариалангийн болон мал аж ахуйн зориулалтаар ашиглагдах талбайн мэдээлэл шаардлагатай.</p> | <p>АМГТГ, ГХГЗЗГ -аас орон зайн мэдээ авдаг. Байгаль орчны орон зайн мэдээний чанарыг сайжруулах, улсын хэмжээний орон зайн мэдээг шинэчлэх шаардлагатай. Орон зайн мэдээний чанарыг сайжруулах, топологи шалгалт явуулах, нэг мэдээгээр үйлчлэх</p> | <p>Геодезийн байрлалын тодотгол, өндөр, Өндрийн тоон загвар /шаардлагатай өндөр тохиолдолд өндөр нарийвчлал бүхий/</p> |
| <p>Бусад санал</p> | <p>Салбар тус бүрийн газар зохион байгуулалтын мэдээллийг засгийн газар болон яам, агентлагуудад төлбөргүйгээр мэдээлэл хангах боломжийг бий болгох саналыг тусгах хэрэгтэй.</p> | <p>Орон зайн мэдээг бүрдүүлэх, боловсруулах талаар мэдээ бүрдүүлэгч байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт явуулах, Орон зайн мэдээг WMS үйлчилгээ ашиглан солилцох, Орон зайн мэдээний стандарт, хууль эрх зүйн орчныг бий болгох, төрийн байгууллага хооронд орон зайн мэдээллийг солилцох дэд бүтцийг бий болгох.</p> | <p>ЗХЖШ, Зэвсэгт хүчний анги, байгууллагуудын тусгай хэрэгцээний газрын тодотголыг хийж гүйцэтгэх, байр зүйн зургийг нарийвчлалтай боловсруулах нөхцөл бололцоог дээшлүүлэх, орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх талаарх өндөр үзүүлэлт бүхий компьютер, өндөр хурдын интернэт, геодезийн хэмжилтийн техник, тоног төхөөрөмжөөр хангах саналтай байна.</p> |

| Байгууллагын нэр | Эрчим хүчний яам (Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК) | Эрүүл мэндийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, (Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар) | Сангийн яам |
|-------------------------|--|--------------------------|--|----------------------|
| | 2018.01.02 в/03 | 2018.01.05 2/39 | 2018.01.04 3/26 | 2017.12.21 11-2/7160 |

| | | | | |
|--|--|---|--|--|
| Танай байгууллага эрхлэх асуудлын хүрээнд ямар төрлийн мэдээлэл бүрдүүлдэг бэ? /Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй бол 9-11 дэх асуулт руу шилжинэ үү/ | Барилгын дулааны тоноглол, дулааны шугамын трасс, худаг, төв шугамын өргөн диаметр, солигдсон он гэх мэдээлэл агуулдаг | Хувь хүний эрүүл мэндийн мэдээлэл, хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийн мэдээлэл, эмнэлгийн мэргэжилтний тусгай зөвшөөрлийн мэдээлэл, эмийн бүртгэл | | Төрийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй системүүдийг боловсруулан хэрэгжүүлж холбогдох мэдээллийн санг бүрдүүлдэг. /орон зайн мэдээллийн санг бүрдүүлдэггүй./ |
| Мэдээллийн санг ямар төрлөөр хадгалдаг вэ? (хүснэгтэн, зурган, газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл, *.GDB, *.SHP гэх мэт) | Хүснэгтэн, зурган хэлбэрээр SHP өргөтгөлөөр хадгалдаг | | | |
| Орон зайн анхдагч мэдээ боловсруулахад ямар программ хангамж ашиглаж байна вэ? | ArcGIS Desktop 10.2 | | | |
| Ямар төрлийн өгөгдлийн сан удирдах систем (DBMS) хэрэглэдэг бэ? (MySQL, PostgreSQL, EnterpriseDB, Microsoft SQL Server, Oracle гэх мэт) | SQL Server 2012 | | | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх ямар хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж байна вэ? | Компанийн "Дулаан хангамжийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлтийг хариуцан ажиллах журам"-ыг мөрдөн ажилладаг. | | | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой ямар Үндэсний болон | Компанийн "Дулаан хангамжийн мэдээллийн сангийн баяжилт, шинэчлэлтийг хариуцан ажиллах | | | |

| | | | | |
|---|--|--|---|---|
| байгууллагын стандарт, нормтой вэ? | журам"-ыг мөрдөн ажилладаг. | | | |
| Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомж? | ArcGIS газар зүйн мэдээллийн системийн лицензийн төлбөр | | | |
| Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал ямар байдаг вэ? Тулгамдаж буй асуудал гардаг уу? | Банкнуудтай дулааны төлбөрийн мэдээлэл солилцдог. Тулгамдсан асуудал одоогоор байхгүй. | | Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцохдоо "Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам"-ын дагуу явж байна. Сум, хорооны түвшинд мэдээлэл солилцоход дэд бүтэц болон хууль эрх зүйн орчин хүндрэлтэй байна. | Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох боломж дэд бүтцийн хувьд бүрдсэн гэж үзэж болох боловч Төрөөс Мэдээллийн технологийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомжууд харьцангуй сул байгаатай холбоотойгоор байгууллагуудтай мэдээлэл солилцоход хүндрэлтэй байдал үүсдэг. |

| | | | | |
|---|---|--|--|--|
| <p>Үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэг бэ? Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл</p> | <p>Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газраас барилгын байршлын мэдээлэл авдаг.</p> | <p>Бусад төрийн байгууллагуудаас орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэггүй. MNS5260:2015 стандартын дагуу 5000 хүн тутамд нэг эмийн сан, хоорондын зай нь 500 метрээс багагүй байх ёстой гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд орон зайн мэдээллийн хэрэгцээ байдаг.</p> | <p>Тус яамны эрхлэх үйл ажиллагааны хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хариуцан ажилладаг Өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх судалгааны үеэр Орон нутгийн хил хязгаарын мэдээллийг Геодези, зураг зүйн газраас 2015 онд авч ашиглаж байсан. Цаашид хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлийн мэдээллийн санд дахь өрх, иргэний мэдээллийг орон зайн мэдээллийн сантай холбож ашиглах хэрэгцээ шаардлага байна.</p> | <p>Сангийн яам нь бусад төрийн байгууллагуудыг бодоход мэдээллийн технологийн үйл ажиллагаандаа харьцангуй эрт ашиглаж ирсэн бөгөөд орон зайн мэдээ, мэдээлэлд оруулан ашиглаж болохуйц тодорхой хэмжээний мэдээллийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Одоогийн байдлаар орон зайн өгөгдөл мэдээллийг авч хэрэглээгүй байгаа ба цаашид үйл ажиллагаанд хэрэглэх нь зайлшгүй юм.</p> |
| <p>Бусад санал</p> | <p>-</p> | | | <p>Монгол улс нь орон зайн мэдээллийн сан, түүнтэй холбоотой системүүдийг боловсруулан хөгжүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Сангийн яам нь эрхлэх асуудлын хүрээнд орон зайн мэдээллийн сан болон холбогдох системүүдийг бий болгоход хамтран ажиллах боломжтой</p> |

| | | | | |
|---|--|--|--|---|
| Байгууллагын нэр | ЗТХЯ | УБТЗ ХНН | МТЗ | Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв |
| Албан тоот | 2017.12.25 03/5766 | | | |
| Танай байгууллага эрхлэх асуудлын хүрээнд ямар төрлийн мэдээлэл бүрдүүлдэг бэ? /Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй бол 9-11 дэх асуулт руу шилжинэ үү/ | Монгол улсын хэмжээнд автозамын сүлжээ, түүний дагуух барилга, байгууламжийн тухай Орон зайн мэдээллийн санг мэргэжлийн байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглахаар дараахь түрлүүдээр бүрдүүлж байна. Үүнд: Олон улсын чанартай зам, Улсын чанартай зам, Орон нутгийн зам, Тусгай зориулалтын зам-уурхайн зам, хот нийслэлийн замын сүлжээ. Орон зайн мэдээллийн сан нь Газар зүйн мэдээллийн сан ба Тоон мэдээллийн сангаас бүрдэнэ. ГМС-д улсын хэмжээний автозамын сүлжээний зураг, Тоон мэдээллийн санд улсын чанартай замын шинэчилсэн хээрийн хэмжилт 2017 оноор, замын паспорт, зам дагуух барилга, байгууламж гүүр, хоолой, бусад тэмдэглэгээний координат, паспортууд багтана. | Төмөр замын ачаа ба зорчигч тээвэрлэлттэй холбоотой мэдээлэл бүрдүүлдэг. | Газар зүйн байршил, ажлын хэмжээг харуулсан ажлын зураг буюу ажлын зураг Баригдсан төмөр замын объектын зураг | Бүрдүүлдэггүй |
| Мэдээллийн санг ямар төрлөөр хадгалдаг вэ? (хүснэгтэн, зурган, газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл, *.GDB, *.SHP гэх мэт) | geodatabase | | Ажлын файл хэлбэрээр / газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл .shp .jpg/ | |

| | | | | |
|---|---|--|--|--|
| Орон зайн анхдагч мэдээ боловсруулахад ямар программ хангамж ашиглаж байна вэ? | ArcGIS, ESRI | - | ESRI global mapper, arcgis Google map – Google earth | |
| Ямар төрлийн өгөгдлийн сан удирдах систем (DBMS) хэрэглэдэг бэ? (MySQL, PostgreSQL, EnterpriseDB, Microsoft SQL Server, Oracle гэх мэт) | Microsfot SQL Server | - | Зөвхөн файл хэлбэрээр ашиглаж байгаа | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх ямар хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж байна вэ? | "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын захирлын тушаалаар "Монгол Улсын авто замын сүлжээний орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох судалгаа"-ны ажлын хэсэг байгуулагдсан. Холбогдох дүрэм журмыг судалж байна. | Холбоотой Монгол улсын хууль Байгууллагын дотоод журам | Холбоотой Монгол улсын хууль Байгууллагын дотоод журам | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой ямар Үндэсний болон байгууллагын стандарт, нормтой вэ? | | | Байхгүй | |
| Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомж? | - | | байхгүй | |

| | | | | |
|--|--|--|---|---|
| <p>Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал ямар байдаг вэ? Тулгамдаж буй асуудал гардаг уу?</p> | | <p>Төмөр замын тээврийн үйл ажиллагаатай ОХУ-ын хөрш төмөр замуудтай галт тэрэг, ачааны мэдээлэл солилцож байна.</p> | <p>Гэрээт байгууллагуудтай ажлын зураг солилцох Файлын нууцлалыг хангах асуудал</p> | <p>Тус төв нь холбогдох байгууллагуудаас мэдээллийг цахим шуудан болон цахим хэлбэрээр солилцдог. Дээрх байгууллага нь цаг тухайд нь мэдээллийг ирүүлдэггүй</p> |
| <p>Үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэг бэ? Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл</p> | | <p>Төрийн байгууллагуудаас ямар ч төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэггүй.</p> | <p>Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, УБТЗ ХНН-аас албан бичгээр хандаж авдаг.</p> | <p>Төв нь үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэггүй.</p> |
| <p>Бусад санал</p> | | | | <p>Орон зайн мэдээллийн сантай болох талаар судалгаа хийн ажиллаж байна</p> |

| Байгууллагын нэр | АТҮТ | ЗТХТ | НТГ | НАЗХГ |
|--|---|--|--|---|
| Танай байгууллага эрхлэх асуудлын хүрээнд ямар төрлийн мэдээлэл бүрдүүлдэг бэ? /Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй бол 9-11 дэх асуулт руу шилжинэ үү/ | Улс, хоорондын нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд суурилуулсан байршил тогтоох төхөөрөмжөөр тээврийн хэрэгслийн бодит цагийн байршил /координатаар/, хурдын мэдээллийг хүлээн авч, "Wialon Local" программ хангамжийн тусламжтайгаар хэрэгцээт мэдээ, тайланг боловсруулдаг. | Авто замын орон зайн мэдээллийн сан /Азийн дэд бүтцийн хүрээлэн боловсруулсан/ | Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэл болон зогсоолын мэдээлэл, Авто үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын талаарх мэдээлэл, Өдөр тутмын бүртгэлийн /GPS/ мэдээлэл, Нийтийн тээврийн үйлчилгээний зорчил /карт/ | Авто зам, гүүр, нүхэн гарц болон авто замтай холбоотой бусад мэдээллийг бүрдүүлж, бүрдүүлэхээр ажиллаж байна. |
| Мэдээллийн санг ямар төрлөөр хадгалдаг вэ? (хүснэгтэн, зурган, газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл, *.GDB, *.SHP гэх мэт) | SHP | Хүснэгтэн, зурган хэлбэрээр SHP өргөтгөлөөр хадгалдаг | SHP, KMZ, Microsoft Excel | Нийслэлийн дундын мэдээллийн сантай холбох ажлын хүрээнд GDB-ээр хадгалж байна. |
| Орон зайн анхдагч мэдээ боловсруулахад ямар программ хангамж ашиглаж байна вэ? | Тус системд холбогдсон тээврийн хэрэгслийн байршил тогтоох төхөөрөмжөөс ирсэн байршлын мэдээллийг цаг хугацааны хувьд тохируулан "оноосон нэр" өгөх замаар "Wialon Local" программын газрын зурагт хөгжүүлэлтийн хийж байна. Мөн QGIS систем ашиглан шаардлагатай хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэдэг. | Microsoft Excel, ArcGIS 10.2.2, Road application | Google Earth, ArcGIS | Google Earth, ArcGIS |
| Ямар төрлийн өгөгдлийн сан | "Wialon DB" өгөгдлийн сан | Microsfot SQL Server | MySQL, MSSQL, Oracle | Microsfot SQL Server |

| | | | | |
|--|--|---|---|--|
| удирдах систем (DBMS) хэрэглэдэг бэ? (MySQL, PostgreSQL, EnterpriseDB, Microsoft SQL Server, Oracle гэх мэт) | удирдах системийг ашигладаг ба энэ нь ORACLE Berkley DB системтэй ижил юм. | | | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх ямар хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж байна вэ? | Холбогдох дүрэм журам | Авто замын газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 24 тоот тушаал | Нийслэлийн засаг даргын 2016 оны 12-р сарын 08-ны А/864 журмын дагуу мэдээллээ бүрдүүлж эхлээд байна. | Мэдээллийн аюулгүй байдлын тухай хууль тогтоомж болон байгууллагын дотоод дүрэм журамтай уялдуулан ажилладаг. |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой ямар Үндэсний болон байгууллагын стандарт, нормтой вэ? | "Wialonlocal" программын шаардлага хангасан протокол бүхий байршил тогтоох төхөөрөмжийн мэдээллийн системд хүлээн авах боломжтой | Авто замын газрын даргын 2009 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 24 тоот тушаал | WGS-84 | Нийслэлийн мэдээлэл технологийн газраас хэрэгжүүлж буй Дундын мэдээллийн сангийн Стандартад нийцүүлэн уялдаа холбоотой ажиллаж байна. |
| Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомж? | Мэдээлэл дамжуулалтын зардалд нэг тээврийн хэрэгсэл дунджаар 3000 төгрөг гэрээт үүрэн холбооны операторт төлнө. | Байхгүй | Байхгүй | Нийслэлийн Засаг даргын баталсан А/137 захирамжийн 8-р хавсралтын 1-р ажлын хүрээнд Газар зүйн мэдээллийн сангийн ArcGIS программыг 3 жилийн хугацаатайгаар 2017 оны 10 сарын 08-нд авсан. Цаашид жил жилээр сунгаад явна. |
| Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал ямар байдаг вэ? Тулгамдаж буй | Газар зүйн байрлалын нэгдсэн тогтсон нэр томъёо байдаггүй. | Байхгүй | Дундын мэдээллийн нэгдсэн сантай болсноор мэдээлэл авахад | Албан бичгээр харьцаж мэдээлэл солилцоход удаан хүндрэлтэй байдаг. |

| асуудал гардаг уу? | | | илүү хялбар болсон. | |
|--|--|--|---|--|
| Үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэг бэ? Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл | Орон зайн мэдээллийг бодитоор авахад үүрэн холбооны операторуудын сүлжээнүүдийн тасралтгүй байдал хүндрэл учруулдаг. Учир нь сүлжээ тасарсан газруудад мэдээллийг бодит цагт хүлээн авах боломж бүрддэггүй. | Бусад төрийн байгууллагуудаас орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэггүй. | Нийтийн тээврийн шинэ чиглэл болон зогсоол төлөвлөхөд шинээр байгуулагдсан суурьшлын бүсийн мэдээллийг Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Нийслэлийн авто замын газраас Google earth болон AutoCAD-ын файлыг авч ашигладаг. | Газрын албанаас газар чөлөөлөлттэй холбоотойгоор кадастрын мэдээлэл, Ерөнхий төлөвлөгөөний газраас хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний мэдээлэл, шугам сүлжээний байгууллагуудаас шугам сүлжээний мэдээлэл авч хэрэглэх болон зөвшилцөж ажилладаг. |
| Бусад санал | Орон зайн мэдээллийг шуурхай хүлээж авах, мэдээллийг ашиглан газрын зургаа хөгжүүлэх, хөдөлгөөний хяналтыг сайжруулахад байршил тогтоох төхөөрөмжөөс ирүүлж буй мэдээллийг үүрэн холбооны сүлжээ ашиглалгүй сансрын хиймэл дагуулаас шууд хүлээн авдаг болох шаардлагатай байна. | | | |

| Байгууллагын нэр | ИНЕГ | МИАТ |
|--|---|-----------------------------------|
| Танай байгууллага эрхлэх асуудлын хүрээнд ямар төрлийн мэдээлэл бүрдүүлдэг бэ? /Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй бол 9-11 дэх асуулт руу шилжинэ үү/ | Нисэхийн аюулгүй ажиллагааг хангахад чухал шаардлагатай газар зүйн болон орон зайн өгөгдөл болох газрын гадарга, саад, аэродромын зураглалын өгөгдлийн сан, агаарын замын өгөгдлийн сан, соронзон хазайлтын өнцгийн утга, навигацийн тоног төхөөрөмжийн мэдээлэл, аэродромын мэдээлэл, байр зүйн тоон зураг зэргийг бүрдүүлдэг. | Орон зайн мэдээлэл бүрдүүлдэггүй. |
| Мэдээллийн санг ямар төрлөөр хадгалдаг вэ? (хүснэгтэн, зурган, газарзүйн мэдээллийн системийн өргөтгөл, *.GDB, *.SHP гэх мэт) | JPEG, PDF, XLS, TIFF, IMG, SHP, DWG, DGN, DXF | |
| Орон зайн анхдагч мэдээ боловсруулахад ямар программ хангамж ашиглаж байна вэ? | ArcGIS, AutoCAD, Erdas IMAGINE, Geocalc, Microstation, Spectrum Survey | |
| Ямар төрлийн өгөгдлийн сан удирдах систем (DBMS) хэрэглэдэг бэ? (MySQL, PostgreSQL, EnterpriseDB, Microsoft SQL Server, Oracle гэх мэт) | Oracle 11G, MySQL | - |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн санг ашиглах талаарх ямар хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж байна вэ? | Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Чикагогийн конвенц, Иргэний нисэхийн дүрэм, журам, холбогдох байгууллагатай байгуулсан санамж бичиг, хамтын ажиллагааны гэрээ, Геодези зураг зүйн тухай Монгол улсын хууль, Геодезийн хэмжилт хийхэд ашиглагддаг барилгын норм ба дүрмүүд | |
| Өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх, мэдээллийн сантай холбоотой ямар Үндэсний болон байгууллагын стандарт, нормтой вэ? | MNS 6478:2014 Иргэний нисэх. Агаарын ба газрын үйл ажиллагаанд хэрэглэх, Иргэний нисэхийн дүрэм-175, ИНЕГ-ын даргын баталсан "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний бүтээгдэхүүнд тавигдах шаардлага", "Нислэгийн зургийн шаардлага", "Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагыг Аэродромын мэдээллээр хангах журам", ИНЕГ-НМҮА-ны даргын баталсан "Нисэхийн өгөгдөл хадгалах журам" | |

| | | |
|---|---|---|
| <p>Мэдээллийн сангийн үйлчилгээний хөлс, төлбөрийн хувьд мөрдөж буй хууль тогтоомж?</p> | <p>Геодези, зураг зүйн ажлын жишиг үнэ БД81-103-13</p> | |
| <p>Бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох байдал ямар байдаг вэ? Тулгамдаж буй асуудал гардаг уу?</p> | <p>ИНЕГ нь олон улсын иргэний нисэхийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор Монгол улсын хилийн мэдээлэл, авто зам, төмөр зам, хот суурин газрын хил хязгаар, Барилга, байгууламжийн өндөр, байрлал, геодезийн тулгуур цэгийн мэдээлэл болон газар зүйн тоон зураг зэрэг мэдээллүүдийг хүсэн Барилга, хот байгуулалтын яам, ГЗБГЗЗГ зэрэг төрийн байгууллагуудад удаа дараа ханддаг боловч шаардлага хангасан, сүүлийн үеийн бодит мэдээлэл авч чаддаггүй. ИНЕГ болон ГЗБГЗЗГ хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд ГЗБГЗЗГ-аас хүлээн авсан 1:100000-ны масштабтай байр зүйн зургийн тоон зургуудын зарим өндрийн тоотууд буруу болон дутуу, хаялбарын өндөр байхгүй, эсвэл буруу зэргээс шалтгаалан нислэгийн журам зохиоход хүндрэл учирч байна. Энэ талаар ГЗБГЗЗГ-т олон дахин хандаж байгаа боловч шаардлага хангасан зураг авч чадахгүй байна. ИНЕГ нь улсын төсвийн хөрөнгөөр бүрдүүлсэн геодези, зураг зүйн ажлуудыг Геодези, зураг зүйн тухай Монгол Улсын хуулийн 9.2-ын дагуу ГЗБГЗЗГ-т хүлээлгэн өгсөн боловч ГЗБГЗЗГ нь мэдээллийн сандаа бүртгэж авдаггүй. Орон нутгийн засаг захиргааны нэгжүүдэд харьяалагддаг Газрын албадаас мэдээлэл хүсэхэд өгөхгүй байх, өгсөн тохиолдолд мэдээлэл нь зөрүүтэй, алдаатай, дутуу зэрэг үл тохирол байнга гарч хүндрэл учруулдаг.</p> | <p>Орон зайн талаарх мэдээлэл солилцдоггүй. Тулгамдаж буй асуудал байхгүй.</p> |
| <p>Үйл ажиллагаа эрхлэхэд бусад төрийн байгууллагуудаас ямар төрлийн орон зайн өгөгдөл, мэдээллийг авч хэрэглэдэг бэ? Орон зайн мэдээллийн хэрэгцээ, шаардлага, хүндрэл бэрхшээл</p> | <p>ИНЕГ болон ГЗБГЗЗГ хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичигт агаарын навигацид ашиглагдах дараах Монгол орны геоидын загвар, солбицлын эрин бүхий дараах тоон өгөгдөл, мэдээлэл (тэдгээрийн шинэчлэгдсэн хувилбарууд)-ыг засварлах боломжтой байдлаар ГЗБГЗЗГ-аас авахаар тусгагдсан байдаг. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн 1:1000000-ны масштабтай тоон зургийн мэдээллийн сан 2. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн 1:500000-ны масштабтай тоон зургийн мэдээллийн сан 3. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн 1:100000-ны масштабтай тоон зургийн мэдээллийн сан 4. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн 1:50000-ны масштабтай тоон зургийн мэдээллийн сан | <p>Бусад байгууллагаас орон зайн өгөгдөл мэдээллийг авч хэрэглэдэггүй. Хүндрэл байхгүй.</p> |

| | | |
|---------------------------|--|----------------------|
| | <p>5. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн 1:25000-ны масштабтай тоон зургийн мэдээллийн сан</p> <p>6. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн газар зүйн нэрийн зураг</p> <p>7. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн хот суурин газрын суурьшлын бүсийн хил заагийн зураг</p> <p>8. Улаанбаатар хотын барилгажсан бүсийн хилийн зураг</p> <p>9. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн зураг</p> <p>10. Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдсэн өндрийн тоон загвар (DEM)</p> <p>11. Монгол орны геоидын өндрийн загвар (тоон байдлаар)</p> <p>12. ГЗБГЗЗГ-аас гаргасан программ хангамжууд (Геоидын өндөр тооцоолох, таних тэмдгийн гэх мэт)</p> <p>13. Солбицлын эрин шинэчлэгдсэн тохиолдолд Монгол Улсын геодезийн тулгуур сүлжээний цэгийн каталогийн шинэчилсэн хувилбар</p> <p>Одоогийн байдлаар ИНЕГ нь дээр дурдсанаас 3, 9, 10, 11-д тусгагдсан өгөгдөл, мэдээллийн ГЗБГЗЗГ-аас авсан. Бусад өгөгдөл мэдээллийг авч чадаагүй байна.</p> | |
| <p>Бусад санал</p> | <p>Монгол улс нь 1989 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенцод нэгдэн орсон бөгөөд түүний Хавсралтуудад заасан стандарт, шаардлагуудад нийцүүлэн Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй нислэгийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах үүрэг хүлээдэг. Чикагогийн конвенцын Хавсралтуудад олон улсын агаарын навигацид ашиглагдах газар зүйн болон орон зайн өгөгдөл/мэдээллийн шаардлагыг нарийвчлан тусгаж өгсөн байдаг бөгөөд зарим шаардлагууд нь геодези, зураг зүйн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан Монгол улсын стандарт, дүрэм, журам, тогтоолын шаардлагуудаас зөрүүтэй байдаг.</p> <p>Жишээлбэл, Олон Улсын агаарын навигацид EGM-96 геоидын загварын өндрийн мэдээллийг ашиглах шаардлага тавьсан байдаг. Гэвч Монгол улсын засгийн газрын тогтоол Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх геодезийн хэмжил зураглалын ажилд Балтын тэнгисийн өндрийн тогтолцоог ашиглана гэж заасан байдаг. Энэ зөрүүтэй байдлаас шалтгаалж ГЗБГЗЗГ-аас гаргаж буй Балтын тэнгисийн тогтолцоонд илэрхийлэгдсэн нийтийн хэрэгцээнд зориулагдсан газрын зургуудын өндрийн мэдээлэл нь ИНЕГ-ын бүрдүүлсэн газрын гадарга болон саадын өгөгдлийн сангийн өндрийн мэдээллээс зөрдөг тул нисэхийн мэргэжилтнүүдийн дунд байнга маргаан дагуулсан. Энэхүү асуудалд Геодези, зураг зүйн тухай хуулийн 5.4.5-д заасны дагуу Геодези,</p> | <p>Санал байхгүй</p> |

| | | |
|--|--|--|
| | <p>зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас арга хэмжээ авах шаардлагатай. ГЗБГЗЗГ нь орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотойгоор ИНЕГ-аас хүргүүлсэн 2016 оны 02 дугаар сарын 22-ны 08/в-46 болон 2016 оны 10 дугаар сарын 25-ны 08/в-267 дугаар албан бичгийн хариуг одоо хүртэл ирүүлээгүй байна. Төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу албан бичгийн хариуг өгөхөд анхаарал хандуулахыг хүсэж байна.</p> | |
|--|--|--|

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн хоёрдугаар хавсралт

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Асуудлыг шийдвэрлэх зорилгууд

A. Суурь орон зайн өгөгдөл, мэдээллийн ангиллыг тодорхой болгох, тэдгээрийг бүрдүүлэгч байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг оролцоог сайжруулах замаар орон зайн өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийн давхардлыг арилгах,

B. Орон зайн өгөгдөл, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, боловсруулалт, хадгалалт, хамгаалалт, түгээлт, хэрэглээний стандартын нэгдсэн тогтолцоо бий болгох замаар баталгаатай, шинэлэг, чанартай орон зайн мэдээллийг шуурхай, хялбар хайх, солилцох, хэрэглэх, түгээх боломжийг бүрдүүлэх,

C. Орон зайн өгөгдөл, мэдээллийг түгээх, ашиглах, солилцох зэрэг үйл ажиллагааны явцад үүсэх бүрдүүлэгч, хэрэглэгчийн үүрэг, хариуцлага, эрх, нөхцөл, хязгаарлалтын (лицензийн) асуудлыг тодорхой болгох замаар орон зайн мэдээлэлд нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг өргөжүүлэх судалгаа-хөгжил, инновац, бизнесийн орчныг дэмжих,

D. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд оролцогч, хамтрагч байгууллагуудын эрх, үүрэг, оролцоог тодорхой болгох, тэдгээрийг нэгдсэн удирдлагаар зохицуулах замаар бүх салбарт орон зайн мэдээллийн үр дүнтэй хэрэглээг нэмэгдүүлэх.

Судалгаанд ашигласан материалуудыг дараах эх сурвалжаас авсан болно. Нэгдсэн Үндэсний байгууллагын Орон зайн мэдээллийн менежментийг хорооны цахим хуудас: <http://ggim.un.org/knowledgebase/KnowledgebaseCategory20.aspx>

| Улсын нэр | Эрх зүйн зохицуулалтын нэр | Бүлэг, зүйл | Хамрах хүрээ, агуулга | Зорилго А | Зорилго В | Зорилго С | Зорилго D |
|-----------|---|-------------|--|--|---|---|---|
| АНУ | Ерөнхийлөгчийн Зарлиг 12906, 1994.04.11 Ерөнхийлөгчийн | - | Ерөнхийлөгчийн Зарлигаар ОЗӨДБ гэж юу болохыг тогтоосон ба | Захирамж А-16-аар Холбооны Газарзүйн Мэдээллийн Хороог байгуулсан. | Бүх төрийн байгууллагуудыг өөрсдийн бүрдүүлж, | ХГМХ-г холбогдох шатны төрийн байгууллагуудтай хамтран Үндэсний | Захирамж А-16-д орон зайн суурь өгөгдөл, мэдээллийн |

| | | | | | | | |
|----------------|---|------------------------------|--|---|--|---|--|
| | Зарлиг 13286, 2003.03.05 /шинэчилсэн найруулга/ Захирамж А-16 “Газарзүйн мэдээлэл болон холбогдох орон зайн өгөгдлийн үйл ажиллагааны зохицуулалт” | | Үндэсний орон зайн өгөгдлийн клирингхаусыг байгуулах, Өгөгдлийн стандартын асуудал, тоон өгөгдлийн хамрах хүрээ, өгөгдөл, мэдээлэл бүрдүүлэх хамтын ажиллагаа зэргийг зарчмын хувьд тогтоосон. Холбооны Газарзүйн Мэдээллийн Хороог ҮОЗӨДБ байгуулахад гол зохицуулалт, уялдааг хангуулахыг заасан байдаг. | Захирамж А-16-д дурдсан өгөгдөл, мэдээллийн бүрдүүлэлтийг тодорхой хугацаа заан бүрдүүлж дуусгахыг заасан. <i>Зарлиг-Хэсэг.5</i> Захирамж А-16-д орон зайн суурь өгөгдөл, мэдээллийн ангилал, тэдгээрийн бүрдүүлэгч нарыг тодорхой зааж өгсөн байдаг. | боловсруулж буй орон зайн шинэ өгөгдлүүдийг 9 сарын хугацаанд Холбооны Газарзүйн Мэдээллийн Хороо /ХГМХ/-ноос баталсан стандартуудын дагуу стандартжуулахыг заасан. <i>Зарлиг-Хэсэг.3b</i> | орон зайн өгөгдлийн цахим клирингхаусыг байгуулахыг даалгасан байдаг <i>Зарлиг-Хэсэг.3a</i> | ангилал, тэдгээрийн бүрдүүлэгч нарыг тодорхой зааж өгсөн. Холбооны дотоод хэргийн албанд ОЗӨДБ байгуулахтай холбогдон гарах зардлаар хангахыг үүрэгжүүлсэн. <i>Зарлиг-Хэсэг.3e</i> |
| Европын холбоо | INSPIRE Тогтоол, 2007.03.14 | 7 бүлэг, 26 зүйл, 3 хавсралт | INSPIRE нь гишүүн орнуудын хоорондын уялдааг хангах бодлого тодорхойлоход дэмжлэг үзүүлэх үүрэгтэй ба дараах нийтлэг зарчмуудыг баримталдаг: | INSPIRE нь 34 чухал ач холбогдолтой орон зайн мэдээллийн төрлийг 3 бүлэгт хуваан гаргасан байна /Тогтоолын хавсралт/ Тус 34 ангилал бүрийн шинэчлэх хугацаа, мета-өгөгдлийг | Европын хамтын ажиллагааны газарзүйн мэдээллийн портал болох INSPIRE нь ISO, CEN, OGC, W3C зэрэг олон улсын стандартыг бий болгосон байна. | INSPIRE Тогтоолд эдгээр гишүүн орнуудын дэд бүтцийг холбосон Европын хороогоор удирдуулсан ЕХ-ны геопорталыг байгуулахыг шаардсан байдаг. | Европын орнууд тус тусдаа 27 төрлийн дэд бүтэцтэй байх нь мэдээжийн хэрэг төвөгтэй тогтолцоо бөгөөд үүнийг шийдвэрлэхийн тулд INSPIRE нь |

| | | | | | | | |
|--|--|--|---|---|--|--|--|
| | | | <ul style="list-style-type: none"> • Өгөгдөл, мэдээлэл нь зөвхөн нэг удаа цуглуулж, түүнийг үр ашигтайгаар хэрэглэх, тордох тохиромжтой газарт хадгалагдах, • Европын улс хоорондын хил дамнасан төрөл бүрийн эх сурвалжаас үүсэлтэй орон зайн мэдээлэл нь ямар ч зүйдэлгүйгээр нэгтгэгддэг, бүх төрлийн хэрэглээнд болон хэрэглэгчид хүртэж хэрэглэдэг байх, • Нэг нарийвчлал, масштабаар цуглуулагдсан | <p>бүрдүүлэлт, хөгжүүлэлт зэргийг зааж өгсөн. Хавсралт I</p> <ol style="list-style-type: none"> 1.Солбицлын тогтолцоонууд 2.Газар зүйн торлолын систем 3.Газар зүйн нэр 4.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж 5.Хаяг 6.Кадастрын нэгж талбарууд 7.Авто замын шугам сүлжээ 8.Ус зүй 9.Тусгай хамгаалалтын газар нутаг <p>Хавсралт II</p> <ol style="list-style-type: none"> 10.Өндрийн зураг 11.Газрын бүрхэвч 12.Орто зураг 13.Геологи гэх мэт | <p>Мөн INSPIRE-т шууд өгөгдөл хадгалах эсвэл удирддаггүй бөгөөд улс тус бүрийн портал болон сэдэв, бүлэг, тусгай өгөгдөл болон үйлчилгээтэй уялдаа холбоотой ажилладаг тогтолцоо юм.</p> | <p>Сервер тус бүрийг өгөгдөл хариуцсан байгууллагууд удирдах бөгөөд сервер болон өгөгдөлд холбогдсон INSPIRE портал мета өгөгдөлд хандан, хэрэглэгч хүссэн газарзүйн мэдээллийг хайх боломжтой. Олон нийтэд зориулагдсан өгөгдөл нь дотоодын бодлогын чанартай хадгалалт (retaining) болон чөлөөтэй хандах боломжтой мэдээлэл хуваалцах (sharing), гадаад дотоодод ашиглагдах худалдааны (trading) өгөгдөл гэж гурав хуваагддаг.</p> | <p>дэд түвшний эрх зүйн орчин бүхий журмыг бий болгосон юм. Мета-өгөгдөл, орон зайн мэдээлэл, түүний үйлчилгээний зохицуулалт, сүлжээ, хамтран хэрэглэх бодлогууд, хянах, тайлагнах үзүүлэлтүүдийн техникийн гүйцэтгэлүүдийн дүрмүүдийг журам хэлбэрээр баталсан байна. Эдгээр журмуудыг гишүүн орнуудын болон Европын парламент баталдаг.</p> |
|--|--|--|---|---|--|--|--|

| | | | | | | | |
|--|--|--|---|--|--|--|--|
| | | | <p>мэдээлэл нь төрөл бүрийн нарийвчлал, масштабаар хэрэглэгчдэд хүрэх боломжтой байх,</p> <ul style="list-style-type: none">• Бүх түвшний сайн засаглал бий болгоход хэрэгтэй газар зүйн мэдээлэл нь ил тод, түргэн шуурхай байх,• Ямар газар зүйн мэдээлэл бэлэн байгаа, тодорхой хэрэгцээнд хэрхэн хэрэглэгдэх, ямар нөхцөл, шаардлагын дагуу хэрэглэж болох зэрэг мэдээллүүд нь олоход хялбар байх зэрэг болно. | | | | |
|--|--|--|---|--|--|--|--|

| | | | | | | | |
|---------|---|-------------------|--|---|---|---|--|
| Индонез | Орон зайн мэдээллийн тухай хууль, 2011 | 12 бүлэг, 71 зүйл | Геодези, зурагзүйн үйл ажиллагаа, орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагааг хамтад нь хуульчилсан. Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаа /бүрдүүлэх, боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх, хэрэглэх/ тус бүрээр зүйлчлэн заасан. | Хуулийн 4 дүгээр зүйлд орон зайн мэдээллийг суурь, сэдэвчилсэн байна гэж заасан ба суурь орон зайн мэдээллийг нэг бүрчлэн хуульчлан ангилсан бол сэдэвчилсэн мэдээллийг суурь мэдээлэлтэй уялдсан төрөл бүрийн мэдээлэл байхаар заасан. 5, 12, 19 дүгээр зүйл | 17 дугаар зүйл: Суурь мэдээллийг шинэчлэх стандарт, нормтой байна. 27 дугаар зүйл: орон зайн өгөгдлийг бүрдүүлэх үйл явц стандарттай байна. Түүнчлэн орон зайн өгөгдлийг боловсруулах, хадгалах, хамгаалах, түгээх зэрэг нь тодорхой стандартын дагуу явагдана гэдгийг заасан. 27, 34, 38 дугаар зүйл | 53 дугаар зүйл: ҮОЗӨДБ байгуулах ажилд дэмжлэг үзүүлж, зохицуулалтаар хангаж ажиллахыг засгийн газарт заасан байдаг | ҮОЗӨДБ-ийн үйл ажиллагаанд оролцож буй засгийн газар, хуулийн этгээд, хариуцагч агентлаг, иргэний үүрэг, эрх, хязгаарлалтыг зохицуулсан. |
| Япон | Орон зайн мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэх ерөнхий хууль 2007.05.30 | 3 бүлэг, 21 зүйл | Үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах, оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа, эрх үүрэг оролцоог зохицуулсан | Орон зайн суурь өгөгдөл гэж ямар өгөгдлийг хэлэхийг тодорхойлсон ба Газар, дэд бүтэц, Тээвэр, аялал жуулчлалыг яамыг ангилал зэрэглэлийг тодорхойлохыг заасан /Хуулийн 2,3 дугаар зүйл / | Засгийн газрыг орон зайн суурь өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой техникийн стандартаар хангахыг үүрэгжүүлсэн /Хуулийн 2 дугаар | Засгийн газар болон доод түвшний байгууллагууд бүрдүүлсэн орон зайн суурь өгөгдөл мэдээллийн хэрэглээг нэмэгдүүлэхэд бүхий л хүчээ дайчлан ажиллах талаар хуульчилсан | Хуулийн 3 дугаар зүйлд орон зайн өгөгдлийн дэд бүтцийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн 9 зарчмыг заасан ба Засгийн газар, бүх шатны |

| | | | | | | | |
|-------|---|-----------------|---|--|---|--|--|
| | | | | Тус яамнаас 2007 оны 8 сарын 29-нд энэхүү суурь өгөгдөл мэдээллийн ангиллыг батлан гаргасан. Нийт 11 мэдээллийн ангиллыг баталсан байх ба эдгээрийг бүрдүүлэхэд баримтлах зарчмыг байрлалын нарийвчлалын хамт тодорхойлсон /Тогтоолын 1,2,3 дугаар зүйл/ | хэсэг 16 дугаар зүйл/ | /Хуулийн 17-19 дүгээр зүйл/ | төрийн байгууллага, хуулийн этгээдийг дээр дурдсан зарчмуудыг баримтлах замаар үйл ажиллагаа явуулахыг заасан. |
| БНХАУ | БНХАУ-ын хэмжил, зураглалын тухай хууль 1992.12.28 2002.08.29 | 9 бүлэг 55 зүйл | БНХАУ-ын Хэмжил, зураглалын тухай хуулиар Хятадад хэмжил, зураглал, геомэдээллийн үйл ажиллагааг зохицуулдаг. Үүнээс гадна удирдлага зохион байгуулалтын 4 журам, орон нутгийн 35 журам, 6 албаны болон 74 орон нутгийн засаг захиргааны дүрэм нь хууль эрх зүйн орчныг бүрдүүлдэг байна. | Нэн ач холбогдолтой орон зайн өгөгдөл, мэдээллийг 5 ангиллаар заасан ба эдгээр мэдээллийг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр түгээхийг хориглосон /Журмын 4 дүгээр бүлэг/ | Хэмжил зураглал, орон зайн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааг Улсын стандартуудад нийцүүлнэ гэж заасан | 2010 онд БНХАУ-ын Хэмжил зураглал, геомэдээллийн агентлаг нь хуульдаа үндэслэн хэмжил зураглал, геомэдээллийн стратегийг хөгжүүлэх судалгаа явуулсан байна. Гол стратеги нь “Тоон Хятад болохын тулд Гео-орон зайн суурь мэдээллийг бүрдүүлэх, үндэсний газарзүйн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх, геоматикийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хятад улсыг геоматикийн тэргүүлэх улс болгох” гэсэн дараагийн шатны стратегийн үндсэн чиглэл, зорилго, зорилтуудыг тодорхойлсон. БНХАУ-ын Үндэсний геопортал нь геомэдээллийн нэг цэгийн үйлчилгээний платформ бөгөөд үндэсний, бүсийн, мужийн болон орон нутгийн газарзүйн мэдээллийн нөөцийг улс орны хэмжээнд | |

| | | | | | | | |
|------|---|------------------|--|--|--|---|---|
| | | | Хэмжил, зураглалын үр дүнг зохион байгуулах журмаар орон зайн өгөгдөл, мэдээллийн боловсруулалт, түгээлтийн асуудлыг зохицуулсан байдаг. | | | нэгтгэж өгдөг. Платформ нь 1 гол зангилаа холбоос, 31 хэсэгчилсэн зангилаа холбоос болон 333 мэдээллийн сангаас бүрддэг ба эдгээр платформын бүрэлдэхүүн хэсгүүд нь хятадын Үндэсний Геоматикийн төв, мужийн болон хотын Геоматикийн төвөөс мөн адил хамаарч, удирдан зохион байгуулагддаг. Map World (http://www.tianditu.cn) веб сайт нь олон нийтэд зориулагдсан геомэдээллийн платформ болж, 2011 оны 1 дүгээр сараас ажиллаж байна. 2012 оны байдлаар 15 мужийн зангилаа холбоос болон 9 хотын зангилаа холбоос нь гол зангилаа холбоост холбогдсон болно. Засгийн газрын агентлаг, үйлдвэрлэл болон хувь хүн Map World-ийг ачаалах, үзэх, байршилд тулгуурласан мэдээллийг хайх, тодорхой асуулгаар хайлт хийх, мөн хэмжилт хийх болон өөрсдийн маршрутыг төлөвлөх маягаар ашиглаж болно | |
| БНСУ | Үндэсний газар зүйн мэдээллийн системийг байгуулах, ашиглах тухай хууль, 2002 Үндэсний орон зайн мэдээллийн дэд | 6 бүлэг, 33 зүйл | 1) Нийтлэг зүйл 2) ҮОЗӨДБ-ийг дэмжих 3) Үндэсний орон зайн суурь өгөгдөл бүрдүүлэлт | Байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагаа, үүрэг оролцоог Үндэсний орон зайн өгөгдлийн хороог байгуулах замаар шийдвэрлэсэн /Хуулийн 2 дугаар бүлгийн 4 дүгээр зүйл/ Хуулиар тус хорооны | Орон зайн өгөгдөлтэй холбоотой стандартыг Үндэсний стандартын актаар зохицуулах болон орон зайн өгөгдөл, | Орон зайн өгөгдөл, мэдээллийг цуглуулах, бүрдүүлэх, боловсруулах зорилго бүхий Үндэсний орон зайн өгөгдлийн төвийг Газар, тээврийн яамны харьяа | Газар, тээврийн яамыг Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн гол хариуцагч байгууллага байхаар үүрэгжүүлж зохион байгуулалт, |

| | | | | | | | |
|--|--|--|---|---|--|--|--|
| | <p>бүтцийн хууль, 2009.02.06 Орон зайн мэдээллийн салбарыг дэмжих тухай 2010.10.03</p> | | <p>4) ҮОЗӨДБ-ийг байгуулах, хэрэглэх 5) Үндэсний орон зайн өгөгдлийн хамгаалалт 6) Хариуцлага хүлээлгэх</p> | <p>эрхлэх асуудлыг зааж өгсөн. Хуулиар Газар, тээврийн яамыг суурь орон зайн өгөгдлийн ангиллыг тодорхойлохыг үүрэг болгосон ба тус суурь өгөгдлүүдэд юу хамаарахыг хуулийн заалтаар оруулсан. Үүнд: байр зүй, хил, авто зам төмөр замын бүсүүд, гол гэх мэт /Хуулийн 3 дугаар бүлэг, 12 дугаар зүйл/</p> | <p>мэдээллийг бүрдүүлэгч байгууллагууд нь техникийн стандарт боловсруулж болохыг заасан /Хуулийн 3 дугаар бүлэг 14 дүгээр зүйл/ БНСУ нь 2011 оны байдлаар орон зайн өгөгдлийн 140 стандарттай. Стандарттай холбоотой судалгаа хөгжлийг дамжсан заалттай /Хуулийн 15 дүгээр зүйл/</p> | <p>байгуулна гэж заасан. Тус Төвийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Ерөнхийлөгчийн зарлигаар зохицуулна. /Хуулийн 18 дугаар зүйл/ Орон зайн өгөгдөл бүрдүүлдэг бүх шатны төрийн байгууллага өөрсдийн бүрдүүлж буй орон зайн өгөгдөл, мэдээллээр өгөгдлийн сан байгуулахыг үүрэгжүүлсэн /Хуулийн 21 дүгээр зүйл/ Мөн давхардсан зардлаас сэргийлсэн заалтыг оруулсан /Хуулийн 22 дугаар зүйл/</p> | <p>хэрэгжүүлэлтийн асуудлыг Үндэсний хороо ажиллах замаар байгууллагуудын уялдаа холбоог хангасан.</p> |
|--|--|--|---|---|--|--|--|

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн гуравдугаар хавсралт

ОРОН ЗАЙН СУУРЬ ӨГӨГДЛИЙН АНГИЛЛЫН ОЛОН УЛСЫН СУДАЛГАА

Хүснэгт 6 INSPIRE 34 чухал ач холбогдолтой орон зайн мэдээллийн төрөл

| | Хавсралт-1 | Annex I |
|-----|---|---|
| 1. | Солбицлын тогтолцоонууд | I.1 Coordinate reference systems |
| 2. | Газар зүйн торлолын систем | I.2 Geographical grid systems |
| 3. | Газар зүйн нэр | I.3 Geographical names |
| 4. | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж | I.4 Administrative units |
| 5. | Хаяг | I.5 Addresses |
| 6. | Кадастрын нэгж талбарууд | I.6 Cadastral parcels |
| 7. | Авто замын шугам сүлжээ | I.7 Transport networks |
| 8. | Ус зүй | I.8 Hydrography |
| 9. | Тусгай хамгаалалтын газар нутаг | I.9 Protected sites |
| | Хавсралт-2 | Annex II |
| 10. | Өндрийн зураг | II.1 Elevation |
| 11. | Газрын бүрхэвч | II.2 Land cover |
| 12. | Орто зураг | II.3 Orthoimagery |
| 13. | Геологи | II.4 Geology |
| | Хавсралт-3 | Annex III |
| 14. | Статистикийн мэдээ | III.1 Statistical units |
| 15. | Барилга, байгууламж | III.2 Buildings |
| 16. | Хөрс | III.3 Soil |
| 17. | Газар ашиглалт | III.4 Land use |
| 18. | Эрүүл ахуй, аюулгүй байдал | III.5 Human health and safety |
| 19. | Нийтийн аж ахуйн болон төрийн үйлчилгээ | III.6 Utility and Government services |
| 20. | Хүрээлэн буй орчны мониторингийн байгууламж | III.7 Environmental monitoring facilities |
| 21. | Бүтээгдэхүүн болон үйлдвэрлэлийн байгууламж | III.8 Production and industrial facilities |
| 22. | Хөдөө аж ахуй болон тариалангийн байгууламж | III.9 Agricultural and aquaculture facilities |
| 23. | Хүн амын нутагшил, суурьшил | III.10 Population distribution – demography |
| 24. | Газар нутгийн менежмент /хязгаарлалт, бүсийн зохицуулалт, тайлангийн нэгж | III.11 Area management / restriction / regulation zones & reporting units |
| 25. | Байгалийн эрсдэлийн бүс | III.12 Natural risk zones |
| 26. | Агаарын давхаргын нөхцөл байдал | III.13 Atmospheric conditions |
| 27. | Ус цаг уурын газар зүйн онцлогууд | III.14 Meteorological geographical features |

| | | |
|-----|------------------------------------|--|
| 28. | Далайн газар зүйн онцлогууд | III.15 Oceanographic geographical features |
| 29. | Тэнгисийн бүс нутаг | III.16 Sea regions |
| 30. | Био-газар зүйн бүс нутаг | III.17 Bio-geographical regions |
| 31. | Газар нутаг, биотоп | III.18 Habitats and biotopes |
| 32. | Төрөл зүйлийн тархалт | III.19 Species distribution |
| 33. | Эрчим хүчний нөөц | III.20 Energy resources |
| 34. | Ашигт малтмал, эрдэс баялгийн нөөц | III.21 Mineral resources |

Хүснэгт 7 INSPIRE үндсэн мэдээллийн ангилал

| | | | | |
|----|--|---|--|--|
| 1. | Газар зүйн байрлал | Солбицлын тогтолцоо | 1. Geographical location | 1.1 Geographical reference systems |
| | | Газар зүйн нэр | | 1.2 Geographical names |
| | | Газар зүйн торлол | | 1.3 Geographical grids |
| 2. | Засаг захиргааны нэгж | Албан ёсны засаг захиргааны нэгж | 2. Administrative units | 2.1 Official administrative units |
| | | Засгийн газрын менежментийн бүсүүд | | 2.2 Government management zones |
| | | Блок болон статистикийн дүүргүүд/нэгжүүд | | 2.3 Blocks, census and statistical districts |
| | | Төрийн хамгаалалтын нэгж/талбай | | 2.4 Civil security units |
| | | Хүрээлэн буй орчны менежментийн нэгж/талбай | | 2.5 Environment management & reporting units |
| | | Шуудангийн код/бүс | | 2.6 Postal codes/regions |
| 3. | Үл хөдлөх хөрөнгө, байшин барилга, хаяг | Үл хөдлөх хөрөнгө | 3. Properties, buildings and addresses | 3.1 Properties |
| | | Барилга, байшин | | 3.2 Buildings |
| | | Хаяг | | 3.3 Addresses |
| 4. | Өндөр | Газрын гадаргуугийн өндөршил | 4. Elevation | 4.1 Terrestrial elevation |
| | | Гүний усны хэмжилт | | 4.2 Bathymetry |
| | | Далайн эрэг | | 4.3 Coastline |
| 5. | Гео-физикийн орчин | Хөрс | 5. Geo-physical environment | 5.1 Soil |
| | | Үндсэн чулуулгийн геологи | | 5.2 Bedrock geology |
| | | Гео-морфологи | | 5.3 Geo-morphology |

| | | | | |
|-----|------------------------------------|---|------------------------------|---|
| 6. | Газрын гадарга | Газрын бүрхэвч | 6. Land surface | 6.1 Land cover |
| | | Ортофото зураг | | 6.2 Orthophoto-images |
| 7. | Тээвэр | Тээврийн сүлжээ | 7. Transport | 7.1 Transport networks |
| | | Тээврийн үйлчилгээ | | 7.2 Transport services |
| 8. | Тоног төхөөрөмж, байгууламж | Дамжуулагч шугам, хоолой | 8. Utilities and facilities | 8.1 Transmission lines and pipelines |
| | | Хүрээлэн буй орчныг хамгаалах байгууламж, тоног төхөөрөмж | | 8.2 Environmental protection facilities |
| | | Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, аж үйлдвэр | | 8.3 Production facilities, industry |
| | | Хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж | | 8.4 Agricultural facilities |
| | | Худалдаа, үйлчилгээний тоног төхөөрөмж | | 8.5 Trade and service facilities |
| 9. | Нийгэм, хүн ам | Хотын болон хөдөө орон нутгийн суурьшил | 9. Society and population | 9.1 Urban and rural settlement |
| | | Хүн амын тархалт, хүн ам зүй | | 9.2 Population distribution-demography |
| | | Хүн амын эрүүл мэнд, хамгаалал | | 9.3 Human health and safety |
| | | Соёлын өв | | 9.4 Cultural heritage |
| | | Байгалийн таатаа нөхцөл | | 9.5 Natural amenities |
| 10. | Талбайн зохицуулалт | Газар ашиглалтын төлөвлөгөө | 10. Area regulation | 10.1 Land use plans |
| | | Тусгай хамгаалалттай газар нутаг | | 10.2 Protected sites |
| | | Хориотой бүс нутаг | | 10.3 Area restriction/regulation zones |
| 11. | Агаар, уур амьсгал | Агаар, агаар мандлын нөхцөл | 11. Air and climate | 11.1 Air and atmospheric conditions |
| | | Цаг уурын орон зайн биетүүд | | 11.2 Meteorological spatial features |
| | | Уур амьсгалын бүс | | 11.3 Climate zones |
| 12. | Усан гадаргуу/Ус зүй | Гадаргын ус, ус зүйн сүлжээ | 12. Water bodies/Hydrography | 12.1 Surface water bodies/ |

| | | | | |
|-----|--|-------------------------------------|-------------------------------------|--|
| | | | | Hydrography networks |
| | | Усан бассейн | | 12.2 Water catchments |
| | | Гүний ус, усархаг давхраа | | 12.3 Groundwater bodies/aquifers |
| 13. | Далай, тэнгис | Далайн орон зайн биет | 13. Ocean and seas | 13.1 Oceanographic spatial features |
| | | Тэнгисийн бүс | | 13.2 Sea regions |
| 14. | Ургамлын аймаг/биологийн төрөл зүйл | Био-газарзүйн бүс | 14. Biota/biodiversity | 14.1 Bio-geographical regions |
| | | Ургамал, ногоо | | 14.2 Vegetation |
| | | Амьдрах орчин, биотоп | | 14.3 Habitats and biotopes |
| | | Төрөл зүйлийн тархалт | | 14.4 Species distribution |
| | | Газар нутгийн өвөрмөц шинж | | 14.5 Landscape diversity |
| 15. | Байгалийн нөөц | Экосистемийн нөөц | 15. Natural resource | 15.1 Ecosystem resources |
| | | Усны нөөц | | 15.2 Water resources |
| | | Хөдөө аж ахуйн газар, хөрсний нөөц | | 15.3 Agricultural land and soil resources |
| | | Ойн нөөц | | 15.4 Forest resources |
| | | Загасны нөөц | | 15.5 Fishery resources |
| | | Геологийн нөөц | | 15.6 Geological resources |
| | | Эрчим хүчний сэргээгдэх нөөц | | 15.7 Renewable energy resources |
| 16. | Байгалийн болон технологийн эрсдэл | Байгалийн эрсдэлд өртөмтгий бүс | 16. Natural and technological risks | 16.1 Natural risk vulnerability zones |
| | | Технологийн эрсдэлд өртөмтгий бүс | | 16.2 Technological risk vulnerability zones |
| | | Технологийн осол, байгалийн гамшиг | | 16.3 Technological accidents and natural disasters |
| 17. | Хүний үйл ажиллагааны | Бохирдсон газар | 17.Areas under anthropogenic stress | 17.1 Polluted areas |
| | | Дуу шуугиан болон цацраг идэвхт бүс | | 17.2 Noise and radiation zones |

| | | | |
|--|-------------------------------|----------------|--------------------------------------|
| | нөлөөлөлд орсон талбай | Эвдэрсэн газар | 17.3 Areas of intensive exploitation |
|--|-------------------------------|----------------|--------------------------------------|

Хүснэгт 8 Шинэ Зеланд Улсын суурь орон зайн мэдээллийн дэлгэрэнгүй ангилал

| № | Үндсэн ангилал | Дэд ангилал | Суурь өгөгдлийн багцууд /жишээ/ |
|----|--------------------------------|---------------------|--|
| 1. | Байрлал | | Цэг тэмдэгтийн мэдээлэл |
| | | | Цэг, тэмдэгтийн солбицол |
| | | | Геодезийн хэмжилт |
| | | | GNSS байнгын ажиллагаатай станц |
| | | | Гажилтын Загвар |
| | | | Геоидийн загвар |
| 2. | Кадастр, үл хөдлөх хөрөнгө | | Тоон нэгж талбар |
| | | | Кадастр, хэмжилтийн мэдээлэл |
| | | | Эрхийн бүртгэл |
| | | | Үнэлгээ |
| | | | Барилгын дэвсгэр зураг |
| | | | Дэд нэгж талбар |
| | | | Төрийн өмчийн газар |
| | | | Фермийн хил хязгаар |
| 3. | Хаяг | | Нэрлэж өгсөн хаяг |
| | | | Шуудангийн хаяг |
| | | | Газар дээр байрлуулсан хаяг |
| | | | Шуудангийн кодын хил |
| 4. | Агаар, сансрын зураг | | Ортофото зураг, хөдөө орон нутгийн масштабтай |
| | | | Ортофотозураг, хот суурин газрын масштабтай |
| | | | Олон сувгийн зураг, радарын зураг |
| 5. | Газар ашиглалт, газрын бүрхэвч | Газар ашиглалт | Газар ашиглалт, төлөвлөлтийн бүс |
| | | | Хашаа |
| | | | Цахилгааны сүлжээ, нийтийн үйлчилгээний бусад сүлжээ |
| | | | Бохирдсон газар |
| | | Газрын бүрхэвч | Бусад онцлог газрууд /оршуулгын гэх мэт/ ойн |
| | | | Хамгаалалтын газар |
| | | | Ургамлын бүрхэвч |
| | | | Газрын бүрхэвчийн мэдээллийн сан |
| | | | Газрын хүрээлэн буй орчин |
| | | | 1:50000 масштаб бүхий байр зүйн растер зураг |
| | | | 1:250000 масштаб бүхий байр зүйн растер зураг |
| | | | Газар ашиглалтын зураг |
| | | Байгалийн онцлогууд | Хад, цохио |
| | | | Агуй |
| | | | Мөстлөг |
| | | | Геологи |

| | | | |
|----|-----------------------|----------------|----------|
| | | | Хөрс |
| | | | Усан нүх |
| 6. | Газар зүйн нэр | - | - |
| 7. | Засаг захиргааны нэгж | - | - |
| 8. | Өндөр, гүн | Өндөр | - |
| | | Гүн | - |
| 9. | Тээвэр | Авто зам | - |
| | | Төмөр зам | - |
| | | Агаарын зам | - |
| | | Усан зам | - |
| 10 | Ус | Эрэг дагуу | - |
| | | Эх газар дээрх | - |
| | | Эргээс хол | - |

Хүснэгт 9 ISO 19115 стандартад заасан мэдээллийн төрөл

| | | | | |
|----|------------------------------------|---|--|--|
| 1. | Ферм | Ан амьтан үржүүлэг, ногоо тарилт | 1. Farming | Rearing of animals and/or cultivation of plants. |
| 2. | Биотоп | Байгаль орчин дах амьтны, ургамлын аймаг | 2. Biota | Flora and/or fauna in natural environment |
| 3. | Хил зааг | | 3. Boundaries | Legal land descriptions |
| 4. | Цаг уур, уур амьсгал, агаар мандал | Агаар мандлын үйл явц, үзэгдэл | 4. Climatology / Meteorology / Atmosphere | Processes and phenomena of the atmosphere |
| 5. | Эдийн засаг | Эдийн засгийн үйл ажиллагаа, нөхцөл, хөдөлмөр эрхлэлт | 5. Economy | Economic activities, conditions and employment |
| 6. | Өндөр | Далайн төвшний гадаргаас дээш доош өндөр | 6. Elevation | Height above or below sea level |
| 7. | Хүрээлэн буй орчин | Хүрээлэн буй орчны нөөц, хамгаалалт, хадгалалт | 7. Environment | Environmental resources, protection and conservation |
| 8. | Гео шинжлэх ухааны мэдээлэл | Дэлхий судлалтай холбоотой мэдээлэл | 8. Geoscientific Information | Information pertaining to earth sciences |
| 9. | Эрүүл мэнд | Эрүүл мэнд, үйлчилгээ, хүний экологи, аюулгүй байдал | 9. Health | Health, health services, human ecology, and safety |

| | | | | |
|-----|--------------------------------------|--|--|--|
| 10. | Суурь, газрын зураг, дэлхийн бүрхэвч | Суурь газрын зураг | 10. Imagery Base Maps / Earth Cover | Base maps |
| 11. | Тагнуул, цэрэг | Цэргийн анги, бүтэц, үйл ажиллагаа | 11. Intelligence / Military | Military bases, structures, activities |
| 12. | Ус | | 12. Inland Waters | |
| 13. | Байрлал | Байрлалд суурилсан мэдээлэл, үйлчилгээ | 13. Location | Positional information and services |
| 14. | Далай | Давстай усны онцлогууд /нуураас бусад/ | 14. Oceans | Features and characteristics of salt water bodies (excluding inland waters) |
| 15. | Төлөвлөлт / кадастр | Газар ашиглалтын төлөвлөгөөнд холбогдох мэдээлэл | 15. Planning / Cadastre | Information used for appropriate actions for future use of the land |
| 16. | Байгууламж | Хүний гараас бүрдсэн барилга байгууламж | 17. Structure | Man-made construction |
| 17. | Тээвэр | Хүн болон бараа таваар зөөх зориулалт бүхий бүх төрлийн хэрэгсэл | 18. Transportation | Means and aids for conveying persons and/or goods |
| 18. | Харилцаа холбоо, сүлжээ | Цахилгаан ус, хаягдалын систем, харилцаа холбооны дэд бүтэц, үйлчилгээ | 19. Utilities / Communication | Energy, water and waste systems and communications infrastructure and services |

Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлангийн дөрөвдүгээр хавсралт

ОРОН ЗАЙН МЭДЭЭЛЛИЙН СУУРЬ 18 ӨГӨГДЛИЙН ХҮРЭЭ

| Д/д | Таних тэмдэг | Суурь орон зайн өгөгдөл | Тодорхойлолт |
|-----|---|-------------------------------|---|
